

**ХҮНИЙ ЭРХ  
ХАМГААЛАГЧДЫГ  
ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ,  
ХАМГААЛАХ ТУХАЙ  
ЗАГВАР ХУУЛЬ**

## ОРЧУУЛГЫН ТУХАЙД

Энэхүү Загвар хуулийг одоогоор гурван хэлээр (англи, франц, испани) орчуулаад байна. ISHR нь энэхүү баримт бичгийг бусад хэл рүү орчуулахыг талархан хүлээн авна. Гагцхүү та энэхүү баримт бичгийг орчуулах буюу орчуулгын ажилд оролцохоор төлөвлөж байгаа бол мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлыг хангахын тулд бидэнтэй урьдчилан холбоо барина уу.

Энэхүү хувилбарыг 2017 оны 1 дүгээр сард хэвлэсэн.

Шинэчилсэн мэдээллийг [www.ishr.ch](http://www.ishr.ch) хаягаар орж авна уу.

## ЗАГВАР ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА, ЗОРИЛТ

Энэхүү Загвар хууль нь улс орнууд болон бусад оролцогчдод Нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхүүлэн дэмжих, хамгаалах талаар хувь хүн болон нийгмийн бүлэг, байгууллагуудын эрх, үүргийн тухай тунхаглалыг (НҮБ-ын тунхаглал) үндэсний түвшинд бүрэн дүүрэн бөгөөд үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглүүлэх, туслах зорилготой юм.

Хүний эрх хамгаалагчдыг хууль ёсоор хүлээн зөвшөөрөх, хамгаалах нь тэднийг аюулгүй, таатай орчинд ажиллаж, халдлага, хонзогнол, үндэслэлгүй хязгаарлалтаас ангид байх нөхцлийг бүрдүүлэхэд амин чухал юм. Хамгаалагчдыг хууль ёсоор хүлээн зөвшөөрөх, хамгаалах нь хүний эрхийг дээдлэх, ардчилал, сайн засаглал, тогтвортой хөгжил, хууль дээдлэх ёсыг хөхүүлэн дэмжих илүү өргөн хүрээтэй зорилгод мөн хувь нэмэр оруулдаг. Хүний эрх хамгаалагчид нь эрх эдлэгчид, зөрчлийн хохирогчид бүхэлдээ нийгмийн эрх ашгийн төлөө ажилладаг.

Улс орнууд хүний эрх хамгаалагчдыг ажлаа чөлөөтэй, аюулгүй, таатай орчинд явуулах боломжоор хангах үндсэн үүрэгтэй. Сүүлийн жилүүдэд НҮБ-ын Тусгай журам, гэрээний байгууллагууд, Хүний эрхийн зөвлөл, Хүний эрхийн дээд комиссарын газар зэрэг механизмууд, бүс нутгийн хүний эрхийн байгууллагууд, шинжээчдийн хамт Тунхаглалаар баталгаажуулсан эрхийг баталгаатай эдлүүлэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хамгаалагчдын ажлыг хязгаарласан, гутаан доромжилсон, эрүүгийн хариуцлага хүлээлгэх хууль тогтоомжийг хянан үзэж, нэмэлт өөрчлөлт оруулахыг улс орнуудад уриалсаар ирсэн билээ.

Гэвч цөөхөн улс Тунхаглалыг үндэсний хууль тогтоомждоо цогц байдлаар тусгасан байдаг бол олон орон Хүний эрх хамгаалагч нар хууль ёсны ажлаа хэрэгжүүлэхэд нэн чухал эрх болох хүний үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарласан хууль тогтоомжийг хэрэгжүүлсээр байна.

Хүний эрх хамгаалагчдыг хамгаалах талаар тусгайлсан хууль, бодлого боловсруулсан улс орнуудад нөөц бололцоо хийгээд улс төрийн хүсэл зориг дутагдалтай байгаа нь тэдгээрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд саад болж байна.

Энэ хүрээнд Загвар хууль нь дараах үндсэн гурван зорилтыг дэвшүүлж байна:

- хүний эрх хамгаалагчдын ажлыг дэмжих, тэднийг хонзогнол болон халдлагаас хамгаалах зорилгоор үндэсний хэмжээнд хууль, бодлого, институцийг хөгжүүлэхэд нь улс орнуудад туслалцаа үзүүлэх, техникийн удирдамжаар хангах;
- хүний эрх хамгаалагчдын ажлыг хуулиар илүү өргөн хүрээнд хүлээн зөвшөөрүүлж, хамгаалуулахыг зорин ажиллаж буй хамгаалагчдыг гарын авлагаар хангах;
- одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, бодлогын хамрах хүрээ, үр нөлөөг хэмжих, үнэлэх арга хэрэгслээр улс орнууд болон хүний эрх хамгаалагчдыг хангах.

## **Загвар хуулийг боловсруулсан үйл явц**

Энэхүү Загвар хуулийг өндөр түвшний 28 шинжээч дэмжиж гарын үсэг зурсан. Загвар хуулийг Олон улсын хүний эрхийн алба (International Service for Human Rights)-наас гурван жилийн хугацаанд дараах зүйлийг үндэслэн боловсруулсан болно. Үүнд:

- бүх бүс нутгийн төлөөлөл болох 40 гаруй улсыг хамруулан хүний эрх хамгаалагчдыг хүлээн зөвшөөрөх, хамгаалахад чиглэсэн сайн туршлагууд болон хязгаарлалтын аль алиныг тодорхойлсон харьцуулсан эрх зүйн судалгаа;<sup>1</sup>
- бүх бүс нутаг, дэд бүс нутаг, эрх зүйн тогтолцоог төлөөлсөн 110 гаруй улсын 500 гаруй хүний эрхийн хамгаалагчидтай нүүр тулан зөвлөлдсөн<sup>2</sup>;
- мониторингийн ажиллагаа болон судлагдсан байдлын харьцуулсан шинжилгээ;<sup>3</sup>
- загвар хуулийн төслийг боловсруулахад хүний эрхийн өндөр түвшний шинжээч, хуульч мэргэжилтнүүдтэй өргөн хүрээнд хамтран ажиллаж, төслийг эцэслэхдээ хоёр өдөр уулзсан билээ.<sup>4</sup>

Энэхүү Загвар хуулийг Фрешфилдс Брукхаус Дерингер (Freshfields Bruckhaus Deringer) хуулийн фирмийн олон тооны мэргэжлийн санал дүгнэлт болон үнэ төлбөргүй (pro bono) эрх зүйн туслалцааны ачаар боловсруулав.

## **Энэхүү Загвар хуулийг хэрхэн ашиглах тухай**

Энэхүү Загвар хуулийн тайлбар нь хүний эрх хамгаалагчдыг хүлээн зөвшөөрөх, хамгаалах тухай хуулийг боловсруулахад хууль тогтоогчид, хамгаалагчдад туслах гарын авлагын үүрэг гүйцэтгэх зорилготой бөгөөд тухайн хуулийн аль нэг хэсгийг бүрдүүлэх зорилго агуулаагүй болно.

Энэхүү Загвар хуулийг олон талын оролцогч янз бүрээр ашиглаж болно. Үүнд:

- хууль тогтоогчид, бодлого боловсруулагчид хүний эрх хамгаалагчдыг хүлээн зөвшөөрөх, хамгаалах тухай үндэсний хууль боловсруулахдаа мэдээлэл авах, эсвэл одоо хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомжийн цар хүрээ болон үр дүнг хянан үзэхэд техникийн туслалцааны эх үүсвэр болгон ашиглах;
- хүний эрх хамгаалагчид болон иргэний нийгмийн бусад оролцогчийн зүгээс хүний эрх хамгаалагчдыг хүлээн зөвшөөрөх, хамгаалах тухай үндэсний хуулийг боловсруулахад санал оруулах, чиглүүлэх, эдгээр хууль, бодлогыг боловсруулж, хянахад хувь нэмэр оруулахдаа ашиглах, шалгах жагсаалт, хариуцлагын хэрэгсэл болгох.

Энэхүү Загвар хуулийг үндэсний нөхцөл байдал, үндэсний эрх зүй, үндсэн хуулийн хүрээнд нийцүүлэх шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрөхийн хамт аль болох цогц байдлаар боловсруулахыг чармайсан юм.

Загвар хуулийн гол заалтууд наад зах нь НҮБ-ын Тунхаглалын холбогдох заалтуудыг бүрэн хүчин төгөлдөр болгоход суурь болох зорилготой юм. НҮБ-ын Тунхаглал эсвэл бусад олон улсын баримт бичигт тусгасан үүрэг эсвэл стандартаас давсан олон заалтыг сайн туршлагад үндэслэн оруулсан болно.

Энэхүү Загвар хуулийг үндэсний эрх зүйн орчин, уламжлалаас хамааран хууль тогтоомж болон дүрэм журмыг хослуулсан байдлаар, эсхүл хууль тогтоомж болон ерөнхийлөгчийн буюу гүйцэтгэх засаглалын шийдвэр, захирамжийг хослуулан, эсхүл хууль тогтоомж болон бодлогыг хослуулсан байдлаар баталж болно.

Хүний эрх хамгаалагчдыг хамгаалах тухай үндэсний аливаа хуулийг хамгаалагчид болон иргэний нийгмийн бусад оролцогчидтой нягт зөвшилцөн боловсруулж, хэрэгжүүлэх ёстой бөгөөд эмэгтэй хүний эрх хамгаалагч, эрсдэлд байгаа болон эрсдэлд өртөж болзошгүй хамгаалагчдын бусад бүлэг буюу ангилалд хамаарах хамгаалагчдын онцлог байдал, хамгааллын хэрэгцээнд жендэрийн байр сууринаас, мэдрэмжтэй хандвал зохино.

Түүнчлэн хүний эрх хамгаалагчдыг хамгаалах аливаа хууль нь улс төрийн өндөр түвшний дэмжлэг болон бүрэн дүүрэн, үр дүнтэй хэрэгжүүлэхэд хангалттай эх үүсвэртэй байх зайлшгүй шаардлагатай.

### **Хүний эрх хамгаалагчдыг хамгаалах ерөнхий хүрээ**

Энэхүү Загвар хуульд үндэслэсэн хүний эрх хамгаалагчдыг хүлээн зөвшөөрөх, хамгаалах тухай тусгайлсан хууль байх нь зайлшгүй шаардлагатай ч уг хууль нь дангаараа хамгаалагчдын аюулгүй, таатай орчныг бүрдүүлэх эрх зүйн хүрээний хангалттай элемент биш гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Загвар хуулийн талаар өмнө нь уулзаж, зөвлөлдсөн хамгаалагчид тэднийг хамгаалах тухай тусгайлсан хууль тогтоомж гаргахыг дэмжихдээ тэдний үйл ажиллагааг хязгаарласан аливаа хууль, бодлогыг хянан үзэх, нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байгааг онцолсон. Цаашилбал, зөвлөлдөх уулзалтад оролцсон хамгаалагчид тэднийг хамгаалах тухай хуулийг зайлшгүй шаардлагатай гэж үзэхдээ тухайн хууль нь тэдний ажиллах аюулгүй, таатай орчныг баталгаажуулахын тулд өргөн хүрээтэй бусад арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн. Хамгаалагчид аюулгүй бөгөөд таатай орчинд үйл ажиллагаа явуулахад шаардлагатай үндсэн элементүүдийг Хүний эрх хамгаалагчдын нөхцөл байдлын асуудлаарх Тусгай илтгэгч асан Маргарет Секаггиагийн 2013 оны 12-р сарын тайланд дурдсан. Үүнд<sup>5</sup>:

- хууль эрх зүй, институцийн болон захиргааны тохиромжтой орчин;
- хамгаалагчдын эсрэг зөрчил хариуцлага хүлээхгүй байхын эсрэг тэмцэх, шударгаар шийдвэрлэх;
- хүчтэй, хараат бус, үр дүнтэй үндэсний хүний эрхийн байгууллагууд;
- олон нийтийн дэмжлэгийг оролцуулан хамгаалагчдын ажлыг үр дүнтэй хамгаалах бодлого, механизм;

- хүний эрх хамгаалагч эмэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн асуудлаар ажилладаг хүмүүст тулгардаг эрсдэл, бэрхшээлд онцгой анхаарал хандуулах;
- төрийн бус этгээд хамгаалагчдын ажлыг хүндэтгэдэг, дэмждэг байх;
- НҮБ болон олон улсын хүний эрхийн байгууллагуудад аюулгүй, нээлттэй хандах боломж;
- хүний эрх хамгаалагчдын хүчтэй, динамик, олон талт нийгэмлэг.

- 
1. Хязгаарлалтаас хамгаалалт руу судалгааны тайлангийн талаар дараах линкээр орж үзнэ үү [www.ishr.ch/sites/default/files/article/files/research\\_report\\_on\\_legal\\_environment\\_for\\_hrds\\_upload.pdf](http://www.ishr.ch/sites/default/files/article/files/research_report_on_legal_environment_for_hrds_upload.pdf).
  2. In the eyes of the law: Human rights defenders demand national legal recognition and protection, Summary Consultation Report; In the eyes of the law: Human rights defenders demand national legal recognition and protection, Full Consultation Report.
  3. In Defense of Life: Civil Observation Mission (moc) Report on the situation of human rights defenders in Mexico 2015 тайланг Хүний эрхийг хамгаалах, түгээн дэлгэрүүлэх Мексикийн Комисс(cmdpdh), Олон улсын Энх Тайвны Бригад-Мексикийн төсөл(pbi Mexico), Конекс Европ, Мексикийн Эмнести Интернэшнл(ai Mexico), Жаст Ассоциэйтс(jass), Хүний эрхийн төлөөх олон улсын үйлчилгээ(ishr), Галын шугамын хамгаалагчид(fld), Олон улс дахь хамгаалалт(pi), Роберт Ф.Кеннеди Хүний Эрх (rfk Human Rights), Хүний эрх хамгаалагчдыг хамгаалах ажиглалтын төв(omct/fidh), Мексикийн хүний эрхийн төлөөх Германы хамтын ажиллагаа зэрэг олон улсын болон үндэсний байгууллагууд хамтран бэлтгэлээ. Дараах холбоосоор орж үзнэ үү: [www.cmdpdh.org/publicaciones\\_pdf/cmdpdh\\_en\\_defensa\\_de\\_la\\_vida\\_conclusiones\\_de\\_la\\_mision\\_de\\_observacion\\_civil\\_sobre\\_situacion\\_de\\_personas\\_defensoras\\_en\\_mexico\\_2015.pdf](http://www.cmdpdh.org/publicaciones_pdf/cmdpdh_en_defensa_de_la_vida_conclusiones_de_la_mision_de_observacion_civil_sobre_situacion_de_personas_defensoras_en_mexico_2015.pdf); Хүний эрх хамгаалагчдыг хамгаалах шинэ, түр зуурын үндэсний хууль тогтоомж, механизмыг судалсан тухай Протекшн Интернэшнл байгууллагын Focus вэб хуудсанд дурдсаныг дараах холбоосоор орж үзнэ үү. <http://focus.protectionline.org/>
  4. 2016 оны 5-р сарын 10-11-ний өдрүүдэд Швейцарийн Боссид дэлхийн өнцөг булан бүрээс хүний эрхийн өндөр түвшний шинжээчид, хуульч мэргэжилтнүүд хуралдаж Загвар хуулийн төслийг хэлэлцэж, тайлбар, нэмэлт өөрчлөлт оруулав.
  5. 2013 оны 12-р сар, Хүний эрх хамгаалагчдын нөхцөл байдлын талаарх өмнөх Тусгай илтгэгчийн тайлан, A/ HRC/25/55.

## **ЗАГВАР ХУУЛЬД ГАРЫН ҮСЭГ ЗУРАГЧИД**

Энэхүү загвар хуулийг 2016 оны 5 дугаар сарын 10, 11-ний өдөр зохион байгуулсан Шинжээчдийн хуралд оролцсон дараах хүний эрхийн шинжээч, хуульчид хувь хүнийхээ хувьд дэмжсэн болно.

Алис Могве, Ботсванагийн Дитшванело Хүний эрхийн төвийн захирал.

Андреа Рокка, Фронтын шугамын хамгаалагчид байгууллагын хамгааллын дарга.

Крис Сидоти, Хүний эрхийн олон улсын зөвлөх, Хүний эрхийн дээд комиссарын газрын Хүний эрхийн асуудлаарх техникийн хамтын ажиллагааны сайн дурын сангийн Удирдах зөвлөлийн гишүүн, Австралийн Хүний эрхийн комиссар асан.

Клаудиа Виржиниа Самаёа, UDEFEGUA (Гватемал дахь Хүний эрх хамгаалагчдыг хамгаалах нэгж)-ийг үүсгэн байгуулагч бөгөөд зохицуулагч.

Клемент Вул, Баруун Африкийн хүний эрхийн хамгаалагчдын сүлжээний дэд дарга, Олборлох үйлдвэр, байгаль орчин, хүний эрхийн зөрчлийн асуудлаарх Африкийн Комиссын Ажлын хэсгийн гишүүн.

Даниэл Жолой, Мексикийн хүний эрхийг хамгаалагч, Эмнести Интернэшнлийн бодлогын ахлах зөвлөх.

Жеральд Стаберок, Дэлхийн эрүү шүүлтийн эсрэг байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга.

Гуадалуп Маренго, Эмнести Интернэшнлийн Дэлхийн хүний эрхийн хамгаалагчдын багийн ахлагч.

Хассан Шир Шейх, Хамгаалагчдыг хамгаал байгууллагын дарга.

Жеймс Саваж, Дэлхийн хүний эрхийн сангийн Хүний эрхийн хамгаалагчдад таатай орчныг бүрдүүлэх хөтөлбөрийн ажилтан.

Жан-Даниел Вини, Швейцарийн Гадаад хэргийн яамны олон улсын хүний эрхийн асуудал эрхэлсэн шинжээч.

Камала Чандракирана, НҮБ-ын Эмэгтэйчүүдийг хуулиар болон практик дээр ялгаварлан гадуурхахын эсрэг ажлын хэсгийн гишүүн, Индонезийн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн үндэсний комиссын дарга, ерөнхий нарийн бичгийн дарга асан.

Луи Энрике Эгүрэн Фернандез, Хамгааллын олон улсын байгууллагын Удирдах зөвлөлийн гишүүн.

Маргарет Секаггиа, Уганда улсын Хүний эрхийн төвийн гүйцэтгэх захирал, НҮБ-ын Хүний эрх хамгаалагчдын нөхцөл байдлын асуудлаарх Тусгай илтгэгч асан, Угандагийн Хүний эрхийн комиссын дарга асан.

Маурисио Анжел, Хамгааллын олон улсын байгууллагын Судалгаа, сургалтын албаны дарга.

Майкл Инейхен, Олон улсын хүний эрхийн албаны хөтөлбөрийн менежер (Компанийн хариуцлага) ба Хүний эрхийн зөвлөлийн Нөлөөллийн захирал.

Мишель Форст, НҮБ-ын Хүний эрх хамгаалагчдын нөхцөл байдлын асуудлаарх Тусгай илтгэгч.

Нави Пиллай, НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссар асан.

Ольга Абраменко, Ялгаварлан гадуурхахын эсрэг дурсгалын төвийн шинжээч.

Оливье де Фрувилл, Олон улсын эрх зүйн профессор, Пантеон-Ассас их сургуулийн Хүний эрх ба хүмүүнлэгийн эрх зүйн судалгааны төвийн захирал

Отто Саки, Олон улсын хуульчдын комиссын Африкийн бүсийн газрын хууль эрх зүйн ахлах зөвлөх.

Патрисия Шулц, НҮБ-ын Эмэгтэйчүүдийн ялгаварлан гадуурхалтыг устгах хорооны гишүүн.

Филип Линч, Олон улсын хүний эрхийн алба байгууллагын захирал.

Рейн Алапини-Гансу, Африкийн Хүний ба ард түмний эрхийн комиссын Африк дахь Хүний эрхийн хамгаалагчдын асуудлаарх Тусгай илтгэгч.

Сэр Николас Братза, Европын хүний эрхийн шүүхийн ерөнхийлөгч асан.

Вринда Гровер, хүний эрхийн хуульч, идэвхтэн, Дэлхийн хүний эрхийн сангийн Удирдах зөвлөлийн гишүүн, Хүний эрхийн төлөөх Өмнөд Азичууд байгууллагын товчооны гишүүн.

Вайлдер Тайлер, Олон улсын хуульчдын комиссын Ерөнхий нарийн бичгийн дарга.

Янхи Ли, Мьянмар дахь Хүний эрхийн нөхцөл байдлын асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч



**ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧДЫГ  
ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ, ХАМГААЛАХ  
ТУХАЙ ЗАГВАР ХУУЛЬ**

<b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ</b>	<b>1</b>
Нэгдүгээр зүйл. Зорилго	1
Хоёрдугаар зүйл. Хүний эрх хамгаалагчийн тодорхойлолт	2
<b>ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧДЫН ЭРХ БА ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ҮҮРЭГ</b>	<b>4</b>
Гуравдугаар зүйл. Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах эрх	4
Дөрөвдүгээр зүйл. Эвлэлдэн нэгдэх, бүлэг, байгууллага байгуулах эрх	5
Тавдугаар зүйл. Хөрөнгө нөөц хайх, хүлээж авах, захиран зарцуулах эрх	6
Зургадугаар зүйл. Мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрх	6
Долдугаар зүйл. Хүний эрхийн үзэл санааг хөгжүүлэх, нөлөөлөх эрх	8
Наймдугаар зүйл. Төрийн бус, төрийн болон засгийн газар хоорондын байгууллагатай харилцах эрх	9
Есдүгээр зүйл. Олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн байгууллага, механизмд хандах, харилцах болон хамтран ажиллах эрх	9
Аравдугаар зүйл. Нийтийн үйл хэрэгт оролцох эрх	10
Арван нэгдүгээр зүйл. Тайван замаар эвлэлдэн нэгдэх эрх	11
Арван хоёрдугаар зүйл. Төлөөлөх болон өмгөөлөх эрх	12
Арван гуравдугаар зүйл. Чөлөөтэй зорчих эрх	13
Арван дөрөвдүгээр зүйл. Хувийн нууцтай байх эрх	14
Арван тавдугаар зүйл. Айлган сүрдүүлэлт, хонзогнолоос ангид байх	15
Арван зургадугаар зүйл. Гүтгэлэг, гутаан доромжлолоос ангид байх	16
Арван долдугаар зүйл. Соёлын эрхээ хэрэгжүүлэх болон хөгжих эрх	16
Арван наймдугаар зүйл. Үр дүнтэй нөхөн сэргээлгэх, бүрэн нөхөн төлбөр авах эрх	17
Арван есдүгээр зүйл. Хүний эрх хамгаалагчийн эрхийг хязгаарлах	18
Хорьдугаар зүйл. Бусад эрх, эрх чөлөөг үл хөндөх	18
Хорин нэгдүгээр зүйл. Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах үүрэг хариуцлага	19
<b>ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ</b>	<b>20</b>
Хорин хоёрдугаар зүйл. Хүний эрх хамгаалагчдын эрхийг хүндэтгэх, хөхиүлэн дэмжих, хамгаалах, хэрэгжүүлэх үүрэг	20
Хорин гуравдугаар зүйл. Хүний эрх хамгаалагчдын үйл ажиллагаа, ажлыг нь дэмжих үүрэг	20
Хорин дөрөвдүгээр зүйл. Хүний эрх, үндсэн эрх чөлөөтэй холбоотой материалыг чөлөөтэй авах эрхийг хангах үүрэг	21

Хорин тавдугаар зүйл. Нууц эх сурвалжийг задруулахгүй байх үүрэг	22
Хорин зургадугаар зүйл. Айлган сүрдүүлэлт, хонзогнолын эсрэг хамгаалалтыг баталгаажуулах, урьдчилан сэргийлэх үүрэг	23
Хорин долдугаар зүйл. Дур зоргоор, хууль бусаар халдах, хөндлөнгөөс оролцохын эсрэг хамгаалалтыг баталгаажуулах үүрэг	23
Хорин наймдугаар зүйл. Мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах үүрэг	24
Хорин есдүгээр зүйл. Үр дүнтэй нөхөн сэргээлгэх бүрэн нөхөн төлбөр авахыг баталгаажуулах үүрэг	25
Гучдугаар зүйл. Айлган сүрдүүлэлт, хонзогнолыг гэмт хэрэгт тооцох үүрэг	26
Гучин нэгдүгээр зүйл. Хүний эрхийн боловсролыг түгээх, хөхиүлэн дэмжих үүрэг	26
Гучин хоёрдугаар зүйл. Хамгаалах болон яаралтай хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг	27
Гучин гуравдугаар зүйл. Гадаад улс дахь хүний эрх хамгаалагчдад туслалцаа үзүүлэх	27
<b>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧИЙГ</b>	
<b>ХАМГААЛАХ МЕХАНИЗМ</b>	<b>29</b>
Гучин дөрөвдүгээр зүйл. Хүний эрх хамгаалагчдыг хамгаалах тогтолцоог бий болгох	30
Гучин тавдугаар зүйл. Иргэний нийгэмтэй зөвшилцөх	36
Гучин зургадугаар зүйл. Нөөц	36
Гучин долдугаар зүйл. Сургалт ба шалгалт	37
<b>ТАВДУГААР БҮЛЭГ. ХЭРЭГЛЭГДЭХ НЭР ТОМЬЁО БОЛОН ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ</b>	<b>38</b>
Гучин наймдугаар зүйл. Нэр томьёо	38
Гучин есдүгээр зүйл. Ялгаварлан гадуурхахгүй байх	41
<b>ХАВСРАЛТ I. ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧДЫГ ХАМГААЛАХ ЭРХИЙН, НӨӨЦИЙН БОЛОН ХЭРЭГЖҮҮЛЭХ МЕХАНИЗМЫН БОЛОМЖИТ НЭМЭЛТ ЗААЛТУУД</b>	<b>42</b>
Нэгдүгээр зүйл. Хамгаалалтын арга хэмжээ авахыг хүсэх өргөдөл	42
Хоёрдугаар зүйл. Хамгаалалтын арга хэмжээ хүссэн өргөдлийн үнэлгээ	42
Гуравдугаар зүйл. Хамгаалалтын төлөвлөгөө, авах арга хэмжээг боловсруулах	43
Дөрөвдүгээр зүйл. Яаралтай хамгаалах төлөвлөгөө, арга хэмжээ	45
Тавдугаар зүйл. Хамгаалалтын арга хэмжээг дахин үнэлэх, цуцлах	45
Зургадугаар зүйл. Механизмын шийдвэрийг хянах	46
Долдугаар зүйл. Дэмжин сурталчилах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ	47
<b>ХАВСРАЛТ II. ЗАГВАР ХУУЛИЙГ БУСАД ХУУЛЬТАЙ НИЙЦҮҮЛЭХ БОЛОМЖИЙН НЭМЭЛТ ЗААЛТУУД</b>	<b>48</b>
Нэгдүгээр зүйл. Энэ хуульд нийцсэн тайлбарыг илүүд үзэх	48
Хоёрдугаар зүйл. Нийцэмжгүй байдлын тухай мэдэгдэл	48
Гуравдугаар зүйл. Нийцэмжгүй байдлын мэдэгдлийн үр дагавар	49
Дөрөвдүгээр зүйл. Нийцэмжтэй байдлын мэдэгдэл	49
Тавдугаар зүйл. Хууль тогтоомжийн нийцтэй байдлыг хяналтад байлгах	50

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

### Нэгдүгээр зүйл.

#### Зорилго

Энэхүү хуулийн зорилго нь

- a. Хүний эрхийг хүн бүр дангаараа эсхүл бусадтай нэгдэн үндэсний болон олон улсын хэмжээнд хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалахыг хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх, хангах;
- b. ... улсад хүний эрх болон үндсэн эрх чөлөөг баталгаажуулах, хөхиүлэн дэмжих, хамгаалах байдлыг баталгаажуулах;
- c. .... улсад НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих талаар хувь хүн, нийгмийн бүлэг, байгууллагын эрх, үүргийн тухай тунхаглалын хэрэгжилтийг баталгаажуулах;
- d. Хүний эрх хамгаалагчдыг хамгаалах талаарх бүс нутгийн гэрээ, баримт бичгийг хэрэгжүүлэх талаар хүлээсэн .... улсын үүрэг амлалтыг баталгаажуулах юм.

#### Тайлбар

Дэд хэсэг (a)-г НҮБ-ын Хүний эрх хамгаалагчдын тунхаглалын Нэгдүгээр зүйл дээр үндэслэсэн болно.

*Хүн бүр бие даан болон бусадтай эвлэлдэн нэгдэж, үндэсний болон олон улсын түвшинд хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хүндэтгэн биелүүлэх явдлыг хөхиүлэн дэмжих, түүний төлөө тэмцэх эрхтэй.*

Дэд хэсэг (b) болон (c)-г Шинэ Зеландын 1990 оны Хүний эрхийн хуульд үндэслэсэн болно.

Африкаас дараах холбогдох бүс нутгийн тунхаглал, эрх зүйн баримт бичиг багтсан болно: Кигалигийн Тунхаглал – Энэхүү Тунхаглалыг Руандагийн Кигали хотод 5-р сарын 6-7-ны хооронд Хүний Эрхийн Үндэсний Байгууллагууд болон Хүний Эрхийн Үндэсний Хамтын Нийгэмлэгүүдийн Форумын гишүүд хуралдаж хүүхдийг хүчээр эрт гэрлүүлэхээс сэрэмжлэх, түүнийг таслан зогсоох зорилгоор баталсан; Хүний ба ард түмний эрхийн тухай Африкийн харти; Африк дахь Хүний Эрх Хамгаалагчдыг Хамгаалах 69-р Тогтоол – энэхүү Тогтоолыг Гамбийн Банжул хотод 2004 оны 5 сарын 21-с 6-р сарын 4-н хүртэл хуралдсан Хүний ба ард түмний эрхийн тухай Африкийн Хорооны 35 дахь Ээлжит Чуулганаар баталсан; 1999 оны Гранд Бэй (Маврикий) Тунхаглал ба Хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө.

Америкийн бүс нутгаас дараах холбогдох тунхаглал, эрх зүйн баримтуудыг дурдаж болно: Хүний Эрхийн Америкийн Конвенц, Хүний Эрхийн Америк Хоорондын Хорооноос гаргасан “Хүний Эрх Хамгаалагчдыг Хэрэгтэн Болгож, Яллах” Тайлан (2015), “Америк дахь Хүний Эрх Хамгаалагчдын Нөхцөл Байдлын тухай Тайлан” (2012), “Уугуул иргэд, Африк гаралтай хүмүүс, Олборлох үйлдвэрийн ажилчдын нөхцөл байдал” (2015), болон Америк Хоорондын Хүний Эрхийн Шүүхийн шийдвэр Хүний Эрх Хамгаалагч. Гватемал (2014 оны 8-р сарын 28).

**Хоёрдугаар зүйл.  
Хүний эрх хамгаалагчийн тодорхойлолт**

Энэхүү хуулийн зорилгын хүрээнд “хүний эрх хамгаалагч” гэдэгт хүний эрх, үндсэн эрх чөлөөний хэрэгжилт, хамгаалалтыг дангаараа болон бусадтай хамтран орон нутгийн, үндэсний, бүс нутгийн болон олон улсын төвшинд хөхиүлэн дэмжих, хамгаалах, хэрэгжүүлэх талаар ажилласан болон ажиллахаар хичээж байгаа хувь хүнийг хэлнэ.

Энэхүү хуулийн зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд “хүний эрх хамгаалагч” гэдэгт хүний эрх, үндсэн эрх чөлөөг орон нутгийн, үндэсний, бүс нутгийн болон олон улсын хэмжээнд хөхиүлэн дэмжих, хамгаалах, хэрэгжүүлэх талаар дангаараа болон бусадтай хамтран ажиллаж байгаа хувь хүнийг хэлнэ.

Тайлбар

Энэхүү хэсэгт НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын “Хүний эрх хамгаалагчид: Хүний эрх хамгаалагчийн эрхийг хамгаалах нь” (2004), Ажлын Албаны 29 тоот баримт бичигт хэрэглэсэн “хүний эрх хамгаалагч”-н тодорхойлолтыг тусгасан болно (хуудас 2: <http://www.ohchr.org/Documents/Publications/FactSheet29en.pdf>)

‘Хүний эрх хамгаалагч’ гэдэг нь дангаараа болон бусадтай эвлэлдэн нэгдэж хүний эрхийг дэмжих, хамгаалах зорилгоор үйл ажиллагаа явуулдаг хүмүүсийг тодорхойлоход хэрэглэдэг нэр томъёо юм.

Үүнтэй ижил төстэй тодорхойлолтуудыг Бразилийн Хүний Эрхийн Хуулийн 2(1) зүйл, Непалын Хүний Эрхийн Хуулийн 2 (а) зүйл зэрэг дотоодын эрх зүйн баримт бичгүүдээс харж болно.

Хүний эрх хамгаалагчид өөрсдийн оршин сууж буй улсынхаа нутаг дэвсгэрт (орон нутаг, бүс нутаг болон үндэсний түвшинд) эсвэл түүнээс цааш хүний эрхийг дэмжих, хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж болохыг тодорхой болгох зорилгоор “орон нутгийн, үндэсний, бүс нутгийн болон олон улсын түвшинд” гэсэн хэллэгийг нэмсэн болно. Энэ талаар бусад эрх зүйн баримтуудад дурдсан байдаг. Жишээ нь НҮБ-ын Хүний эрх хамгаалагчдын тунхаглалын 1-р зүйлд:

*Хүн бүр бие даан болон бусадтай эвлэлдэн нэгдэж үндэсний болон олон улсын түвшинд хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хэрэгжүүлэхийг хичээх, дэмжих эрхтэй.*

Мөн Америк Хоорондын Хүний Эрхийн Комиссоос гаргасан Америк дахь Хүний Эрх Хамгаалагчдын Нөхцөл Байдлын Тухай” 2 дахь илтгэлийн хуудас 4-г үзнэ үү (2011):

*... үндэсний болон олон улсын хэмжээнд хүний эрх, үндсэн эрх чөлөөг хэрэгжүүлэхийг ямар нэгэн байдлаар дэмжиж, эрэлхийлж буй хүн бүр. ”*

Хэд хэдэн дотоодын баримт бичигт “хүний эрх хамгаалагч”-г энд байгаагаас илүү нарийвчлан тодорхойлсон байдаг. Жишээлбэл, Филиппиний хуулийн 3 (а) зүйл, Конго Улсын хуулийн 5-р зүйлийг үзнэ үү.

Бүс нутгийн зөвлөлдөх уулзалтууд, шинжээчдийн уулзалтын үеэр илүү нарийвчилсан тодорхойлолт зарим хүнийг “хүний эрх хамгаалагч” гэсэн ангилалд оруулахгүй байх үндэслэл болох магадлалтай талаар хэлэлцсэн учир энэхүү Загвар хуульд “хүний эрх хамгаалагч”-ийг илүү өргөн хүрээнд тодорхойлсон болно.

Бүс нутгийн зөвлөлдөх уулзалтуудын үеэр “хүний эрх хамгаалагч”-ийн тодорхойлолтыг Загвар хуульд<sup>1</sup> оруулахгүй байх нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлсэн болно. Загвар хуулийн төслийг боловсруулагчид энэхүү хуулийг тайлж ойлгох, хэрэгжүүлэхэд зохих хэмжээний чиглэл олгохын тулд “хүний эрх хамгаалагч”-ийн тодорхойлолт оруулах шаардлагатай гэж үзсэн. Бүс нутгийн зөвлөлдөх уулзалтаас гарсан саналын дагуу Загвар хуулийн төслийг боловсруулагчид нэр томъёог тоочиж тодорхойлноор хүмүүсийг “хүний эрх хамгаалагч” гэсэн ангиллаас шууд хасахад хэцүү болно гэж үзсэн. “Хүний эрх хамгаалагч” гэсэн тодорхойлолтод нэмэлт тодруулга хийх шаардлагатай бөгөөд “хүний эрх хамгаалагч” гэсэн ангилалд багтах хүмүүсийн бүрэн бус жагсаалтыг нарийвчлан нэмж оруулж болно.

Непалын хуулийн 2 (а) зүйлд нарийвчилсан жагсаалтыг багтаасан байдаг. Үүнд дурдахдаа хүний эрх хамгаалагчид дараах хүмүүс багтана:

- a) Хүний эрхийн өмгөөлөгчид;
- b) Хүний эрхийн идэвхтнүүд;
- c) Хуульч, шүүх хурлын мэргэжилтнүүд;
- d) Шүүхийн төлөөлөгчид;
- e) Сэтгүүлчид болон хэвлэл мэдээллийн ажилтнууд;
- f) Үйлдвэрчний эвлэлийн гишүүд;
- g) Нийгмийн ажилтнууд;
- h) Эрүүл мэндийн салбарын ажилтнууд.

“Хүний эрх хамгаалагч” гэдэгт хүний эрхийн төлөөх өөрчлөлтийг олон нийтэд нээлтэй байдлаар дэмжиж, санал болгож буй хүмүүс, түүнчлэн өөрчлөлтийн төлөө идэвхтэй кампанит ажил эрхэлдэг хүмүүс (“хүний эрхийн идэвхтнүүд”) багтана гэдгийг тодорхой болгох үүднээс “хүний эрх дэмжигчид” гэсэн ангиллыг оруулсан болно.

Хэрэв хүний эрх хамгаалагчдыг хүлээн зөвшөөрөх, хамгаалах тухай хууль боловсруулж буй улс илүү нарийвчилсан тодорхойлолтыг оруулахыг хүсвэл дараахь хэсгийг нэмж болно: *“хүний эрх хамгаалагчид бүтэн болон хагас цагаар ажиллаж, үйл ажиллагаагаа явуулж болно, тэд төлбөртэй эсвэл сайн дурын үндсэн дээр ажиллах боломжтой бөгөөд мэргэжлийн / мэргэжлийнхээ нэг хэсэг болгон ажиллах боломжтой боловч, энэ нь заавал шаардлагагүй.”*

Хүний эрх хамгаалагчийн статус авахад заавал албан ёсоор бүртгүүлэх шаардлага байхгүй гэдгийг анхаарах нь чухал юм. Үүнтэй адилаар, А / HRC / 20/27-д заасны дагуу бүртгэлгүй холбоо нийгэмлэгүүд үйл ажиллагаагаа явуулах боломжтой байх ёстой.

“Хүний эрх хамгаалагч”-ийн тодорхойлолтод “тайван замаар” гэсэн үг ороогүй нь НҮБ-ын Тунхаглалын 1-р зүйлд эдгээр үг ороогүйтэй холбоотой болно. Гэхдээ НҮБ-ын Тунхаглал, Загвар хуулийн бусад хэсэгт ийм шаардлага багтсан болохыг тэмдэглэх нь зүйтэй.

НҮБ-ын Тунхаглалын 12 дугаар зүйлийн 3-т:

*Хүн бүр дангаараа болон бусадтай эвлэлдэн нэгдэж, хүний эрх, үндсэн эрх чөлөөг зөрчсөн болон хорьж хасахад хүргэсэн Төрийн үйл ажиллагаа, үйлдлүүдийн эсрэг, мөн хүний эрх, үндсэн эрх чөлөөгөө эдлэхэд бэрхшээл учруулж буй бүлэг болон хувь хүмүүсийн гаргасан хүчирхийллийн үйлдлүүдийн эсрэг тайван замаар, хариу үйлдэл үзүүлснийхээ төлөө үндэснийхээ хуулиар хамгаалуулах эрхтэй.*

Цаашилбал, Тунхаглалын 13-р зүйлд:

Энэхүү тунхаглалын 3-р зүйлд заасны дагуу хүн бүр, бие даан болон бусадтай эвлэлдэн нэгдэж, тайван замаар хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах зорилгоор төрөл бүрийн нөөц, хэрэгслүүд олж авах хүсэлт гаргах, хүлээж авах болон ашиглах эрхтэй.

<sup>1</sup> International Service for Human Rights байгууллагын Project report: Regional Consultation on Model National Law on the Recognition and Protection of Human Rights Defenders төслийн тайлан, 5-р нүүр.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧДЫН ЭРХ БА ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ҮҮРЭГ**

### Хоёрдугаар бүлгийн Ерөнхий Тайлбар

Хоёрдугаар бүлэг нь НҮБ-ын Тунхаглалын 1, 3, 5-13 дугаар зүйл, 17 дугаар зүйл болон олон улсын бусад баримт бичигт заасан нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрхийг тусгасан.

*НҮБ-ын Тунхаглалд зааснаас ч илүүг зарим үндэсний хууль тогтоомжид баталгаажуулсан. Загвар хуулийн энэ бүлэгт эдгээр заалтыг оруулсан.*

Загвар хуульд заагаагүй боловч зарим улсын дотоодын хуульд заасан, тухайлбал Филиппиний хуулийн 14 дүгээр зүйлд хүний эрхийн зөрчлийн хохирогч болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд зориулан нутагшуулах газар барьж өгөх гэж заасан ч энэ нь загвар хуульд тусгахад хэтэрхий нарийвчилсан зохицуулалт гэж загвар хуулийн төсөл боловсруулагчид үзсэн юм.

### **Гуравдугаар зүйл.**

#### **Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах эрх**

Хүн бүр дангаараа болон бусадтай хамтран хүний эрх, үндсэн эрх чөлөөг орон нутгийн, үндэсний, бүс нутгийн болон олон улсын хэмжээнд хөхиүлэн дэмжих, хамгаалах эрхтэй.

Уг зүйлд 4-өөс 18-р зүйлд нарийвчлан тусгасан эрхүүдийг багтаасан эрх хэмээх ерөнхий ойлголтыг авч үзнэ.

НҮБ-ын Тунхаглалын 1-р бүлэгт заасны дагуу:

*Хүн бүр нь дангаараа болон бусадтай хамтран хүний эрх ба үндсэн эрх чөлөөг орон нутгийн, үндэсний, бүс нутгийн болон олон улсын хэмжээнд хөхиүлэн дэмжих болон хамгаалах эрхтэй.*

Хүний эрх хамгаалагчид нь хүний эрх хамгаалах хийгээд дэмжих үйл хэргээ өөрийн улс орон (орон нутаг, муж эсвэл үндэсний хэмжээнд) төдийгүй олон улсад өрнүүлэх боломжтой гэдгийг тодруулах үүднээс “Орон нутгийн, үндэсний, бүс нутгийн болон олон улсын хэмжээнд” хэмээн тусгайлан зааж өгсөн.

Америк Хоорондын Комисс ба “Америк дахь Хүний Эрхийн Хамгаалагчдын Нөхцөл Байдлын тухай” Хүний Эрхийн хоёр дахь тайланд тусгаснаар (2011), ху 4:

*Үндэсний болон олон улсын хэмжээнд хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих ба хамгаалахаар тэмцэж буй хүн бүрийг хүний эрх хамгаалагч гэнэ.*



**Дөрөвдүгээр зүйл.**  
**Эвлэлдэн нэгдэх, бүлэг, байгууллага байгуулах эрх**

1. Хүн бүр дангаараа эсвэл бусадтай хамтран хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих ба хамгаалахыг эрмэлзэх, хэрэгжүүлэхийн төлөө албан ёсны ба албан бус, бүртгэлтэй эсхүл эс бүртгэлтэй бүлэглэл, төрийн бус байгууллагад нэгдэх, төрийн бус байгууллага, бүлэглэл байгуулах, бүлэглэлд оролцох эрхтэй.
2. Эдгээр бүлэг, эвсэл, байгууллага нь дараах шинжтэй байж болно.
  - a. .... Улс дахь бүлэг, эвсэл, байгууллага;
  - b. Бусад улс дахь бүлэг, эвсэл, байгууллага;
  - c. Бүс нутгийн болон олон улсын түвшний бүлэг, эвсэл, байгууллага.
3. Энэхүү зүйлийн 2 дахь хэсгийн (а) дэд хэсэгт заасан ... улс дахь бүлэг, эвсэл, байгууллага нь дараах байгууллагуудтай харилцах эрхтэй:
  - a. .... Улсын бүлэг, эвсэл, байгууллага болон бусад улс орны, бүс нутгийн болон олон улсын байгууллагатай хамтрах; болон
  - b. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт бүлэг, эвсэл, байгууллагуудын сүлжээтэй хамтрах эрхтэй, тэдгээр нь албан болон албан бус, бүртгүүлсэн болон бүртгүүлээгүй байж болно.

Тайлбар

Уг зүйлийг НҮБ-ын Тунхаглалын 5 дугаар бүлэгт үндэслэн найруулсан болно:

*Хүн бүр үндэсний хэмжээнд ба олон улсын түвшинд хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах зорилгоор дангаараа эсвэл бусадтай эвлэлдэн нэгдэх эрхтэй.*

...

*(b) Төрийн бус байгууллага, холбоо, бүлэг байгуулах эсхүл элсэж болно.*

“Албан болон албан бус бүлэг, холбоо, байгууллага” хэмээн нарийвчлан тусгаж өгснөөр дэд хэсэг (1) дэх орон нутгийн бүлгэм, нутгийн уугуул иргэд болон хүний эрх хамгаалах зорилгоор нэгдэн нийлсэн хэсэг бүлэг хүмүүсийг хамааруулна. Эвлэлдэн нэгдэх эрх нь бүртгэлтэй хийгээд бүртгэлгүй бүхий л холбоодод адил тэгш үйлчилнэ. Бүртгэлгүй холбоодын гишүүд хуулийн хүрээнд тайван жагсаал цуглаан хийх эрхтэй бөгөөд эрүүгийн хариуцлага хүлээх ямар нэг үйлдэлд холбогдож болохгүй. (А/НRC/20/27, ху14, 56 дугаар цогцолбор).

Хүний эрх хамгаалагчид нь үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг, үүсгэн байгуулагдсан бүлгэмд нэгдэх, элсэх, байгуулах эрхтэй төдийгүй дэлхийн бусад улсуудад үйл ажиллагаа явуулдаг, үүсгэн байгуулагдсан бүлгэмүүдэд элсэх, нэгдэх, байгуулах эрхтэй гэдгийг тодруулах үүднээс дэд хэсэг (2)-ыг нэмж оруулав.

Тодорхой улс оронд үүсгэн байгуулсан бүлгэмүүд нь бусад улс оронд буй бүлгэмүүдтэй нэгдмэл сонирхолтой байж болно хэмээх санааг илүү тодруулах үүднээс дэд хэсэг (3)-ыг нэмж оруулав. Уг дэд хэсгийг Буркина Фасогийн хуулийн 6 дугаар бүлгээс сэдэвлэв.

Дэд хэсэг (3)-д Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө ба Зохион Байгуулах Эрхийн Хамгааллын тухай ОУХБ2-ийн конвенцийн 5 дугаар бүлгийн найруулгаас эш татсан болно:

*Байгууллагын ажилтан ба ажил олгогчид нэгдэн зөвлөл болон холбоо байгуулах эрхтэй бөгөөд уг зөвлөл ба холбоо нь олон улсын байгууллагын ажилтан ба ажил олгогчтой хамтран ажилладаг байж болно.*

## Тавдугаар зүйл.

### Хөрөнгө нөөц хайх, хүлээж авах, захиран зарцуулах эрх

Хүн бүр дангаараа эсхүл бусадтай хамтран гагцхүү хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах, хэрэгжүүлэх зорилгоор төрийн, засгийн газар хоорондын, хүмүүнлэгийн болон хувийн байгууллага болон орон нутгийн ба олон улсын эх үүсвэрээс хөрөнгө нөөц эрх, хүлээж авах, захиран зарцуулах эрхтэй.

#### Тайлбар

Уг зүйлд НҮБ-ын Тунхаглалын 13 дугаар бүлгээс эш татав:

*Хүн бүр дангаараа эсхүл бусадтай хамтран хүний эрх болон үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах, хэрэгжүүлэх зорилгоор эх үүсвэрээс мэдээлэл шаардах, олж авах болон ашиглах эрхтэй бөгөөд Тунхаглалын 3-р бүлэгт тусгасны дагуу тайван журмаар зохион байгуулна.*

НҮБ-ын Тунхаглалын 3 дугаар бүлэгт тусгаснаар:

*Улсын хууль нь НҮБ-ын Дүрэмтэй нийцсэн, олон улсад хүлээсэн үүргийнхээ дагуу хүний эрх ба үндсэн эрх чөлөөнд ээлтэй байдлаар хуулийн хүрээнд боловсруулсан баримт бичиг бөгөөд хүний эрх ба суурь эрх чөлөөг бүрэн хангаж хамгаалсан байхын сацуу өнөөгийн Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалд тусгагдсан бүхий л үйл ажиллагааг дэмжсэн, хамгаалсан, тэдний үр дүнтэй хэрэгжилтийг хангасан байвал зохилтой.*

НҮБ-ын Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 3 дугаар заалт болон Гондурасын хуулийн 4(17)-р бүлэг болон Буркина Фасогийн хуулийн 6 дугаар заалтуудыг тус тус тусгаагүй болно.

Бүс нутгийн хэлэлцүүлгийн<sup>2</sup> үеэр санал гарсны дагуу “төрийн, болон олон улсын эх үүсвэрүүд” хэмээх утгыг нэмснээр олон улсын болон улс хоорондын байгууллагууд, гадаад эх сурвалжуудаас (Төрийн болон хувийн өмч хамаарна) мэдээлэл шаардах, олж авах болон ашиглах эрхтэй хэмээх утга илүү тодорхой болсон. Зарим улс оронд гадаадын иргэн харьяатын мэдээлэл олж авах боломж хязгаарлагдмал байдаг тул уг ангилал их чухал юм.<sup>3</sup>

Уг зүйлд Хүний Эрхийн Зөвлөлийн Тогтоол - A/HRC/RES/22/6-аас эш татсан болно:

*...Хувь хүн, бүлгэм, байгууллагад тавьж буй мэдээлэх шаардлага нь тэдний бие даасан, хараат бус байдалд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх. Тавьж буй хязгаарлалт нь ил тод, хариуцлагатай байдлыг хангахын тулд хүний эрх хамгаалагчдыг дэмжих зорилгоор олгогдсон санхүүгийн эх үүсвэрт ялгавартай хандахгүй байх ёстой төдийгүй аливаа хуульд хүний эрх хамгаалах аливаа үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэрийн газар зүйн онцлогоос шалтгаалж гэмт хэрэгт буруутгах, цагдан хорих тухай тусгаж болохгүй.*

## Зургадугаар зүйл.

### Мэдээлэл хайх, хүлээн авах болон түгээх эрх

1. Хүн бүр дангаараа эсхүл бусадтай хамтран:
  - a. Хүний эрх, үндсэн эрх чөлөөний тухай мэдээлэл, түүний дотор ...Улсын хууль, шүүх болон захиргааны журмаар хэрхэн хангаж байгаа талаар мэдэх, мэдээлэл хайх, хүртэх, олж авах, хүлээн авах болон хадгалах эрхтэй;

<sup>2</sup> International Service for Human Rights Project report: Regional Consultation on Model National Law on the Recognition and Protection of Human Rights Defenders төслийн тайлан 13-р нүүр.

<sup>3</sup> International Service for Human Rights, *From Restriction to Protection: Research Report on the Legal Environment for Human Rights Defenders and the Need for National Laws to Protect and Promote their Work* (2014), 121-р зүүлт.



- b. Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хэрэгжүүлэх, хамгаалах, хэрэгжүүлэх болон хамгаалахад туслалцаа үзүүлэхэд шаардлагатай мэдээллийг хувийн хэвшлийн байгууллагаас мэдэх, хайх, хүртэх, олж авах, хүлээн авах болон хадгалах эрхтэй;
  - c. Хүний эрх, үндсэн эрх чөлөөний талаар мэдээлэл болон мэдлэгийг чөлөөтэй нийтлэх, бусдад дамжуулах, тараах эрхтэй;
  - d. Хүний эрх, үндсэн эрх чөлөөний талаар хууль болон практик дээрх нөхцөл байдлыг судлах, хэлэлцэх, ажиглалтын талаар үзэл бодолтой байх, янз бүрийн хэрэгслээр асуудалд анхаарлыг хандуулах эрхийг эдэлнэ.
2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрхийг амаар, бичгээр, хэвлэсэн болон бусад урлагийн хэлбэрээр, хэвлэл мэдээллээр, цахим сүлжээ, цахим бус сүлжээгээр дамжуулан хэрэгжүүлж болно.

### Тайлбар

Уг зүйл нь НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 6 дугаар зүйлд үндэслэсэн болно:

*Хүн бүр дангаараа эсхүл бусадтай хамтран:*

- (a). *Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хууль шүүх болон захиргааны журмаар хэрхэн хангаж байгаа талаар мэдэх, мэдээлэл хайх, хүртэх, олж авах, авах болон хадгалах эрхтэй*
- (б). *Хүний эрх болон олон улсын холбогдох бусад баримт бичгүүдэд тусгасны дагуу хүний бүхий л эрх, үндсэн эрх чөлөөний тухай мэдлэг, мэдээллээ чөлөөтэй хэвлэн нийтлэх, мэдээлэх эрхтэй.*
- (в). *Хүний эрх, үндсэн эрх чөлөөний талаар хууль болон нөхцөл байдлыг судлах, хэлэлцэх, ажиглалтын талаар үзэл бодолтой байх, янз бүрийн хэрэгслээр асуудалд анхаарлыг хандуулах эрхийг эдэлнэ.*

Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах зорилгоор бизнесийн байгууллага ба холбогдох хувь хүнээс хүний эрхийн тухай мэдээ мэдээллийг олж авах боломжтой гэдгийг тодруулах үүднээс дэд хэсэг (1)(b)-ийг нэмж оруулав. Хувь хүнээс мэдээлэл олж авах боломжтой байх тухай санааг бүс нутгийн хэлэлцүүлгээр дэвшүүлсэн.<sup>4</sup> Уг дэд хэсгийг Бизнес ба Хүний Эрхийн 21 дэх үндсэн зарчимд үндэслэн нэмж оруулсан болно:

*...Хүний эрхийг ноцтойгоор зөрчиж буй бизнес эрхлэгч, аж ахуйн нэгж нь уг асуудлыг хэрхэн шийдвэрлэж буйгаа албан ёсоор мэдээлдэг байх. Харилцаа нь бүхий л тохиолдолд: (a) тухайн аж ахуйн нэгжийн хүний эрхэд үзүүлж буй нөлөөлөлд чиглэгдсэн бөгөөд зорилтот бүлгэмдээ хэлбэр болон давтамжын хувьд хүртээмжтэй байх, (b) аж ахуйн нэгжийн хүний эрхэд үзүүлж буй сөрөг нөлөөлөлд чиглэсэн арга хэмжээгээ үнэлж, дүгнэж болохуйцаар мэдээлдэг байх, (c) оролцогч талууд, ажилтан эсвэл арилжааны нууцад сөргөөр нөлөөлөхгүй байх.*

Энэхүү зүйл заалт нь хүний эрх хамгаалагчдын эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай Хүний Эрхийн Зөвлөлийн 31/32 дугаар тогтоолд давхар тусгагдсан байдаг. Үүнтэй төстэй зүйл заалтыг Өмнөд Африкийн Хүний Эрхийн тухай хууль болон Сьерра Леон Улсын Мэдээлэл авах эрхийн тухай хуулийн (2013 он)-ын 32 дугаар хэсэгт тусгасан байдаг.

Бизнесийн аж ахуйн нэгжийн уг мэдээлэлд нэвтрэх эрхтэй байна гэдэг нь хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах, хүчирхийлэл үйлдэгчдэд хариуцлага хүлээлгэх зэрэгт чухал ач холбогдолтой бөгөөд энэ тухай “Сайн туршлагад суурилсан аюулгүй бөгөөд хүртээмжтэй иргэний нийгэм бий болгох практик санал зөвлөмжүүд” хэмээх НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын 2016 оны 3 дугаар сарын тайлангийн 86 дугаар цогцолборт тусгасан байдаг:

<sup>4</sup> International Service for Human Rights, Баруун Европын орнууд болон бусад бүлгийн улсуудын хүний эрх хамгаалагчдын нөхцөл байдал, хамгааллын хэрэгцээ шаардлагын талаарх Зөвлөгөөн, (2015 оны 6-р сарын 22-23, Италийн Флоренц) хуудас 8; Африкийн Франц хэлтэн орнуудын хүний эрх хамгаалагчдын нөхцөл байдал, хамгааллын хэрэгцээ шаардлагын талаарх НҮБ-ын Хүний эрх хамгаалагчдын асуудлаарх Тусгай илтгэгчийн зөвлөгөөн (2015 оны 5 сарын 30-31 Заан Ясан эрэг, Абиджан), 7-р нүүр.

Гишүүн орнууд нь:

- (a) *Олон нийтийн байгууллагуудын мэдээллийн ил тод байдлыг хангаж, уг мэдээллийг хүсэлт тавьж, олж авах тухай эрхийг баталгаажуулан олон улсын хүний эрхийн хууль, стандартад нийцсэн хязгаарлах нөхцлүүдээ тодорхой тусган байгууллагын мэдээлэлд нэвтрэх эрхийг онцгойлон баталгаажуулж, тусгаар нэгжийн мэдээллийг задруулахаас татгалзан, давж заалдах эрхийг хангасан тодорхой хууль, тогтоол, бодлого боловсруулах.*
- (b) *Мэдээлэл олж авах эрхийн хэрэгжилтийг хангахын тулд төрийн албан хаагчдыг сургалтад хамруулж, хэрэгжилтийг бүрэн хангах үүднээс олон нийтэд уг мэдээллийг түгээх.*

Хүний эрх хамгаалагчдыг хамгаалах хуулийн төсөл боловсруулж буй улс орнууд уг зүйл заалтыг илүү нарийвчилж, бизнесийн байгууллага, хэвлэл мэдээлэл болон бусад байгууллагуудыг хамруулах боломжтой.

Дэд хэсэг (1)(c)-д тусгасан “Хүний эрх болон олон улсын холбогдох бусад баримт бичгүүдэд тусгасны дагуу” хэмээх утга нь мэдээлэл олж авах эрхийг хязгаарлаж болзошгүй гэж үзсэн тул Загвар хуульд тусгагдаагүй болно. Уг утга нь Зааны ясан эрэг улсын хуулийн 3 дугаар бүлэг, Конго Улсын хуулийн 11-р бүлэг, Гондурасын хуулийн 4(7) дугаар бүлэгт тус тус тусгаагүй байдаг.

Дэд хэсэг (1)(d)-д тусгасан “зохистой” хэмээх утга хэт субъектив бөгөөд хүний эрх, үндсэн эрх чөлөөнд хамаарах эсэх дээр сонголт хийх боломж олгож байна гэж үзсэн тул Загвар хуульд тусгагдаагүй болно.

Хүний эрх хамгаалагчид нь мэдээллийг ямар ч хэлбэрээр олж авах, түгээх эрхтэй хэмээх утгыг тодруулах үүднээс дэд хэсэг (2) -ийг нэмж оруулсан болно. Уг дэд хэсгийг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19(2) дугаар бүлэгт үндэслэн найруулсан болно:

*Хүн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй бөгөөд уг эрх нь мэдээлэл хайх, олж авах, түгээх; юунд ч хязгаарлагдахгүйгээр амаар, бичгээр, хэвлэсэн болон бусад урлагийн хэлбэрээр, хэвлэл мэдээллээр, цахим сүлжээ, цахим бус сүлжээгээр дамжуулан уг эрхээ эдэлнэ.*

## Долдугаар зүйл.

### Хүний эрхийн үзэл санааг хөгжүүлэх, нөлөөлөх эрх

Хүн бүр дангаараа болон бусадтай хамтран хүний эрх, үндсэн эрх чөлөөтэй холбоотой үзэл санаа, зарчмыг хөгжүүлэх, хэлэлцэх болон үзэл санаагаа олон нийтээр хүлээн зөвшөөрүүлэх эрхтэй.

## Тайлбар

Энэ хэсэг нь НҮБ-ын ХЭХ-ын тунхаглалын 7 дугаар зүйлийг үндэслэсэн. Үүнд:

*Хүн бүр хувиараа болон бусадтай нэгдэж, хүний эрхийн талаарх шинэ ойлголт, зарчмуудыг хөгжүүлэн хэлэлцэх болон тэдгээрийг хүлээн зөвшөөрүүлэхэд нөлөөлөх эрхтэй.*

НҮБ-ын тунхаглалын 7 дугаар зүйлд "хүний эрх" гэж заасан байдаг боловч "хүний эрх, үндсэн эрх чөлөө" гэсэн хэллэгийг Загвар хуулийн 8-р хэсэгт тайлбарласантай уялдуулж хэрэглэсэн.

“Хүний эрхтэй холбоотой шинэ үзэл санаа, зарчим” гэсэн ойлголт нь НҮБ-ын тунхаглал батлагдсанаас хойш хүлээн зөвшөөрөгдөж хөгжиж байна. Уг эрхэд хүний бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийлэл дээр суурилсан эрх орно. Үүнд бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэлд олон улсын хүний эрх, эрх зүйг хэрэглэх тухай Жогжакартын зарчмуудад тусгасан эрхүүд багтана.<sup>5</sup>

<sup>5</sup> Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэлд олон улсын хүний эрх, эрх зүйг хэрэглэх тухай Жогжакартын зарчмууд

### **Наймдугаар зүйл.**

#### **Төрийн бус, төрийн болон засгийн газар хоорондын байгууллагатай харилцах эрх**

Хүн бүр дангаараа болон бусадтай хамтран хүний эрх, үндсэн эрх чөлөөний талаар хүний эрхэд хамаарах төрийн бус, төрийн болон засгийн газар хоорондын байгууллага, үүний дотор тэдгээрийн салбар байгууллага, механизм болон шинжээч, дипломат төлөөлөгчтэй харилцах эрхтэй.

#### Тайлбар

Энэ хэсэг нь НҮБ-ын Тунхаглалын 5 дүгээр зүйлд үндэслэсэн. Үүнд:

*Хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах зорилгоор хувь хүн бүр үндэсний болон олон улсын түвшинд дангаараа эсвэл бусадтай эвлэлдэн нэгдэж:*

*с) Төрийн бус байгууллага болон засгийн газар хоорондын байгууллагуудтай харилцах эрхтэй байна.*

Тодорхой болгох үүднээс 9 дүгээр хэсэгт Засгийн газар хоорондын байгууллагуудтай харилцах эрхэд туслах байгууллагууд болон хүний эрхийн механизмуудтай холбоо тогтоох эсвэл эдгээр байгууллагын мэргэжилтнүүдтэй харилцах эрхийг нэмж оруулсан. Мөн Европын холбооны Хүний эрх хамгаалагчдын талаарх удирдамжид заасан дипломат төлөөлөгчийн газруудтай харилцах эрхийг хүлээн зөвшөөрөх үүднээс хэл нэмж оруулсан болно.

### **Есдүгээр зүйл.**

#### **Олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн байгууллага, механизмд хандах, харилцах болон хамтран ажиллах эрх**

Олон улсын гэрээ болон журмын дагуу хүн бүр дангаараа эсвэл бусадтай хамтран олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн байгууллага, механизм, тусгай журам, гэрээний дагуу байгуулагдсан байгууллага, илтгэгчтэй холбогдох, харилцах, хамтран ажиллах эрхтэй байна.

#### Тайлбар

Энэ хэсэг нь НҮБ-ын Тунхаглалын 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт үндэслэсэн. Үүнд:

*Мөн энэ л зорилгоор, олон улсын зохих баримт бичиг, журмын дагуу хүн бүр бие дааж болон бусадтай нэгдэж, нийтлэг буюу тусгай эрх бүхий олон улсын байгууллагуудтай хүний эрх, эрх чөлөөний асуудлаар холбоо харилцаатай байх, саатуулагдашгүй боломжтой байх эрхтэй.*

Зааны ясан эрэг улсын хуулийн 7 дугаар зүйлийг харна уу.

15 дугаар хэсэгт айлган сүрдүүлэлт, хонзогнолоос хамгаалах нь тусдаа ойлголт боловч хоорондоо холбоотой асуудал болох талаар тайлбарласан.

**Аравдугаар зүйл.**  
**Нийтийн үйл хэрэгт оролцох эрх**

1. Хүн бүр дангаараа болон бусадтай хамтран хүний эрх, үндсэн эрх чөлөөтэй холбоотойгоор нийтийн үйл хэрэг эрхлэхэд оролцох, үүний дотор ялгаварлан гадуурхагдахгүйгээр өөрийн улсын төрийн байгууллагын үйл ажиллагаанд оролцох эрхтэй.
2. Энэ зүйлийн 1-т заасан эрх нь
  - a. Төрийн эрх бүхий байгууллага, агентлаг, төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагад хүний эрх, үндсэн эрх чөлөөний талаар шүүмжлэх, санал өгөх эрх;
  - b. Төрийн эрх бүхий байгууллагад хүний эрх, үндсэн эрх чөлөөний талаар хууль тогтоомж, журамд өөрчлөлт оруулах санал зөвлөмж өгөх эрх;
  - c. Төрийн үйл ажиллагааны талбарын хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах ба хангахад саад учруулах, хойш татаж болзошгүй талаар төрийн аль ч байгууллагад сонордуулах эрх;
  - d. Аль ч оролцогч, төрийн эсвэл хувийн хэвшлийн үйлдэл эсвэл эс үйлдлээр хүний эрх ба үндсэн эрх чөлөөг зөрчих эсвэл зөрчихөд хамаарах асуудлаар төрийн аль ч байгууллагын анхаарлыг хандуулах, сонордуулах эрх;
  - e. Бүлэг II-т заасан эрхүүдийг хэрэгжүүлэх талаар төрийн байгууллагад хүргэсэн мэдээллийг чөлөөтэй хэвлэн нийтлэх, бусдад тараах эрхтэй.

Тайлбар

Энэ хэсэг нь НҮБ-ын Тунхаглалын 8 дугаар зүйлд үндэслэсэн. Үүнд:

1. *Хүн бүр дангаараа эсвэл бусадтай нэгдэж, ямар ч алагчлалгүйгээр өөрийн орны засгийн газрын үйл ажиллагаанд оролцох болон олон нийтийн үйл ажиллагааг удирдан явуулахад үр дүнтэйгээр оролцох боломжтой байх эрхтэй.*
2. *Мөн дангаараа эсвэл бусадтай эвлэлдэн нэгдэж, Засгийн газрын байгууллага, агентлаг болон олон нийтийн үйл хэрэгтэй хамааралтай байгууллагад хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн биелүүлэх, хөхиүлэн дэмжих, хамгаалахад саад болж болох тэдний ажлын аль нэг талд анхаарлыг нь хандуулах, тэдний явуулж байгаа үйл ажиллагааг сайжруулахад чиглэгдсэн санал, шүүмжлэл танилцуулах эрхтэй.*

Нийтийн үйл хэрэг эрхлэхэд оролцох эрх нь тухайн улсын бүх хүний эрх хамгаалагчдыг хүлээн зөвшөөрөх, хамгаалах тухай хууль тогтоомжийг боловсруулсны дагуу хүний эрх хамгаалагчдын хэрэгжүүлэх (1) дүгээр дэд хэсэгт заасан том хэмжээний эрх юм.

Олон нийтийн үйл хэрэгт оролцох эрх нь тухайн улсын харьяалалд байдаг бүх хүний эрх хамгаалагчдын өмгөөлөгчдийг хүлээн зөвшөөрөх, хамгаалах тухай хууль боловсруулж буй эрх бөгөөд ингэснээр энэ нь дэд хэсэгт заасан хамрах эрх юм.

Хүний эрх хамгаалагчийн ажлын чухал хэсэг нь хууль тогтоомж, дүрэм журамд шаардлагатай санал, зөвлөмжийг гаргах гэж үзсэн тул (2)(b) дэд хэсэгт тодорхой дурдав.

(2)(d) дэд хэсэгт Непалын хуулийн 3 (5) дугаар зүйлийг үндэслэсэн.

Төрийн эрх бүхий байгууллагуудын мэдээллийг чөлөөтэй хэвлэн нийтэлж, түгээхийг тодорхой болгох зорилгоор (2) (e) дэд хэсэгт оруулсан.

10 дугаар хэсэгт заасан эрхийг хэрэгжүүлэх харилцаа холбооны боломжийг төрийн байгууллагууд үл тоомсорлож болзошгүйг харгалзан төсөл боловсруулагчид дэд хэсэгт "Энэ хэсэгт дурдсан төрлийн мэдээлэл хүлээн авсан аливаа төрийн байгууллага хүлээн авснаа баталгаажуулан ажлын 10 хоногийн дотор бичгээр хариу өгнө" гэж нэмж оруулах хэрэгтэй гэж үзсэн. Уг заалтыг Загвар хуульд дараах хоёр шалтгаанаар оруулах ёсгүй гэж дүгнэсэн. Нэгдүгээрт, ийм шаардлага нь дотоодын нөөц бололцоо хязгаарлагдмал орнуудын хувьд хэтэрхий хүнд байх болно. Хоёрдугаарт, уг заалтгүйгээр "олон нийтийн үйл ажиллагаанд оролцох эрх"-ийг илүү өргөн хүрээнд тайлбарлах боломжтой юм (жишээлбэл, төрийн байгууллагуудад санал хүргүүлэх, хариу өгөх).

### **Арван нэгдүгээр зүйл. Тайван замаар эвлэлдэн нэгдэх эрх**

1. Хүр бүр хүний эрх, үндсэн эрх чөлөөний асуудлаар уулзах, тайван замаар эвлэлдэн нэгдэх, төрийн болон хувийн хэвшлийн дур зоргын эсвэл хууль бус нөлөөллөөс ангид орон нутгийн, улсын, бүс нутгийн болон олон улсын хэмжээний үйл ажиллагаанд оролцох эрхтэй.
2. Энэ зүйлийн 1-т заасан эрх нь хүний эрх, үндсэн эрх чөлөөтэй холбоотой тайван арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, оролцох, мэдээлэл тараах, түүний дотор жагсаал цуглаан хийх, эсэргүүцэх олон нийтийн газар эсвэл бусад газар семинар, уулзалтад оролцох эрхийг агуулна.

#### Тайлбар

Энэ хэсэг нь НҮБ-ын 5 болон 12 дугаар зүйлд үндэслэсэн. 5 дугаар зүйлд:

*Хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах зорилгоор хувь хүн бүр үндэсний болон олон улсын түвшинд хувиараа буюу бусадтай эвлэлдэн нэгдэж:*

*а) Тайван замаар хуран цуглах, цуглаан хийх;*

12 дугаар зүйлд:

1. *Хүн бүр хувиараа болон бусадтай эвлэлдэн нэгдэж, хүний эрх, эрх чөлөөг зөрчихийн эсрэг үйл ажиллагаанд тайван замаар оролцох эрхтэй.*

...

3. *Үүнтэй холбоотойгоор, хүний эрх, эрх чөлөөний зөрчлийн болон мөн хүний эрх, эрх чөлөөгөө сэтгэл хангалуун эдлэхэд нь муугаар нөлөө үзүүлэх бүлэг буюу хувь хүний үйлдсэн хүний эрхийн эсрэг тайван замаар эсэргүүцэл үзүүлэх үйл ажиллагаа, үйлдлүүдэд хувиараа болон бусадтай эвлэлдэн нэгдэж, оролцсон хүн бүр үндэсний хууль тогтоомжийн дагуу үр нөлөөтэйгээр хамгаалуулсан байх эрх олгоно.*

НҮБ-ын Тунхаглалд хүний эрхийг хамгаалагчид жагсаал, цуглаан зохион байгуулах эрхтэй гэж тодорхой заагаагүй болно. Буркина Фасогийн хуулийн 6 дугаар зүйл, Непалын хуулийн 3(5) дугаар зүйл зэрэг дотоодын зарим баримт бичигт тусгасан байдаг.

(1) дэд хэсэгт "төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан болон хувийн байгууллагууд хөндлөнгөөс оролцохгүй" гэсэн нь энэхүү эрхээ хэрэгжүүлэхэд төрийн эрх баригчид болон бусад хүмүүс хөндлөнгөөс оролцохгүй байх болон хөндлөнгөөс оролцохоос сэргийлэх ёстойг тодорхой заасан байна.

Хүний эрх хамгаалагчдын олон нийтийн жагсаал, жагсаал цуглаан хийх эрхийг хязгаарлаж болох хууль тогтоомжийн талаарх асуудлыг шийдвэрлэхийн тулд (2) дахь дэд хэсэгт тайван замаар жагсаал, цуглаан хийх эрх нь тайван замаар жагсаал цуглааны талаар төлөвлөх, оролцох, мэдээлэл түгээх эрхийг багтаасан болохыг тодорхой зааж өгсөн болно.

Иргэний нийгмийн таатай орчин, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхлын хооронд эерэг хамаарал байгаа хэдий ч терроризмтой тэмцэх арга хэмжээг улам боловсронгуй болгож, хүний эрхийг хамгаалагчдын үйл ажиллагааг хязгаарлаж, эрүүгийн хариуцлагад татан оролцуулахад чиглэж байна гэж төсөл санаачлагчид хэлэлцэв. Зөвлөлөөс гаргасан А/HRC/22/6, А/HRC/25/18 тоот тогтоолууд дараах байдлаар зааж өгсөн ч тодорхой үр дүнд хүрэхгүй байна:

*.. терроризмтой тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хадгалах арга хэмжээ ... хүний эрхийг дэмжих, хамгаалах үйл ажиллагаа эрхэлдэг хувь хүн, бүлэг, нийгмийн байгууллагын ажил, аюулгүй байдалд саад болохгүй.*

Хүний эрх хамгаалагчдыг хүлээн зөвшөөрөх, хамгаалах тухай хууль боловсруулахдаа дээрх тогтоолд заасан зарчмуудыг санаж байх хэрэгтэй.

Энэхүү заалт нь 2016 оны Тусгай илтгэгчийн тайван замаар цугларах, эвлэлдэн нэгдэх тухай тайлан, Ассамблейн үйл ажиллагаанд зөвлөмж өгдөг Тусгай илтгэгчийн шүүхээс гадуурх, дур мэдэн цаазаар авах тухай (А/HRC/31/66) тайланд тусгасны дагуу тайлбарлаж, хэрэглэнэ. Түүнчлэн тайван замаар цуглах, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний тухай Тусгай илтгэгчийн 2012 (А/HRC/20/27), 2013 (А/HRC/23/39) оны тайлангуудад чөлөөт ардчилсан нийгэмд тайван замаар цугларахад зөвшөөрөл шаардлагагүй гэж заасан байдаг.

Дээрх тогтоол, тайланд тайван цугларах эрх чөлөөг дараах байдлаар хэрэгжүүлэхээр заасан байна:

*.. төрийн эрх баригчдад олон нийтийн аюулгүй байдал, хэв журам, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах арга хэмжээ авах боломжийг хэрэгжүүлэх үүднээс урьдчилан мэдэгдэх тогтолцоог тэргүүн ээлжинд зохицуулдаг.*

### **Арван хоёрдугаар зүйл.**

#### **Төлөөлөх болон өмгөөлөх эрх**

1. Хүн бүр дангаараа болон бусадтай хамтран хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгалах, хангахад орон нутгийн, үндэсний, бүс нутгийн болон олон улсын хэмжээнд бусад этгээд хувь хүн, бүлэг эсвэл байгууллагад туслалцаа үзүүлэх, тэдгээрийг төлөөлөх, тэдгээрийн нэрийн өмнөөс ажиллах эрхтэй.
2. Энэхүү зүйлийн 1-т заасан эрх нь дараах эрхийг багтаана:
  - a. Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн төрийн байгууллагын бодлого болон үйл ажиллагаанд өргөдөл, гомдол гаргах болон бусад зохистой арга хэрэгслээр дотоодын шүүхийн, захиргааны, хууль тогтоох болон бусад эрх бүхий байгууллагад хандах;
  - b. Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар холбогдох мэргэжлийн хууль зүйн туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх болон бусад туслалцаа үзүүлэх;



- c. Хүний эрх, үндсэн эрх чөлөө болон үндэсний эрх зүйд нийцсэн эсэх талаар өөрийн дүгнэлтээ гаргах зорилгоор нийтийн сонсгол, шүүх ажиллагаанд оролцох эрх;
- d. Энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу мэдээлэл гаргах, өгөх эрх.

### Тайлбар

Энэ хэсэг нь НҮБ-ын тунхаглалын 9 дүгээр зүйлийг үндэслэсэн.

- 2. *Энэ зорилгоор, эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн хэн боловч өөрөө болон хуулийн дагуу эрх олгогдсон төлөөлөөрөө дамжуулан гомдол гаргах, гаргасан гомдлыг нь шударга, бие даасан, эрх бүхий шүүхээр эсвэл хуулийн дагуу байгуулагдсан бусад эрх олгогдсон байгууллагуудаар хэлэлцүүлэхээс өмнө нээлттэй шүүх хурлаар хойшлуулалгүй дахин хянуулах, эрх бүхий байгууллагын шийдвэрээр хуулийн дагуу цагаатгагдах, тухайн хүний эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн нөхөн төлбөр авах, мөн шийдвэрийг хугацааг хойшлуулан саатуулалгүйгээр эцсийн шийдвэр болгон хэрэгжүүлэх эрхтэй.*
- 3. *Мөн энэ л зорилгоор хүн бүр бие дааж болон бусадтай нэгдэж:*
  - a) *Төрийн албан хаагч болон засгийн газрын байгууллагуудаас явуулж байгаа хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн бодлого, үйл ажиллагааны талаар өргөдөл, хүсэлт болон бусад тохиромжтой арга хэрэгслээр дотоодын эрх бүхий шүүх эрх мэдлийн байгууллага, гүйцэтгэх захиргаа болон хуулийн байгууллага, эсвэл Гишүүн орны эрх зүйн тогтолцоогоор эрх олгогдсон бусад байгууллагад гомдол гаргах эрхтэй ба гомдолд гаргасан тэдний шийдвэрийг хугацааг хойшлуулан саатуулалгүйгээр ёсоор болгох ёстой.*
  - b) *Гаргасан гомдол нь үндэсний хууль тогтоомж болон олон улсын өмнө хүлээсэн холбогдох үүрэг хариуцлага болон харилцан зөвшилцсөн үүрэгтэй нийцсэн талаар санаа бодлоо илэрхийлэхийн тулд нээлттэй шүүх хурал, шүүн хэлэлцэх ажиллагаа, шүүх хуралд оролцох эрхтэй.*
  - c) *Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар мэргэжлийн хувьд мэргэисэн хуулийн зөвлөх болон бусад холбогдох зөвлөгөө, туслалцаагаар хангах, санал болгох эрхтэй.*

(2)(с) дэд хэсэгт нь олон хүний эрхийг хамгаалагчдын ажилд шүүхийн үйл ажиллагаанд хяналт тавихын ач холбогдлыг тусгасан. Үүнтэй ижил төстэй заалтыг Гондурасын хуулийн 4(14) дүгээр зүйлээс олж болно.

### **Арван гуравдугаар зүйл.**

#### **Чөлөөтэй зорчих эрх**

- 1. Хүн бүр ..... улсын нутаг дэвсгэр дотор болон түүний бүрэн эрх хэрэгжих, хяналтад буй нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох, хүний эрхийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрхийг эдэлнэ.
- 2. ... улсын нутаг дэвсгэрт хууль ёсны дагуу оршиж буй хүний эрх хамгаалагчийн үүрэг гүйцэтгэсэнтэй нь холбогдуулан хэнийг ч нутаг дэвсгэрээсээ дангаар нь эсвэл нийтийг хамруулсан арга хэмжээний хүрээнд албадан гаргахыг хориглоно.
- 3. Хүний эрх хамгаалагч болох, мөн хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулсных нь төлөө хэнийг ч .... Улсын нутаг дэвсгэрт орох болон гарах эрхийг нь хязгаарлаж болохгүй.

### Тайлбар

НҮБ-ын тунхаглалд зорчих эрхийг заагаагүй боловч бүс нутгийн зөвлөгөөнөөр энэ эрхийг тусгахыг зөвлөсөн юм.<sup>6</sup>

Иргэний ба улс төрийн эрхийн олон улсын пактын 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх дэд хэсэгт “Аливаа улсын нутаг дэвсгэрт хууль бусаар оршин байгаа хэн бүр нь шилжих, оршин суух газраа сонгох эрхтэй” гэж заасан байдаг.

Тус 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг Хүний эрхийн хорооны 27-р ерөнхий зөвлөмжид тусгасан бөгөөд түүний албан ёсны тайлбар юм.

Мөн дээрхээс гадна, энэхүү загвар хуулийн төслийг боловсруулагчид хүний эрх хамгаалагчдыг үйл ажиллагаатай нь холбогдуулан албадан гаргах болон холбогдох улсад нэвтрэх, гаргах эрхийг нь хязгаарлахаас хамгаалах зохицуулалт байх нь зүйтэй гэж үзсэн юм.

### **Арван дөрөвдүгээр зүйл. Хувийн нууцтай байх эрх**

1. Хүн бүр дангаараа болон бусадтай хамтран хувийн нууцтай байх эрхтэй.
2. Энэ зүйлийн 1-т заасан эрх нь хүний эрх хамгаалагч нууцаа хамгаалах, кодлох эрхийг багтаах бөгөөд өөрийн болон гэр бүлийн, гэрийн, албан тасалгааны, эд хөрөнгө, цахим болон цахим бус харилцаа холбооны нууцлалыг хадгалах, халдашгүй байх, хууль бус болон хүч хэрэглэх байдлаас ангид байх эрхийг агуулна.
3. Энэ зүйлийн 2-т заасан халдах гэдэгт хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаатай нь холбогдуулан аливаа хэлбэрээр шалгах, бичлэг хийх, нэгжих болон битүүмжлэх зэргийг ойлгоно.

### Тайлбар

Энэ хэсэг нь Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 12 дугаар зүйлд үндэслэсэн. Үүнд:

*Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааных нь нууц болон нэр төр, алдар хүндэд нь халдах ёсгүй. Тийм оролцоо халдлагын эсрэг хэн ч бай хуулиар хамгаалуулах эрхтэй.*

Энэ томъёоллыг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 17(1) зүйлд тусгасан байдаг. Үүнд:

*Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, орон байранд нь буюу захидал харилцааных нь нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах, эсхүл нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно.*

Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 16 дугаар зүйлд:

*Нэг ч хүүхдийн хувийн болон гэр бүлийн амьдрал, орон байрны халдашгүй байдал болон захидал харилцааны нууцад хөндлөнгөөс, хууль бусаар буюу дур мэдэн оролцох, эсхүл түүний нэр төр, алдар хүндэд хууль бусаар халдаж болохгүй.*

Цагаач ажилтан ба тэдгээрийн гэр бүлийг хамгаалах тухай Олон улсын конвенцийн 14 дүгээр зүйлд:

<sup>6</sup> International Service for Human Rights, Хүний эрх хамгаалагчдын нөхцөл байдлын талаархи бүс нутгийн зөвлөгөөн (2014 оны 10-р сарын 28-29, Тунис улсын Тунис хот) 2-р нүүр. International Service for Human Rights, Хүний эрх хамгаалагчдын нөхцөл байдлын талаархи бүс нутгийн зөвлөгөөн: Зүүн Европ ба Төв Ази (2014 оны 11-р сарын 4-5, Гүрж, Тбилиси) 4-р нүүр.



*Нэг ч цагаач ажилтан ба тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн хувийн болон гэр бүлийн амьдрал, орон байрны халдашгүй байдал болон захидал харилцааны нууцад хөндлөнгөөс, хууль бусаар буюу дур мэдэн оролцох, эсхүл түүний нэр төр, алдар хүндэд хууль бусаар халдаж болохгүй.*

Хүний эрх хамгаалагчийн хувийн нууцтай байх эрхийн хүрээнд өмч хөрөнгө, ажлын байр орохоор өргөжүүлсэн.

Энэ хэсэгт "нэр төр, алдар хүндэд халдах" тухай оруулаагүй 16 дугаар хэсэг (Гүтгэлэг, гутаан доромжлохоос ангид байх эрх)-т заасны дагуу авч үзсэн.

"Цахим ба цахим бус орчны аль алинд нь" гэсэн хэллэг нь дижитал эрин дэх нууцлалын эрхийн тухай НҮБ-ын тогтоолын "хүмүүсийн цахим бус байх үед эдлэх эрх болон хувийн нууцын тухай эрх нь мөн цахим орчинд хамгаалуулах ёстойг баталж байна" гэснийг үндэслэсэн юм.<sup>7</sup>

(3)дэд хэсэгт зөвшөөрөгдөхгүй байж болох зарим хэлбэрийг зааж өгсөн. Хүний эрхийг хамгаалагчид хувийн харилцаатай холбоотой бичлэгээр заналхийлэгдэж байсан нөхцөл байдлын тухай бүс нутгийн зөвлөлдөх уулзалтад дурдсан жишээнүүдийн дагуу төсөл санаачлагчид энэ хэсгийг шаардлагатай гэж үзсэн билээ.<sup>8</sup>

### **Арван тавдугаар зүйл.**

#### **Айлган сүрдүүлэлт, хонзогнолоос ангид байх**

Дангаараа эсвэл бусадтай эвлэлдэн нэгдсэн хэн ч өөрийнх нь статус болон хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаатай нь холбогдуулсан аливаа айлган сүрдүүлэлт, хонзогнолд өртөх ёсгүй.

#### Тайлбар

Энэхүү хэсэг нь НҮБ-ын Тунхаглалын 12 (2) дугаар зүйл, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс айлган сүрдүүлэх, хариу арга хэмжээ авах тухай тогтоолууд, НҮБ-ын Хүний эрхийн гэрээний байгууллагын баталсан Сан-Хосе удирдамжийг үндэслэн боловсруулсан болно.<sup>9</sup> НҮБ-ын Тунхаглалын 12 (2) дугаар зүйлд:

*Улс бүр, энэхүү тунхаглалд дурдсан эрхүүдээ хууль ёсны дагуу эдлэн, дангаараа эсвэл бусадтай эвлэлдэн нэгдэж, заналхийлэл, хонзогнол, хууль болон практик дахь алагчлал, дарамт шахалт, бусад аливаа дур зоргоороо үйлдэл зэрэг аливаа хүчирхийллийн эсрэг тэмцсэн хүн бүрийг эрх бүхий байгууллагаар хамгаалуулах бүхий л арга хэмжээг ханган хэрэгжүүлнэ.*

Уг заалт нь "айлган сүрдүүлэх, хонзогнох" гэсэн нэр томъёонд хялбараар тодорхойлсон байна. "Айлган сүрдүүлэх, хонзогнох" гэсэн тодорхойлолтод хүний эрх хамгаалагчийн гэр бүлийн гишүүд, төлөөлөгчид, түншүүд, мөн хүний эрх хамгаалагчтай холбоотой бүлэг, холбоо, байгууллагын эсрэг хийсэн үйлдэл нь багтахар заасан байна. Энэхүү "айлган сүрдүүлэх, хонзогнох" тухай тодорхойлолт нь "хүний эрх хамгаалагчийн статус, ажил, үйл ажиллагаатай нь холбоотой" үйлдэл, эс үйлдэхүйг хязгаарлаж байгааг тэмдэглэх нь зүйтэй.

<sup>7</sup> НҮБ-ын Ерөнхий Ассемблей, Дижитал эрин үеийн хувийн нууцтай байх эрх, 2014 оны 1-р сарын 21, A/RES/68/167, 3-р параграф.

<sup>8</sup> International Service for Human Rights, Хүний эрх хамгаалагчдын нөхцөл байдлын талаархи бүс нутгийн зөвлөгөөн: Зүүн Европ ба Төв Ази (2014 оны 11-р сарын 4-5, Тбилиси, Гүрж) 6-р нүүр.

<sup>9</sup> НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөл, хүний эрхийн чиглэлээр НҮБ, түүний механизмтай хамтран ажиллах, 2013 оны 10-р сарын 9, A/HRC/RES/24/24.

Мөн энэ хэсэг нь Филиппиний хуулийн 11 дүгээр хэсгийг үндэслэсэн болно.

Энэхүү хэсэг нь Загвар хуулийн 26-р хэсгийн үндэс суурийн нэг юм.

38 (2) дахь хэсэгт заасан "айлган сүрдүүлэх, хонзогнох" гэсэн тодорхойлолтоос харахад хүний эрх хамгаалагчтай албан болон албан бус холбоотой бүлэг, холбоо, байгууллага, олон нийтийн холбоо нь айлган сүрдүүлэлт болон хонзогнолоос ангид байх эрхтэй. Энэ нь байгууллага айлган сүрдүүлсэн, хонзогносон үйлдэлтэй холбоотой гомдол гаргах эрхтэй гэсэн үг юм (18(3) дугаар хэсгийг үзнэ үү).

Мөн, энэ хэсэгт "айлган сүрдүүлэх, хонзогнох" гэсэн тодорхойлолтод харьяалалгүй хүний визийг цуцлах зэрэг нөхцөл байдлыг тусгасан болно.

### **Арван зургадугаар зүйл.**

#### **Гүтгэлэг, гутаан доромжлолоос ангид байх**

Хэнийг ч хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаатай нь холбогдуулан аливаа хэлбэрээр төрийн болон хувийн байгууллага, этгээдийн зүгээс гүтгэх, гутаан доромжлохыг хориглоно.

#### Тайлбар

Бүс нутгийн зөвлөлдөх уулзалтын санал хүсэлтийн дагуу энэхүү хэсэгт хүний эрхийг хамгаалагчдын ажилд үзүүлэх дэмжлэгийг багасгаж байдаг хүний эрхийг хамгаалагчдын өмнө тулгарч буй гол бэрхшээл болох гутаан доромжлох үйлдлийг оруулсан.<sup>10</sup>

НҮБ-ын Тунхаглалд хүний эрхийг хамгаалагчдыг гүтгэх, гутаан доромжлох тухай заагаагүй. Гэсэн хэдий ч Филиппиний хуулийн 11 дэх хэсэг, Буркина Фасогийн хуулийн 12 дахь хэсэг зэрэг дотоодын баримт бичгүүдэд зааж өгсөн байдаг.

### **Арван долдугаар зүйл.**

#### **Соёлын эрхээ хэрэгжүүлэх болон хөгжих эрх**

1. Хүн бүр дангаараа эсвэл бусадтай хамтран хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх болон албан үүргээ гүйцэтгэхдээ соёлын эрхээ хэрэгжүүлэх салшгүй эрхтэй бөгөөд хувь хүний хувьд бүрэн хөгжих эрхтэй.
2. Энэ зүйлийн 1-т заасан эрх нь хүний эрх, үндсэн эрхийг зөрчсөн аливаа уламжлал болон зан зүйлийг эсэргүүцэх, өөрчлөхийг шаардах эрхийг багтаана.

<sup>10</sup> International Service for Human Rights, Хүний эрх хамгаалагчдын нөхцөл байдлын талаархи бүс нутгийн зөвлөгөөн (2015 оны 1-р сарын 26-27, Гватемал улсын Гватемал хот) хуудас 1-2-г үз. International Service for Human Rights, Хүний эрх хамгаалагчдын нөхцөл байдлын талаархи бүс нутгийн зөвлөгөөн: Зүүн Европ ба Төв Ази (2014 оны 11-р сарын 4-5, Тбилиси, Гүрж) 3-р нүүр, International Service for Human Rights, International Service for Human Rights, *Project report: Regional Consultation on Model National Law on the Recognition and Protection of Human Rights Defenders*, 5, 6-р нүүр.

### Тайлбар

Энэ хэсэг нь НҮБ-ын Тунхаглалын 18(1) дүгээр зүйлийг үндэслэсэн:

*Хүн бүр бие хүний чөлөөтэй, өв тэгш хөгжлийг хангаж чадах нийгмийнхээ өмнө тодорхой үүрэг хүлээнэ.*

Энэ хэсэгт заасан эрх нь дараах эрхүүдийг агуулна. Үүнд:

- (1) олон нийтийн соёл нийгмийн үйл ажиллагаанд чөлөөтэй оролцох, оролцохгүй байх;
- (2) олон соёлын өвөрмөц байдлыг чөлөөтэй хөгжүүлэх;
- (3) бусад хүмүүсийн адил соёлын өвийг хүртэх;
- (4) уламжлалт хэл, соёлын байгууллагууд, газар нутаг, талбай, эд зүйлсийг хадгалах, ашиглах;
- (5) соёлыг бий болгох, шүүмжлэх, хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах;
- (6) бусад соёлын хүмүүстэй соёлын уламжлал, зан үйлээ солилцох.

Энэ эрхийг эмзэг, гадуурхагдсан бүлэг болох эмэгтэйчүүд, хүүхдүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, угсаатны болон шашны цөөнх, цагаачид, уугуул иргэд, ядууралд нэрвэгдсэн хүмүүст онцгойлон анхаарч хамгаалах хэрэгтэй.

### **Арван наймдугаар зүйл.**

#### **Үр дүнтэй нөхөн сэргээлгэх, бүрэн нөхөн төлбөр авах эрх**

1. Хэн боловч дангаараа болон хамтдаа энэ хуулийн Хоёрдугаар бүлэг болон 3 дугаар бүлэгт заасан эрхийг нь зөрчсөний төлөө зохистой нөхөн төлбөр авах эрхтэй.
2. Эрх нь зөрчигдсөн хэн боловч шүүх болон бусад эрх бүхий байгууллагад хандан зохистой нөхөн төлбөрийг шаардах эрхийг эдэлнэ.
3. Доорх хүн бүр нь эрх бүхий шүүх байгууллагад энэ хуулийн 2 болон 3 дугаар бүлэгт заасан эрх нь зөрчигдсөний төлөө гомдол гаргах эрхтэй
  - a. Хүний эрх хамгаалагч;
  - b. Хүний эрх хамгаалагчийн хамтрагч;
  - c. Хүний эрх хамгаалагчийн хууль ёсны болон бусад итгэмжлэгдсэн төлөөлөгч болон бусад төлөөлөх эрх бүхий этгээд;
  - d. Хүний эрх хамгаалагчийн гэр бүлийн гишүүн;
  - e. Хүний эрх хамгаалагчийн холбоо бүхий бүлэг, эвсэл, байгууллагын гишүүн;
  - f. Олон нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд болон энэ хуульд заасан эрх бүхий этгээд;
  - g. Энэ хуулийн 4 дүгээр бүлэгт заасан этгээд.

### Тайлбар

(1) дэх дэд хэсэг нь НҮБ-ын Тунхаглалын 9(1) дүгээр зүйлд үндэслэсэн. Үүнд:

*Энэхүү Тунхагдалд дурдагдсанаар хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах зэргээр хүний эрх, эрх чөлөөг ханган биелүүлэх явцад эрх нь зөрчигдсөн тохиолдолд хүн бүр хувиараа болон бусадтай нэгдэж үр дүнтэй арга хэрэгслээр хамгаалуулах эрхтэй.*

Хуулийн II хэсгийг зөрчсөн асуудлаар хүний эрхийг хамгаалагчид шүүхэд хандах эрхтэй болохыг (2) дахь дэд хэсэгт заажээ. (2) дахь дэд хэсэг нь 1982 оны Канадын Эрх ба Эрх чөлөөний дүрмийн 24 (1) дүгээр хэсэгт үндэслэсэн.

Тухайн хэсгийн (3) дэд хэсэгт хамгаалуулах эрхтэй хүмүүсийг тусгасан. Өмнөд Африкийн Үндсэн хуулийн 38 дугаар хэсэгт үүнтэй адил заалтыг заасан. Хүний эрхийг хамгаалагч алга болсон эсвэл нууцаар хоригдож байсан, эсвэл тэдэнтэй холбоотой бүлэг, байгууллагыг хаасан эсвэл татан буулгасан тохиолдолд ч гэсэн (3)(f) дэд хэсгийн дагуу тусламж хүссэн өргөдөл гаргаж болно гэдгийг батлах шаардлагатай.

Энэ хэсэг нь олон улсын хүний эрхийн ноцтой зөрчлүүд болон олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн ноцтой зөрчлийн улмаас хохирогчид учирсан хохирлыг арилгах, нөхөн төлүүлэх эрхийн үндсэн зарчим, удирдамж болох Хүний эрхийн хороо, Ерөнхий тайлбар 31, Пактад оролцогч улсуудын эрх зүйн ерөнхий үүрэг, НҮБ-ын баримт бичиг. CCPR / C / 21 / Rev.1 / Add.13 (2004) зэрэгт тулгуурлана.

### **Арван есдүгээр зүйл.**

#### **Хүний эрх хамгаалагчийн эрхийг хязгаарлах**

Энэ хуулийн 2 дугаар бүлэгт заасан эрхийг дангаараа эсхүл бусадтай хамтран хэрэгжүүлж буй хэний ч эрхийг хууль болон олон улсын гэрээ, стандартад зааснаас гадуур байдлаар хязгаарлаж болохгүй бөгөөд эрхийг нь хязгаарлаж байгаа үндэслэл нь бусдын эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх, нийтийн дэг журмыг хангах болон ардчилсан нийгмийн сайн сайхны төлөө байх үндэслэлтэй, шаардлага бүхий, зохистой байх ёстой.

### Тайлбар

Энэ хэсэг нь НҮБ-ын Тунхаглалын 17 дугаар зүйлд үндэслэсэн. Үүнд:

*Хувиараа болон бусадтай эвлэлдэн нэгдэж үйл ажиллагаа явуулж байгаа хүн бүр Энэхүү Тунхагдалд заасан эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ, зөвхөн холбогдох олон улсын үүрэг хариуцлагын дагуу болон гагцхүү бусдын эрх, эрх чөлөөг зүйн дагуу зөвшөөрөн хүндлэх ёс суртахууны шударга шаардлагыг биелүүлэх, ардчилсан нийгэм дэх хэв журам, бүх нийтийн сайн сайхан байдлыг хангах үүднээс хуулиар тодорхойлсон зохих хязгаарлалтад захируулна.*

Олон улсын хууль тогтоомжийн дагуу зөвшөөрөгдөх хязгаарлалтыг шалгах, тогтоох туршилтыг илүү нарийн тусгахын тулд зөвшөөрөгдсөн хэмжээ гэдгийг нотлох нь эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хамааралтай болохыг тодруулах үүднээс “боломжийн, шаардлагатай, пропорционал” гэсэн үгсийг нэмж оруулсан.

Энэ хэсэгт “ёс суртахууны шаардлагыг хангах зорилгоор” хязгаарлалт хийгээгүй болно. Уг хязгаарлалт хийгээгүй явдал нь хүний эрх хамгаалагчдын, түүний дотор хүний эрх хамгаалагч эмэгтэйчүүдийн болон "уламжлалт үнэт зүйл" эсвэл практикт тулгамдаж буй бусад хүмүүсийн эрхийг дур зоргоор хязгаарлахад зөвтгөхөд ашиглаж болно гэсэн үндэслэлээр орхигдуулсан.

**Хорьдугаар зүйл.  
Бусад эрх, эрх чөлөөг үл хөндөх**

Энэ хуульд заасан зүйл заалт нь хүний эрх хамгаалагчдын эрхийг илүү байдлаар хүлээн зөвшөөрөх болон хамгаалах талаар дотоодын болон олон улсын баримт бичгийг хөндөхгүй болно.

Тайлбар

Энэ нь II хэсэгт заасан эрх нь дотоодын болон олон улсын хууль тогтоомжийн дагуу хүний эрх хамгаалагчдын эрхээс бага хүрээтэй байвал хүний эрх хамгаалагчид илүү өргөн цар хүрээтэй эрхийг эдлэх эрхтэйг тодорхойлох "нэмэлт заалт" заалт юм.

Энэхүү 20 дугаар хэсгийг Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай конвенцийн 37 дугаар зүйлд үндэслэсэн болно.

**Хорин нэгдүгээр зүйл.  
Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах үүрэг хариуцлага**

1. Хүн бүр хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах, хэрэгжүүлэхэд голлох үүрэг гүйцэтгэж, хариуцлага хүлээнэ.
2. Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн болон ардчилсан нийгэм, байгууламж, үйл ажиллагааг үгүйсгэсэн аливаа үйлдэл болон эс үйлдэл хийхгүй байна.

Тайлбар

Энэ хэсэг нь НҮБ-ын Тунхаглалын 18(2) болон (3) дугаар зүйлд үндэслэсэн. Үүнд:

*(2) Бие хүн, бүлэг, байгууллага болон төрийн бус байгууллагууд ардчиллыг хамгаалах, хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, ардчилсан нийгэм, байгууллага, үйл ажиллагааг хөгжүүлэх, хөхиүлэн дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэж, хариуцлага хүлээнэ.*

*(3) Мөн түүнчлэн бие хүн, бүлэг, байгууллага болон төрийн бус байгууллагууд нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон бусад хүний эрхийн баримт бичгүүдэд заан тунхагласан хүн бүр нийгэм, олон улсын эмх цэгцтэй байдалд байх эрхийг хөхиүлэн дэмжихэд боломжийн хирээр хувь нэмэр оруулахад чухал үүрэг гүйцэтгэж, хариуцлага хүлээнэ.*

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ

### Хорин хоёрдугаар зүйл.

#### Хүний эрх хамгаалагчдын эрхийг хүндэтгэх, хөхиүлэн дэмжих, хамгаалах, хэрэгжүүлэх үүрэг

Төрийн эрх бүхий байгууллага нь дараах нөхцлийг бүрдүүлэхэд шаардлагатай арга хэмжээ авна.

- a. Энэ хуулийн 2 дугаар бүлэгт заасан хүний эрх, эрх чөлөөг хангах баталгаажуулах;
- b. Энэ хуулийн 2 дугаар бүлэгт заасан эрхийг зөрчсөн хууль, бодлого, хөтөлбөр батлахгүй байх;
- c. Хүний эрхийн хамгаалагчид нь үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх болон ажиллах аюулгүй нөхцөл бүрдүүлж, эрхийг нь хязгаарлахаас хамгаалах таатай орчинг бий болгох.

#### Тайлбар

Энэхүү 22 дугаар зүйл нь НҮБ-ын Тунхаглалын 2 (2)-т заасныг үндэслэн дараах зүйлийг тусгасан болно:

*Улс бүр энэхүү Тунхаглалд дурдсан эрх, эрх чөлөөг үр дүнтэй баталгаажуулахын тулд шаардлагатай болох бүх хууль тогтоомжийн, захиргааны болон бусад арга хэмжээг авна.*

Үндэсний хэмжээнд тухайн Улсын үүргийг төрийн байгууллагууд нь гүйцэтгэдэг болохыг харгалзан уг зүйл заалтын үг үсгийн найруулгыг өөрчилсөн болно.

Энэ зүйлд НҮБ-ын Тусгай илтгэгчийн Хүний эрх хамгаалагчдын нөхцөл байдлын талаарх сүүлийн үеийн тайланд тусгасан тэдний ажиллах аюулгүй, таатай орчны элементүүдийг тодорхойлсон болно.

Заалт (б) бол санал болгож буй хууль тогтоомжийн энэхүү загвар хуулийн II дугаар бүлэгт заасан эрхүүдтэй нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах тогтоцоог бий болгохыг шаардсан болно. Хавсралт II-т нийтлэг эрх зүйн тогтолцоонд хамаарах болон эх газрын эрх зүйн тогтолцоонд хамаарах жишээг багтаасан зүйл заалтуудын оруулсан болно.

### Хорин гуравдугаар зүйл.

#### Хүний эрх хамгаалагчдын үйл ажиллагаа, ажлыг дэмжих үүрэг

1. Төрийн эрх бүхий байгууллага нь энэ хуулийн 2 дугаар бүлэгт заасан эрхийг хэрэгжүүлэхийг нь дэмжих болон хамгаалах шаардлагатай бүх арга хэмжээг авна.
2. Энэ зүйлийн 1-т заасан нь дараах үүргийг багтаана:
  - a. Хорих болон түр саатуулах байранд хууль заасны дагуу нэвтрэхийг зөвшөөрөх, дэмжих;
  - b. Энэ хуулийн 2 дугаар бүлэгт заасан эрхээ хэрэгжүүлэхэд нь хүний эрхийн хамгаалагчдад шаардлагатай газар нэвтрэх, мэдээлэл авах эрхийг нь хангах;

- c. .... Улсын нутаг дэвсгэрт болон бүрэн эрх хэрэгжүүлж байгаа нутаг дэвсгэрт нь хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн талаар мэдээлэл өгөх;
- d. хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах талаар хүний эрхийн хамгаалагчдын ур чадварыг дэмжих, хангах, дээшлүүлэх бодлого боловсруулах, арга хэмжээ зохион байгуулах;
- e. Хүний эрхийн хамгаалагчдын үйл ажиллагаа, чиг үүрэг, ажлын ач холбогдлыг нийтэд таниулах, хөхиүлэн дэмжих,

### Тайлбар

Энэхүү 23 дугаар зүйл нь Зааны ясан эрэг Улсын холбогдох хуулийн 15 дугаар зүйлд үндэслэсэн.

2) (г) заалт нь Өмнөд Африк Улсын Ашгийн төлөө бус байгууллагуудын тухай 1997 оны 71-р хуулийн 2 (а) болон 3 дугаар зүйлд үндэслэсэн болно.

(2) (д) заалт бол төрийн байгууллагууд нь хүний эрх хамгаалагчдыг дэмжих болон тэдгээрийн ажлын аюулгүй хийгээд нэн таатай орчин бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах чухал асуудлын үүднээс олон нийтийг соён гэгээрүүлэх болон дуу хоолойг нь хүргэх талаар НҮБ-ын Хүний эрх хамгаалагчдын нөхцөл байдал хариуцсан Тусгай илтгэгчийн тодорхойлсон, мөн түүнчлэн бүс нутгийн зөвлөлдөх уулзалтын үеэр тогтоосон шаардлага хэрэгцээнд нийцэж байна.

### **Хорин дөрөвдүгээр зүйл.**

#### **Хүний эрх, үндсэн эрх чөлөөтэй холбоотой материалыг чөлөөтэй авах эрхийг хангах үүрэг**

Төрийн эрх бүхий байгууллага нь дараах баримт бичгийг нийтэд цахим болон цахим бус хэлбэрээр аливаа төлбөргүй олж авах эрхийг хангана. Үүнд:

- a. Хүний эрхийн олон улсын ба бүс нутгийн гэрээ;
- b. Үндсэн хууль, дотоодын хууль тогтоомж;
- c. Хүний эрх, эрх чөлөөтэй холбогдол бүхий судалгаа, шинжилгээ, тайлан, мэдээлэл, архив болон бусад төрийн эрх бүхий байгууллагын эзэмшилд байгаа материал;
- d. Хүний эрхийн олон улсын болон бүс нутгийн байгууллагад илгээсэн ... улсын тайлан ба мэдээлэл;
- e. .... Улсын холбогдох олон улсын ба бүс нутгийн байгууллага дахь хэлэлцүүлгийн протокол, харилцаа холбооны мэдээлэл;
- f. Хүний эрх, эрх чөлөөг хангах талаар ажилладаг эрх бүхий үндэсний байгууллагын шийдвэр, мэдээлэлтэй холбоотой аливаа баримт бичиг, мэдээлэл;
- g. Энэ хуулийн 2 дугаар бүлэгт заасан эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад бүх мэдээлэл болон эдгээр эрхийг зөрчсөнтэй холбоотойгоор нөхөн төлбөр шаардахтай холбоотой мэдээлэл.



### Тайлбар

Энэхүү 24 дүгээр зүйл нь 6 дугаар зүйл дээр нэмэлт байдлаар нөхсөн (Мэдээлэл авахаар хандах, хүлээн авах, түгээх эрх) заалтууд юм.

Энэхүү зүйл нь НҮБ-ын Тунхаглалын 14 дүгээр зүйлд үндэслэн дараах заалтыг тусгасан болно:

1. Тухайн Улс нь өөрийн харьяалалд байгаа бүх хүмүүс өөрсдийн иргэний, улс төрийн, эдийн засгийн, нийгмийн болон соёлын эрхийн талаар ойлголттой болгохыг хөхиүлэн дэмжихэд шаардлагатай хууль тогтоомжийн, шүүхийн, захиргааны болон бусад боломжит арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй.
2. Дараах зүйлээс ийнхүү багц арга хэмжээ нь бүрдэнэ. Үүнд:
  - (а) дотоодын хууль тогтоомж болон дүрэм журам, холбогдох олон улсын хүний эрхийн үндсэн гэрээ хэлэлцээр, баримт бичгүүдийг хэвлэн нийтлэх хийгээд өргөнөөр түгээн дэлгэрүүлэх;
  - (б) Хүний эрхийн талаарх олон улсын баримт бичгүүд, түүний дотор тухайн Улс нь нэгдэн орсон олон улсын хүний эрхийн гэрээ хэлэлцээрийн дагуу байгуулагдсан байгууллагуудад тогтмол гаргаж өгдөг нийт 22 илтгэл тайлан, мөн түүнчлэн эдгээр байгууллага дээр болсон хуралдаан хэлэлцүүлгийн хураангуй тэмдэглэл протокол болон мөн эдгээр байгууллагаас гарсан албан ёсны нийт тайлан илтгэлийг бүрэн гүйцэд болон эрх тэгш олгох.

Мэдээлэл авах эрхийг НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссар нь хүний эрх хамгаалагчид болон иргэний нийгмийн бусад оролцогчдын аюулгүй, таатай орчныг бүрдүүлэхэд нэгэн “зайлшгүй чухал бүрэлдэхүүн хэсэг” гэж хэмээн хүлээн зөвшөөрсөн болно (А / HRC / 32/20-ийг үзнэ үү).

Дээд комиссар нь Улс орнуудыг мэдээллийг өөрсдийн идэвх санаачилгаар ил тод болгох, төрийн байгууллагууд болон хувь этгээдийн аль алины мэдэлд буй хүний эрхийг эдлэх болон хамгаалахад шаардлагатай мэдээллийг авах эрхийг баталгаажуулсан хууль тогтоомж, төрийн бодлого батлахыг илт тодорхой уриалсан билээ (А / HRC / 32/20-ийн 86 (а) заалтуудыг үзнэ үү).

Энэхүү 24 дүгээр зүйл бол хүний эрх хамгаалагчид нь ажил үүргээ гүйцэтгэхэд заавал авах ёстой баримт бичгүүдийн нийт тодорхой ангиллыг зааж өгсөн болно.

### **Хорин тавдугаар зүйл.**

#### **Нууц эх сурвалжийг задруулахгүй байх үүрэг**

1. Төрийн эрх бүхий байгууллага нь хүний эрх хамгаалагчдын мэдээллийн эх сурвалжийг задруулахгүй байх, задруулахыг шаардах эрхгүй.
2. Энэ зүйлийн 1-т өөрөөр заасан ч хүний эрх хамгаалагч бичгээр зөвшөөрөл өгсөн нөхцөлд, эсхүл олон улсын стандарт бүхий хараат болон бие даасан шүүхээс шаардсан нөхцөлд төрийн эрх бүхий байгууллага хүний эрх хамгаалагчдын мэдээллийн эх үүсвэрийг ил тод болгож болно.



### Тайлбар

Энэхүү 25 дугаар зүйлийг нь Зааны ясан эрэг Улсын холбогдох хуулийн 16 дугаар зүйлд үндэслэсэн болно.

### **Хорин зургадугаар зүйл.**

#### **Айлган сүрдүүлэлт, хонзогнолын эсрэг хамгаалалтыг баталгаажуулах, урьдчилан сэргийлэх үүрэг**

1. Төрийн болон хувийн хэвшлийн зүгээс хэнийг ч айлган сүрдүүлэх, хонзогнохоос хамгаалах бүх арга хэмжээг төрийн эрх бүхий байгууллага авна.
2. Энэ зүйлийн 1-т заасан арга хэмжээ гэдэг энэ хуулийн Хавсралт 1-т заасан хамгаалах арга хэмжээг багтаана.

### Тайлбар

Энэхүү зүйл нь 15-р зүйлийн (Айлган сүрдүүлэлт ба хонзогнолоос ангид байх эрх) нэмэлт болно.

Энэхүү зүйл нь НҮБ-ын Тунхаглалын 12.2-р зүйлийн дор дурдсан заалтад үндэслэсэн болно:

*Улс бүр, энэхүү тунхаглалд дурдсан эрхүүдээ хууль ёсны дагуу эдлэн, дангаараа эсвэл бусадтай эвлэлдэн нэгдэж, айлган сүрдүүлэх, хонзогнох, хууль болон практикт алагчлах, дарамт шахалт, бусад аливаа дур зоргоороо үйлдэл зэрэг аливаа хүчирхийллийн эсрэг тэмцсэн хэн бүхнийг эрх бүхий байгууллагаар хамгаалуулах бүхий л арга хэмжээг ханган хэрэгжүүлнэ.*

Уг заалтын текстийг "айлган сүрдүүлэх ба хонзогнох" гэсэн нэр томъёог эш татан хялбаршуулсан болно. "Айлган сүрдүүлэх ба хонзогнох" гэсэн тодорхойлолтод хүний эрх хамгаалагчийн гэр бүлийн гишүүд, түүний төлөөлөгчид буюу хамтрагчид, эсвэл хүний эрх хамгаалагчтай холбоотой бүлэг, холбоо, байгууллагын эсрэг авсан арга хэмжээг багтаасан болохыг тэмдэглэх нь зүйтэй. Түүнчлэн уг тодорхойлолт нь "айлган сүрдүүлэх ба хонзогнох" гэдгийг "хүний эрх хамгаалагчийн статус болон хүний эрх хамгаалагчаар ажиллахтай холбоотой" үйлдэл ба эс үйлдлээр хязгаарлаж байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Ойлгомжтой байлгах үүднээс дэд зүйлд (2) төрийн эрх баригчдын хэрэгжүүлэх үүрэгтэй арга хэмжээнд Хавсралт I-д заасан хамгааллын арга хэмжээг багтаасан болно.

### **Хорин долдугаар зүйл.**

#### **Дур зоргоор, хууль бусаар халдах, хөндлөнгөөс оролцохын эсрэг хамгаалалтыг баталгаажуулах үүрэг**

1. Хүний эрх хамгаалагчдын үйл ажиллагаанд буюу түүний болон гэр бүл, орон гэр, ажлын байр, өмч эд хөрөнгө, харилцаа холбооны хэрэгсэл, цахим болон цахим бус мэдээлэлд хууль бусаар халдах, оролцохоос хамгаалах шаардлагатай бүх арга хэмжээг төрийн эрх бүхий байгууллага авах үүрэг хүлээнэ.
2. Энэ зүйлийн 1-т заасан "халдах ба оролцох" гэдэгт хүний эрхийн хамгаалагчийн зөвшөөрөлгүйгээр түүний болон аливаа хүний хууль ёсны үйл ажиллагааг шалгах, бичлэг хийх, нэгжих, битүүмжлэхийг ойлгоно.

### Тайлбар

26-р зүйлд бүс нутгийн зөвлөлдөх уулзалтаар<sup>11</sup> дэвшүүлсэн асуудлыг хөндсөн бөгөөд, 14-р зүйлийн (Хувийн нууцтай байх эрх) нэмэлт болно. Энэ зүйлд Буркина Фасо Улсын хуулийн 13-р зүйлийн үг хэллэгийг ашигласан болно.

### **Хорин наймдугаар зүйл.**

#### **Мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах үүрэг**

1. Хүний эрх хамгаалагч амь насаа алдсан, сураггүй алга болсон, түүнд эрүү шүүлт тулгасан болон хүнлэг бусаар харьцсан, албадан хууль бусаар саатуулсан, айлган сүрдүүлсэн болон түүний энэ хуулийн 2 дугаар бүлэгт заасан эрхийг [*Улсын нэр*] улсын харьяа нутаг дэвсгэрт төрийн эрх бүхий байгууллага болон хувийн хэвшлийн аливаа төлөөлөгч зөрчсөн гэж үзэх итгэл үнэмшил байгаа бүхий л нөхцөлд [*Эрх бүхий байгууллага*] нь цаг алдалгүй, хараат бус, бие даасан, үр дүнтэй мөрдөн шалгалтыг гүйцэтгэж, холбогдох этгээдийг хуульд заасан журмын дагуу мөрдөн мөшгих үүрэг хүлээнэ.
2. Энэ зүйлийн 1-т заасан мөрдөн шалгах ажлыг хэрэгжүүлэхдээ дараах зүйлийг харгалзана:
  - a. Хүний эрх хамгаалагчийн эрхийг зөрчихөд түүний эрх зүйн байдал, үйл ажиллагаа, ажил болон хүний эрхийн хамгаалагчийн үүрэг нь сэдэл болсон эсэх байдал;
  - b. Хүний эрх хамгаалагчийн эрхийг өмнө нь зөрчиж байсан болон хүний эрхийн хамгаалагчдын эрхийг олноор нь болон төстэй байдлаар зөрчиж байсан байдал;
  - c. Тухайн зөрчлийг олон оролцогчид бэлтгэж, төлөвлөж, тусалсан эсэх талаар нөхцөл байдлыг харгалзана.
3. Энэ зүйлийн 1-т заасан мөрдөн шалгах үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад [*Эрх бүхий байгууллага*] нь энэ хуулийн 34 дүгээр зүйлд заасан механизмыг хэрэглэж, хохирогч, түүний гэр бүл болон холбоотон, хамтрагчид мөрдөн шалгах ажиллагааны талаар мэдээлнэ.
4. Энэ зүйлийн 1-т заасны дагуу мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай туслалцааг [*Улсын нэр*] улс нь холбогдох олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн байгууллагаас хүсэж болно.
5. Энэ зүйлийн 1-т заасан мөрдөн шалгах ажиллагааг холбогдох [*Эрх бүхий байгууллага*] хэрэгжүүлэх чадваргүй эсхүл хүсэхгүй тохиолдолд, [*Улсын нэр*] улс нь ийм мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулахыг олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн байгууллагаас шаардана.

<sup>11</sup> International Service for Human Rights, Хүний эрх хамгаалагчдын нөхцөл байдлын талаархи бүс нутгийн зөвлөгөөн (2014 оны 10-р сарын 28-29, Тунис улсын Тунис хот) 4-р нүүр.

### Тайлбар

Энэ зүйлд заасанчлан хүний эрх, үндсэн эрх чөлөө зөрчигдсөн гэж үзэх баттай үндэслэлийг хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагаагаар тогтоосон бол холбогдох байгууллага уг зөрчлийг шалгах үүрэгтэй.

Энэхүү зүйл нь НҮБ-ын Тунхаглалын 9(5)-р зүйлийн дор дурдсан заалтыг тусгасан болно:

*Улс бүр өөрийн шүүх эрх мэдлийн харьяаллын аливаа нутаг дэвсгэрт хүний эрх, үндсэн эрх чөлөөг зөрчсөн гэж үзэх бодитой үндэслэл байгаа тохиолдолд мөрдөн шалгах ажиллагааг шуурхай бөгөөд шударгаар явуулах буюу мөрдөн шалгах ажиллагаа явуулах нөхцөлөөр хангах ёстой.*

Бүс нутгийн зөвлөлдөх уулзалтын үеэр гаргасан саналыг харгалзан мөрдөн шалгах ажиллагааны тайлбарт “бүрэн гүйцэт” гэсэн үгийг нэмж оруулав.<sup>12</sup> Түүнчлэн төрийн байгууллагууд буюу эрх бүхий байгууллагуудыг татан оролцуулж болзошгүй мөрдөн шалгалтын ажиллагааны талаарх олон улсын хууль эрх зүйг тусгасан "үр дүнтэй", "хараат бус", "шуурхай" гэсэн нэр томъёог нэмж оруулсан.<sup>13</sup>

Уг зүйлийн 2-т бүс нутгийн зөвлөлдөх уулзалтын үеэр хүний эрх хамгаалагчдын эсрэг өдүүлсэн гэмт хэргийг тухайн гэмт хэргийн сэдэл хүний эрх хамгаалагчийн ажил нь байж болзошгүй гэж үзэн мөрдөн байцаалт явуулдаггүй учраас хүний эрх хамгаалагчдын эсрэг системтэй зөрчил байж болзошгүй эсхүл олон тооны хүчирхийлэгч байж болзошгүй гэж дурдсаныг тусгасан.

### **Хорин есдүгээр зүйл.**

#### **Үр дүнтэй нөхөн сэргээлгэх, бүрэн нөхөн төлбөр авахыг баталгаажуулах үүрэг**

Төрийн эрх бүхий байгууллага нь энэ хуулийн 2 дугаар бүлэгт заасан эрхийг зөрчсөн болон 3 дугаар бүлэгт заасан үүргээ биелүүлээгүйн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх болон эрхийг нь сэргээх шаардлагатай бүх арга хэмжээг авах үүрэгтэй.

### Тайлбар

Энэхүү зүйл нь 18-р зүйлийн (Эрхээ сэргээлгэх болон нөхөн төлбөр авах эрх) нэмэлт юм. Эрхийг хангах үүргийг оруулсан нь эрх сэргээх ойлголтод шүүхийн бус арга хэрэгслийг хамруулж болохыг харуулж байна.

*2. Энэ зорилгоор эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзэж байгаа хүн бүр биечлэн буюу хууль ёсны төлөөлөгчөөрөө дамжуулан гомдол гаргах, уг гомдлоо нийтийн сонсголоор хараат бус, шударга, эрх бүхий шүүхийн байгууллага буюу хуулиар тогтоосон бусад байгууллагаар шуурхай хянуулах эрхтэй бөгөөд тухайн хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн тохиолдолд олгох нөхөн төлбөрийг оролцуулан хуульд нийцүүлэн гомдлыг барагдуулах шийдвэрийг уг эрх бүхий байгууллагаас гаргуулан авах, түүнчлэн уг шийдвэр, нөхөн төлбөрийн хэрэгжилтийг цаг алдалгүй хангуулах эрхтэй.*

<sup>12</sup> International Service for Human Rights, *Consultation on the situation and protection needs of human rights defenders from Western European and Others Group States* (22-23 June 2015, Florence, Italy), 9-р нүүр: “Улс орнууд төрийн болон хувийн хэвшлийн этгээдийн зүгээс хүний эрх хамгаалагчдад халдсан хэргийг яаралтай, нарийн мөрдөн шалгаж, шүүх, хэрэг үйлдэгчидтэй хариуцлага тооцох, хохирогчдыг үр дүнтэй нөхөн сэргээхээ баталгаажуулах ёстой”.

<sup>13</sup> *Pueblo Bello Massacre v Colombia* (31 January 2006) Inter-American Court of Human Rights Series C No. 140, 142-р параграф; *Pestaco v The Philippines*, Human Rights Committee, Views: Communication No 942/00, 98th sess, UN Doc CCPR/C/98/D/1619/2007 (11 May 2010); *McKerr v United Kingdom* (2002) 34 EHRR 20.

3. Дээрхтэй ижил зорилгоор хүн бүр бие дааж, эсвэл бусадтай хамтран, дараах эрхийг хэрэгжүүлнэ:

(а) Хүний эрх, үндсэн эрх чөлөөг зөрчсөнтэй холбогдуулан албан тушаалтнууд болон төрийн байгууллагуудын явуулж буй бодлого, үйл ажиллагааны талаар гомдол гаргах буюу бусад зохих арга хэрэгслээр эрх бүхий дотоодын шүүх, захиргааны болон хууль тогтоох байгууллага, эсхүл тухайн улсын эрх зүйн тогтолцоон дахь эрх бүхий бусад байгууллагад гомдол гаргах. Тэдгээр байгууллага уг гомдлыг цаг алдалгүй шийдвэрлэх ёстой;

### **Гучдугаар зүйл.**

#### **Айлган сүрдүүлэлт, хонзогнолыг гэмт хэрэгт тооцох үүрэг**

Төрийн, хувийн хэвшлийн аливаа этгээд хүний эрх хамгаалагчийн ажил эрхлэхтэй нь холбогдуулан түүнийг гутаан доромжлох нь хууль бус үйлдэлд тооцогдох бөгөөд ийм үйлдэл үйлдсэн этгээдийг [эрх бүхий байгууллага] мөрдөн мөшгөх болон зохих шийтгэлийг оногдуулах нөхцлийг бүрдүүлэх ёстой.

#### **Тайлбар**

Энэхүү зүйл нь НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн 4-р зүйлийн 2-р хэсгийн доорх заалтад үндэслэсэн болно:

*(1) Оролцогч улсууд эрүүдэн шүүх бүх үйлдлийг эрүүгийн хуулийн дагуу гэмт хэрэг хэмээн үзнэ. Энэ нь эрүүдэн шүүхийг завдах, түүнд оролцох, хамтран оролцоход хамаарна. (2) Оролцогч улс бүр ийм гэмт хэрэг үйлдэгчид түүний хүнд ноцтой шинжийг харгалзан зохих шийтгэл ноогдуулна.*

Айлган сүрдүүлэх, хонзогнох үйлдэлд оногдуулах шийтгэл нь хүний эрх хамгаалагчдыг заналхийлж, халдах нь тэдний хамгаалж буй хүний эрх, үндсэн эрх чөлөө, ардчилсан нийгэм, институт болон үйл явцыг заналхийлж, халдаж буй хэрэг хэмээн адилтгаж болохыг хүлээн зөвшөөрч, тусгах ёстой.

Буркина Фасогийн хуулийн төсөлд хүний эрх хамгаалагчдыг айлган сүрдүүлэх, тэдний эсрэг хонзогнохтой холбогдуулан хэрэг үүсгэх тухай хэд хэдэн заалт (19-29-р зүйл) багтсан. Эдгээр заалт нь дотоодын хууль тогтоомжид нь айлган сүрдүүлэх, хонзогнох үйлдэлд хэрэг үүсгэх заалт байхгүй аливаа улсад удирдамж болно.

Энэ зүйлийг үндэсний нөхцөлд нийцүүлэн өөрчлөх шаардлага үүсэж болох юм.

### **Гучин нэгдүгээр зүйл.**

#### **Хүний эрхийн боловсролыг түгээх, хөхиүлэн дэмжих үүрэг**

Төрийн байгууллага нь өөрийн харьяа нутаг дэвсгэрт хүний эрх, үндсэн эрх чөлөөний талаарх боловсролыг бүх шатны төрийн байгууллага болон хүн бүрт олгох үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих, холбогдох туслалцаа үзүүлэх, шаардлагатай нөөцийг бий болгох үүрэг хүлээнэ. Хүний эрхийн сургалт, дадлага болон боловсролын хөтөлбөрт энэ хуулийн талаар мэдээлэл болон хүний эрх хамгаалагчдын ажлын ач холбогдлын талаар сургалт багтана.

### Тайлбар

Энэхүү зүйл нь НҮБ-ын Тунхаглалын 15-р зүйлийг хэрэгжүүлж, хүний эрхийн боловсрол буюу мэдээллийн дутмаг байдал, хүний эрх хамгаалагчдын чухал бөгөөд хууль ёсны ажлын талаар бүс нутгийн зөвлөлдөх уулзалтын үеэр гаргасан саналд хариу өгөх зорилготой юм.

### **Гучин хоёрдугаар зүйл.**

#### **Хамгаалах болон яаралтай хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг**

Төрийн байгууллага нь энэ хуулийн 4 дүгээр бүлэгт заасан хамгаалах болон хамгаалалтын яаралтай арга хэмжээг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх бүхий л шаардлагатай арга хэмжээ авах үүрэг хүлээнэ.

### Тайлбар

Энэхүү зүйл нь хүний эрх хамгаалагчдыг хамгаалахад оролцдог эсхүл түүнд хамааралтай төрийн эрх бүхий бүх байгууллага тийм хамгаалалтыг шаардлагатай тохиолдолд өөрсдийн эрх мэдлийн хүрээнд үзүүлэх үүрэгтэй төдийгүй уг үүргийг албадан гүйцэтгэж болохыг баталгаажуулах зорилготой юм.

### **Гучин гуравдугаар зүйл.**

#### **Гадаад улс дахь хүний эрх хамгаалагчдад туслалцаа үзүүлэх**

1. Гадаад улс дахь хүний эрх хамгаалагчдыг статусаар нь, эсвэл хүний эрх хамгаалагчийн ажил, үйл ажиллагаатай нь холбогдуулан айлган сүрдүүлсэн, хонзогносон, эсвэл ийм байдалд өртөж болзошгүй тохиолдолд төрийн байгууллага өөрийн эрх мэдлийн хүрээнд болон олон улсын гэрээ, стандартын дагуу туслалцаа үзүүлэх шаардлагатай бүхий л арга хэмжээ авна.
2. Энэ зүйлийн 1-т заасан туслалцаа нь хүний эрх хамгаалагчийн харьяалал, айлган сүрдүүлэлт, хонзогнолын шинж чанараас хамааран дараах зүйлийг багтааж болно:
  - a. Тухайн хамгаалагчийг түүний байгаа улс дахь дипломат төлөөлөгчийн газар байлгах, түүний гэр болон ажлын байр, хоригдсон эсхүл саатуулагдсан газар нь очиж нөхцөл байдалтай танилцах;
  - b. Хүний эрх хамгаалагчийг албан ёсоор ил тод болон хаалтай байдлаар төлөөлөх;
  - c. Хүний эрх хамгаалагчид холбогдох хэрэг, шүүх ажиллагаанд оролцох, ажиглах;
  - d. Хүний эрх хамгаалагчийн байдлыг ажиглах, тайлан бэлтгэх;
  - e. Яаралтай зорчих аялах баримт бичиг гаргаж өгөх;
  - f. Эмнэлгийн тусламж үзүүлэх;
  - g. Орон нутгийн хамгаалагчдын талаар мэдээлэл өгөх;
  - h. Орон нутгийн орчуулагчдын талаар мэдээлэл өгөх;

- i. Хүний эрх хамгаалагчийн гэр бүлийн гишүүдтэй холбоо барих;
- j. Хүний эрх хамгаалагчийг аюулгүй газар хүргэж өгөхөд хүн дагалдуулах, нүүлгэх ажлыг зохион байгуулах;
- k. Санхүүгийн тусламж үзүүлэх;
- l. Хүний эрх хамгаалагчийг аюулгүй газар хүргэхэд шаардлагатай яаралтай зардлыг гаргах.

#### Тайлбар

Хуулийн өмнөх зүйлүүдээс ялгаатай нь энэхүү зүйлд тухайн улсаас гадна байрладаг хүний эрх хамгаалагчдад төрөөс хэрхэн хандах болон тэдэнд үзүүлэх тусламжийн тухай авч үзсэн.

Энэхүү зүйлд тухайн улсын дотоодын хууль тогтоомж нь гадаадад байгаа өөрийн иргэдийг хамгаалахтай холбоотой олон улсын хууль тогтоомжид зааснаас илүү өргөн хүрээтэй үүрэг хүлээдэг нөхцөлд тухайн улс тэрхүү илүү өргөн хүрээтэй үүргийг хүлээх ёстойг баталгаажуулахын тулд олон улсын эрх зүйгээс гадна үндэсний хууль тогтоомжийн талаар тусгасан.

Тухайн улсын харьяат болон иргэдийн хувьд дотоодын болон олон улсын ийм хууль тогтоомж нь тухайн хүнийг гадаадад байх үед нь туслалцаа үзүүлэх үүрэг хүлээлгэх буюу тийнхүү туслалцаа үзүүлэхийг албадаж болно. Иргэний харьяалалгүй хүмүүст туслалцаа үзүүлэх үүрэг хүлээхгүй боловч Европын Холбооны Хүний эрх хамгаалагчдыг хамгаалах тухай удирдамж, Швейцарь, Финлянд, Ирланд, Норвеги, Нидерланд зэрэг улс орнуудын баталсан үндэсний удирдамжид тусгасанчлан сайн туршлага хэмээн улам бүр хүлээн зөвшөөрөх болсон байна.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧИЙГ ХАМГААЛАХ МЕХАНИЗМ

### Тайлбар

Улс бүр нь хүний эрх хамгаалагчдыг хамгаалах хангалттай, бүрэн болон үр дүнтэй механизм бий болгох эсхүл бий болгохыг даалгах үүрэгтэй. Энэхүү механизмыг тусгайлан байгуулсан байгууллага эсхүл эрх олгогдсон хараат бус байгууллага нэгж удирдан зохион байгуулах болно.

Улс нь олон төрлийн хэрэгжүүлэх механизм, хөтөлбөрөөс сонгож болох бөгөөд улс бүрд харилцан өөр механизмыг хэрэгжүүлэх боломжтой. Нөгөө талаасаа улс аль ч тогтолцоо хөтөлбөрийг сонгосон дараах зарчмыг заавал удирдлага болгоно.

- 1) Хөтөлбөр болон механизм нь хүний эрх хамгаалагчидтай сайтар зөвшилцсөний үндсэн дээр боловсруулж, хэрэгжих болон үнэлэх боломжтой байх ёстой бөгөөд хөтөлбөр тогтолцоог боловсруулах, удирдах, шийдвэр гаргахад хүний эрх хамгаалагчдыг оролцуулах ёстой;
- 2) Хөтөлбөр, механизмыг дотоодын хууль тогтоомжоор баталсан байна;
- 3) Хөтөлбөр болон механизм нь төрөөс хараат бус байж, төр, захиргааны байгууллагын хяналт болон түүний бие даасан байдалд сөргөөр нөлөөлөх санхүүгийн хяналтаас ангид байх ёстой;
- 4) Хөтөлбөр болон механизмыг хангалттай болон тогтвортой санхүүжүүлдэг байна;
- 5) Хөтөлбөр болон механизм нь хүний эрхийн хамгаалагчдад аюулгүй болон үйл ажиллагаа явуулах боломжтой нөхцөлийг хангах арга хэмжээг багтаахаас гадна, аливаа заналхийлэл, эрсдэл, хязгаарлалтаас хамгаалах, хүний эрхийн хамгаалагчдын эрсдэлтэй нөхцөлд шуурхай болон удаан хугацаанд хамгаалж чадах нөхцлийг бүрдүүлсэн байна;
- 6) Хөтөлбөр болон механизм нь эрсдлийг үүсгэх тогтолцооны болон нөхцөл байдлыг илрүүлэх болон тогтоох, холбогдох хамгаалагчдад үнэлгээ өгөх агуулгатай байна;
- 7) Хөтөлбөр болон механизм нь холбогдох бүлэг хамгаалагч, хамгаалагч эмэгтэйчүүдэд үүссэн эрсдэлийн тогтолцооны болон нөхцөл байдлыг илрүүлэх болон тогтоох боломжтой байдлаар боловсруулагдаж, хэрэгжих агуулгатай байх төдийгүй, жендерийн онцлогийг тусгасан байна;
- 8) Хөтөлбөр болон механизмыг боловсруулахдаа ашиг тус хүртэгчийн эрсдэлийн мөн чанар, хүйс, хүйсийн тодорхойлолт ба бэлгийн чиг баримжаа, үндэс угсаа, нас, эрүүл мэнд, гэр бүлийн нөхцөл, газар зүйн байрлал, эдийн засаг, нийгмийн байдал, хувь хүний болон бүлэгт хамаарах мөн чанарыг нь харгалзан үзэж хамгаалах онцгой тусгайлсан арга хэмжээг багтаах ёстой. Эдгээр арга хэмжээг нарийн эрсдэлийн үнэлгээ хийх арга зүйг баримталж болон холбогдох хүмүүстэй зөвшилцсөний дараа тодорхойлох ёстой;
- 9) Хөтөлбөр болон механизм нь хүний эрх хамгаалагч, тэдгээрийн гэр бүлийн гишүүд, хамтрагчийн аюулгүй байдлыг цогцоор нь хангах агуулгатай байх бөгөөд энэ нь бие сэтгэл нь халдашгүй байх болон мэдээллийн аюулгүй байдлыг багтаана;



10) Хүний эрх хамгаалагчдыг хамгаалах аливаа төлөвлөгөө болон арга хэмжээ нь тэдгээрийн үйл ажиллагаанд оролцохгүй байх болон үйл ажиллагааг нь дэмжих агуулгатай байна;

11) Хөтөлбөр болон механизмыг хэрэгжүүлэх албан тушаалтан, ажилтан нь тусгайлан сайтар бэлтгэгдсэн, нөхцөл байдал болон хамгаалагч эмэгтэйчүүдийн эрх ашгийг хамгаалах нөхцөл, олон удаагийн давтамжтай, тогтмол ялгаварлан гадуурхах тогтолцоонд бэлтгэгдсэн байх ёстой;

12) Хөтөлбөр болон тогтолцоо нь Тунхаглалыг бүрэн болон үр дүнтэйгээр хэрэгжүүлэх байдлыг дэмжих, хангах болон илтгэх нөхцөлийг бүрдүүлж, парламент, засгийн газарт тайлангийн зүйл заалтаар дамжуулж зөвлөмж өгөх, олон улсын болон бүс нутгийн байгууллагатай хамтран ажиллах нөхцлийг агуулсан байна.

Эдгээр үндсэн зарчмыг Тунхаглалын тайлбар, Хүний эрх хамгаалагчдын нөхцөл байдлын асуудлаарх Тусгай илтгэгчийн 2016 оны Гуравдугаар сарын тайлан (A/HRC/31/55), Бразил, Мексик, Гондурас дахь нөхцөл байдал, бүх бүсийн хүний эрхийн хамгаалагчдын байдлын талаар бүсийн зөвлөмж зэргийг үндэслэж боловсруулсан болно.

Энэ хуулийн 4 дүгээр бүлгийг дээрх үндсэн зарчмыг үндэслэж бэлтгэсэн бөгөөд үйл ажиллагаанд баримтлах удирдамж гэж санал болгосон юм. Нөгөө талаасаа янз бүрийн модель загвараас тухайн үндэстний онцлог, эрх зүйн болон үндсэн хуулийн тогтолцоонд тохирсон моделийг сонгох боломжтой юм. Тухайлбал Парисын тунхаглалд заасны дагуу хүний эрхийн үндэстний байгууллагын хүрээнд тогтолцоог бий болгох, эсхүл 4 дүгээр бүлэгт зааснаар нарийвчилсан үйл ажиллагааны зохицуулалтыг хууль тогтоомж, журмаар тодорхойлох боломжтой.

### **Гучин дөрөвдүгээр зүйл.**

#### **Хүний эрх хамгаалагчдыг хамгаалах тогтолцоог бий болгох**

- 1) Эрх бүхий байгууллага ..... нь хүний эрх хамгаалагчдыг хамгаалах механизмыг боловсруулж байгуулах бөгөөд тус байгууллага нь хүний эрх хамгаалагчдыг хамгаалах хариуцлага хүлээж, тус улсын ..... иргэний нийгмийн байгууллага, хүний эрхийн үндэстний байгууллагатай хамтран ажиллах, зөвшилцөх үүрэг хүлээнэ.
- 2) Энэхүү механизм нь дараах чиг үүрэгтэй байна:
  - a) айлган сүрдүүлэлт, хонзогнолоос урьдчилан сэргийлэх;
  - b) хүний эрх хамгаалагчдыг айлган сүрдүүлэлт, хонзогнолоос хамгаалах;
  - c) айлган сүрдүүлсэн, хонзогносон үйлдлийг мөрдөн шалгаж, хариуцлага хүлээлгэхийг баталгаажуулахад туслах;
  - d) айлган сүрдүүлсэн, хонзогносон аливаа үйлдлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах, хариуцлага хүлээлгэх талаар байгууллага хоорондын болон салбар хоорондын хамтын ажиллагааг дэмжих, туслалцаа үзүүлэх;
  - e) хүний эрх хамгаалагчдын ажлын хууль ёс болон чухал үүрэг, чиг үүрэг, үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих, нийтэд ойлгуулах.



- 3) Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор үндэсний механизм, байгууллага нь дараах эрхийг эдэлнэ:
- a) хүний эрх хамгаалагчдын аюулгүй байдалд заналхийлсэн аливаа нөхцөл байдлыг судлах, хянах болон хамгаалах, үйл ажиллагаагаа аюулгүй болон зохих ёсоор хэрэгжүүлэхэд нөхцөлийг анхаарах;
  - b) энэ хуулийг хэрэгжүүлэх зорилгоор бусад хүний эрх хамгаалагчтай зөвлөлдөх ба ойрхон ажиллах, хамтран ажиллах;
  - c) энэ хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах, мөн энэ зорилгоор хууль хүчин төгөлдөр болохоос 180 хоногийн өмнө хуульд нэмэлт өөрчлөлтийн төсөл, удирдамж бэлтгэх;
  - d) хүний эрх хамгаалагчдыг хамгаалах тусгай хэрэгцээ шаардлагыг тодорхойлох зорилгоор эрсдэл, эмзэг нөхцөл байдал, зөрчилдөөн, хүйсийн онцлог, хамтын эрсдлийг тооцоолж, үнэлгээ өгөх;
  - e) энэ хуулийн 28 дугаар зүйлд заасан хууль зөрчсөн үйлдийг мөрдөн мөшгөх зорилгоор мөрдөн шалгах ажиллагаанд туслах, мэдээлэл өгөх;
  - f) хүний эрх хамгаалагчдын байдал, үйл ажиллагаа, ажилд нөлөөлөх аливаа зохицуулалтын нөлөөний талаар судлах, хянах болон төсөл бэлтгэх, холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэх, шаардлагатай нөхцөлд нэмэлт өөрчлөлтийн санал өгөх;
  - g) энэ хуулийн дагуу хүний эрх хамгаалагчдыг хамгаалах болон баталгаа өгөх хөтөлбөр бодлого хэрэгжүүлэх, боловсруулах талаар засгийн газрын бүх салбарт зөвлөгөө өгөх;
  - h) .... Улс дахь хүний эрх хамгаалагчдын байдлын талаар жил бүр хяналт хийж, тайлан бэлтгэх болон холбогдох байгууллагад тэдгээрийн аюулгүй байдал, ажлын таатай орчинг бүрдүүлэх зохистой арга хэмжээний талаар санал зөвлөмж боловсруулах, эрсдлээс хамгаалах, эрсдлийг сааруулах зорилгоор хүний эрх хамгаалагчдын эсрэг аливаа зөрчлийн шалтгааныг илрүүлэх;
  - i) хүний эрх хамгаалагчдын амь нас, шударга ёс, эрх чөлөө, аюулгүй байдал, ажлын баталгааг хангах арга хэмжээг санал болгох, хэрэгжүүлэх, хангах болон эмэгтэй хүний эрх хамгаалагчид болон илүү эрсдэлтэй хамгаалагчдын хэрэгцээ, шаардлагыг анхаарч, тэднийг хамгаалах болон нөхцөл байдлыг авч үзэхэд анхаарах;
  - j) хүний эрх хамгаалагчдыг хамгаалах хариуцлага хүлээж буй ажилтны эрх зүйн байдал, чиг үүрэг, тэдгээрийг сонгох журам, орлого, сургалтын талаар эрх бүхий байгууллагад зөвлөх;
  - k) хамгаалах арга хэмжээний талаар өргөдөл хүлээн авах, үнэлгээ өгөх, шаардлагатай болон яаралтай хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх, энэ талаар бусад холбогдох байгууллагатай хамтран ажиллах;
  - l) хүний эрх хамгаалагчдыг хамгаалах хөтөлбөрийн талаар нийтэд мэдээлэх, тэдгээрийг олж авах аргыг зааж өгөх, механизмын ажил болон нөөцийг хуваарилах ажилд ил тод байдлыг хангах;

- m) Нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг дэмжих, хамгаалах талаар хувь хүн, бүлэг хүн, иргэний нийгмийн байгууллагын эрх, хариуцлагын талаар НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Тунхаглал болон хүний эрхийн хамгаалагчдын чухал үүрэг, чиг үүрэг, ажлын талаар байгууллага болон нийтэд мэдээлэл түгээх;
- n) ... улс дахь хүний эрх хамгаалагчдын нөхцөл байдлын талаар тайлан, захидал олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн байгууллагад өгөх.
- 4) Хамгаалах тогтолцоо нь хүний эрх хамгаалагчдын талаар хувийн мэдээлэл болон энэ хуулийн 38.2.b-e хэсэгт заасан мэдээллийн нууцыг хадгалж хүндэтгэх зарчимд тулгуурлана. Уг механизмын хүрээнд бие даасан шинжээчтэй хамтран, иргэний нийгмийн төлөөлөгчидтэй зөвшилцөн тогтолцооны үйл ажиллагааны хүрээнд олж авсан мэдээллийг ашиглах болон электрон мэдээллийн аюулгүй байдлыг хангах, бусад байгууллага уг мэдээлэлтэй танилцах заавал биелүүлэгдэх шинжтэй журам боловсруулна.
- 5) Хараат бус шинжээчидтэй хамтран болон иргэний нийгмийн төлөөлөгчидтэй зөвшилцөн, механизм нь энэ хуулийн хэрэгжилт болон хамгаалах тогтолцооны үр дүнгийн талаар тогтмол хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ. Энэхүү хянан шалгах эхний ажиллагааг энэ хууль батлагдсаны дараа 18 сарын дотор хийнэ.

#### Тайлбар

Энэхүү зүйл нь НҮБ-ын Тунхаглалын 14-р зүйлийн 3-т дурдсан доорх заалтад үндэслэсэн болно:

*Гишүүн орон нь өөрийн шүүх эрх мэдлийн хүрэн дэх бүх нутаг дэвсгэрт хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах зорилгоор үндэсний бие даасан хараат бус бусад байгууллагуудыг бий болгох, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ёстой бөгөөд тэдгээр нь омбудсман, хүний эрхийн комисс буюу бусад хэлбэрийн үндэсний байгууллага байж болно.*

“Байгуулах, томилох болон дэмжлэг үзүүлэх” гэсэн нэр томъёог Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт протоколын 17-р зүйлээс авсан.

Тухайн хүний эрх хамгаалагчдыг хамгаалах үндэсний байгууллагын үнэ цэнийг Хүний эрхийн зөвлөлийн хэд хэдэн баримт бичигт онцлон тэмдэглэсэн байдаг. Түүний дотор ХЭЗ-ийн 13/13-р тогтоолд ийнхүү заасан байдаг:

*Улс орнууд хүний эрх хамгаалагчидтай зөвлөлдөх, яриа хэлэлцээ хийх механизмыг бий болгож, бэхжүүлэх, түүний дотор төрийн захиргааны байгууллагад хэрэв тийм бүтэц байхгүй бол хүний эрх хамгаалагчдыг хариуцсан төв нэгжийг бий болгох замаар хамгааллын тусгай хэрэгцээ, түүний дотор эмэгтэй хүний эрх хамгаалагчдыг хамгаалах тусгай хэрэгцээг тодорхойлох, зорилтот хамгааллын арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэхэд хүний эрх хамгаалагчдын оролцоог хангахыг уриалж байна.<sup>14</sup>*

<sup>14</sup> НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөл, Хүний эрх хамгаалагчдын хамгаалалт, 2010 оны 4-р сарын 15, A/HRC/RES/13/13, 5-р параграф

НҮБ-ын Тунхаглалын тайлбарт улс орнууд хүний эрхийн хамгаалагчдын эсрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх хамгааллын механизмыг бий болгохыг зөвлөмж болгосон бөгөөд тэдгээр механизм нь дараах шинж чанарыг агуулах ёстой:

- (a) хүний эрх хамгаалагчидтай зөвлөлдсөний үндсэн дээр байгуулж, үйл ажиллагаагаа явуулах;
- (b) хуулийн дагуу байгуулах буюу тодорхойлох;
- (c) хангалттай бөгөөд тогтвортой нөөцтэй байх;
- (d) хүйс, оршин суугаа газрын онцлог байдал зэргийг оролцуулан хүний эрх хамгаалагчдын онцлогт нийцсэн хамгаалалтын арга хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлэх эрх мэдлээр хангах;
- (e) хүний эрх, жендэрийн асуудал, Хүний эрх хамгаалагчдын тухай тунхаглалын талаар тодорхой сургалтад хамрагдсан ажилтнуудаар хүний нөөцийг хангах.

(Хүний эрх хамгаалагчийн асуудлаарх Тусгай Илтгэгчийн тайлан ба Тайлбар хуудас 21-ийг үзнэ үү. A/HRC/13/22) Ийм механизмыг бие даасан хэлбэрээр байгуулж болохоос гадна хүний эрхийн үндэсний байгууллагын дүрмээр чиг үүрэг оноож болно. Үүнтэй холбогдуулан ХЭЗ-ийн 22/6-р тогтоолд доорх зүйлсийг тусгасан:

*.. Парисын зарчмуудын дагуу байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулж буй үндэсний хүний эрхийн байгууллагуудын хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжид үргэлжлүүлэн хөндлөнгийн хяналт тавих, тэдгээрийн хүний эрхийн хамгаалагчдын үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөллийн талаар төрд тогтмол мэдээлэх, түүнчлэн холбогдох зөвлөмж өгөх зэрэг нь өндөр ач холбогдолтой болохыг онцолж байна.*<sup>15</sup>

Хүний эрх хамгаалагчдын нөхцөл байдлын асуудлаарх Тусгай илтгэгчийн тайланд (Тусгай илтгэгчийн тайлан) (A/HRC / 25/55, 2013 оны 12-р сарын 23-ны өдөр) хүний эрхийн хамгаалагчид үйл ажиллагаагаа аюулгүй бөгөөд таатай орчинд явуулахад шаардлагатай үндсэн элементүүдийг нарийвчлан тодорхойлсон бөгөөд Тусгай илтгэгч үндэсний хүний эрхийн байгууллагууд хүний эрх хамгаалагчдыг хамгаалахад амин чухал үүрэг гүйцэтгэж чадна гэдгийг онцолсон. (79-р догол мөрийг үзнэ үү).

Тусгай илтгэгч хүний эрхийн үндэсний байгууллагууд энэхүү амин чухал үүргээ гүйцэтгэхийн тулд дараах чиг үүргийг хэрэгжүүлэхийг зөвлөсөн (80 - 82-р догол мөрийг үзнэ үү):

- (a) хүний эрх хамгаалагчдын нөхцөл байдалд хөндлөнгийн хяналт тавих, түүний дотор тэдний аюулгүй байдалд учрах эрсдэл, хамгаалагчдын аюулгүй, таатай орчинд ажиллахад учирч байгаа хууль эрх зүйн болон бусад саад тотгорыг хянах үүрэг бүхий төв нэгжийг томилон ажиллуулах;
- (b) хүний эрх хамгаалагчдын үйл ажиллагааг зохицуулдаг хууль эрх зүй, захиргааны тогтолцоонд хөндлөнгийн хяналт тавих, хамгаалагчдын ажилд хууль тогтоомжийн үзүүлэх нөлөө болон болзошгүй нөлөөллийн талаар төрд мэдээлэх;

<sup>15</sup> НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөл, *Protecting human rights defenders*, 12 April 2013, A/HRC/RES/22/6, 16-р параграф

(с) хамгаалагчдад зориулсан хамгааллын хөтөлбөрүүд байгаа тохиолдолд тэдгээрийн талаар мэдээлэл түгээх, ингэхдээ тэдгээрийн дизайн, хэрэгжилт, үнэлгээнд хамгаалагчдын оролцоог хангах.

Энэ зүйлд дурдсан Механизмын чиг үүргийг Тайлбар хэсэг дэх зөвлөмж, Тусгай илтгэгчийн илтгэлүүд, түүнчлэн Мексикийн болон Гондурасын хууль зэрэг үндэсний хууль тогтоомжоос авч ашигласан.

Улс бүр иргэний нийгэмтэй зөвшилцөн өөрийн засаглалын тогтолцоонд тохирсон хүний эрх хамгаалагчдыг хамгаалах үндэсний механизмын нарийвчилсан бүтцийг тодорхойлох ёстой. Ашиглахад хялбар байх үүднээс энэхүү Загвар хуульд Хүний эрх хамгаалагчдыг хамгаалах механизм гэж нэрлэсэн нэг байгууллагыг бий болгосон. Гэхдээ энэхүү Загвар хуулийн илүү чухал суурь бол уг үндэсний механизмын гүйцэтгэж буй чиг үүрэг юм. Улсууд эдгээр чиг үүргийг хүний эрх хамгаалагчдыг хамгаалах үндэсний механизмыг бүрдүүлдэг өөр байгууллагуудад оногдуулж болно.

Хэрэв тухайн улс Парисын зарчимд нийцсэн үндэсний хүний эрхийн байгууллагатай бол энэхүү зүйлийг уг байгууллагад энэ зүйлд дурдсан үүрэг хариуцлага болон чиг үүргийг оноох байдлаар томъёолж болно. Эдгээр нэмэлт үүрэг хариуцлага болон чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд тухайн байгууллагыг зохих нөөцөөр хангах ёстой. Хэрэв тухайн байгууллага энэ үүргийг гүйцэтгэхгүй бол уг зүйлд үндэсний механизмыг хүний эрхийн үндэсний байгууллагатай нягт хамтран ажиллахыг шаардах ёстой.

Энэхүү зүйлийн дагуу үндэсний тусгай механизмыг бий болгосон тохиолдолд энэ зүйлд заасан үүрэг хариуцлага болон чиг үүргийг хүлээх ёстой. Энэ зүйлд үндэсний механизмын нэг хэсэг болох төрийн байгууллагуудын үүрэг роль, үндэсний механизмд багтдаг бусад төрийн байгууллагуудтай харилцах харилцааг тусгах нь зүйтэй.

Мексикийн хууль, Гондурасын хууль зэрэг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид хүний эрх хамгаалагчдыг хамгаалах үндэсний механизм нь ерөнхийдөө гурван үндсэн хэсгээс бүрддэг: (1) эцсийн шийдвэр гаргаж, шаардлагатай зөвшөөрлийг өгдөг удирдах байгууллага; (2) асуудлыг хэлэлцэж, удирдах байгууллагад зөвлөгөө өгдөг зөвлөх /зөвлөлдөх байгууллага; болон (3) үндэсний механизмын техникийн ажлыг гүйцэтгэдэг, удирдах байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлдэг гүйцэтгэх байгууллага/ нарийн бичгийн дарга нарын газар.

Хүний эрх хамгаалагчдыг хамгаалах үндэсний механизмын бүтэц бүрэлдэхүүн ямар байхаас үл хамааран эцсийн хариуцлага нь түүний хэрэгжилт, үр нөлөөг баталгаажуулах ёстой Төрийн тэргүүн, Засгийн газрын тэргүүнд хамаарна гэдгийг онцлон тэмдэглэх нь чухал юм. Хүний эрх хамгаалагчдыг хамгаалах тухай хууль, бодлогыг хэрэгжүүлэхэд тулгарч буй иргэний нийгмийн тодорхойлсон алдаа дутагдлын нэг бол улс төрийн өндөр түвшний дэмжлэг байхгүй байгаа явдал юм.

#### *Мексикийн хууль*

Мексикийн хуульд зааснаар Мексикийн хуулийн зорилтыг хэрэгжүүлэх механизм үндсэн гурван байгууллагаас бүрдэнэ: (1) Удирдах зөвлөл; (2) Зөвлөлдөх зөвлөл; (3) Үндэсний Гүйцэтгэх Зохицуулалтын Алба.

Удирдах зөвлөл нь хүний эрх хамгаалагчид, сэтгүүлчдийг хамгаалах механизмын дээд эрх мэдлийг хэрэгжүүлэгч бөгөөд шийдвэр гаргах гол байгууллага юм. Зөвлөл дэх иргэний

нийгмийн төлөөллийг хуулиар баталгаажуулсан болно. Мексикийн хуулийн 8-р зүйлд Удирдах зөвлөлийн бүрэн эрхийг тодорхойлсон.

Зөвлөлдөх зөвлөл нь Удирдах зөвлөлийн иргэний нийгмийн төлөөллөөс бүрдсэн зөвлөлдөх байгууллага юм. Зөвлөлдөх зөвлөлийн бүрэн эрхийг Мексикийн хуулийн 16-р зүйлд тодорхойлсон.

Үндэсний Гүйцэтгэх Зохицуулалтын алба нь муж улсууд, холбооны төрийн захиргааны агентлагууд болон бие даасан байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэгтэй техникийн байгууллага юм. Уг алба нь гурван туслах хэсгээс бүрдэнэ: (1) Хэрэг тохиолдлыг хүлээн авах, яаралтай хариу арга хэмжээ авах нэгж; (2) Эрсдэлийн үнэлгээний нэгж; (3) Урьдчилан сэргийлэх, хөндлөнгийн хяналт, дүн шинжилгээ хийх алба (17-р зүйлийг үзнэ үү). Мексикийн хуулийн 18-р зүйлд Үндэсний Гүйцэтгэх Зохицуулалтын албаны эрх мэдлийг тодорхойлсон болно.

#### *Гондурасын хууль*

Харьцуулбал, Гондурасын хуулиар Хүний эрх хамгаалагч, сэтгүүлч, нийгмийн харилцаа холбооны мэргэжилтэн, хуульчдыг хамгаалах үндэсний систем (Үндэсний хамгааллын систем) нь таван байгууллагаас бүрддэг (19-р зүйлийг үзнэ үү): (1) Хүний эрх, хууль зүй, дотоод хэрэг, төвлөрлийг сааруулах департаментын Төрийн нарийн бичгийн дарга (удирдах байгууллага); (2) Хүний эрхийн хамгаалагчид, сэтгүүлчид, нийгмийн харилцаа холбооны мэргэжилтэн, хуульчдыг хамгаалах үндэсний зөвлөл (Хамгааллын Үндэсний зөвлөл); (3) Хамгааллын системийн ерөнхий газар; (4) Хамгааллын механизмын техникийн хороо; (5) Аюулгүй байдлын департаментын Төрийн нарийн бичгийн даргын Хүний эрхийн газар.

Үндэсний тогтолцоог удирдах байгууллага болох Хүний эрх, хууль зүй, дотоод хэрэг, төвлөрлийг сааруулах департаментын Төрийн нарийн бичгийн даргын бүрэн эрхийн талаар Гондурасын хуульд тусгайлан заагаагүй болно.

Хамгааллын Үндэсний зөвлөлийг Үндэсний хамгааллын системийн зөвлөлдөх, зөвлөх байгууллага болгон байгуулсан (20-р зүйлийг үзнэ үү). Гондурасын хуулийн 24-р зүйлд Хамгааллын Үндэсний зөвлөлийн бүрэн эрхийг тодорхойлсон.

Хүний эрх, хууль зүй, дотоод хэрэг, төвлөрлийг сааруулах департаментын Төрийн нарийн бичгийн даргын зохион байгуулалтын бүтцэд багтдаг Үндэсний хамгааллын системийн ерөнхий газар нь Үндэсний хамгааллын системийн гүйцэтгэх бүтэц юм (28-р зүйлийг үзнэ үү). 29-р зүйлд Үндэсний хамгааллын системийн ерөнхий газрын бүрэн эрх, үүргийг тодорхойлсон болно.

Хамгааллын механизмын техникийн хороо нь Ерөнхий газарт ирүүлсэн хамгаалалт авах хүсэлтэд эрсдэлийн шинжилгээ, хэлэлцүүлэг хийж, шийдвэрийг хэрэгжүүлэх үүрэгтэй (31-р зүйлийг үзнэ үү). 32-р зүйлд Техникийн хорооны эрх мэдлийг тодорхойлсон болно.

Хүний эрхийг хамгаалагчид, тэдний гэр бүл болон хамтрагчдын хувийн нууцыг хамгаалахын тулд хүний эрхийн үндэсний байгууллагууд эдгээр хүмүүсийн талаар цуглуулсан өгөгдлийн нууцлалыг хадгалах шаардлагатай. Гондурасын хуулийн 31-р зүйлд заасны дагуу Техникийн хорооны гишүүд хамгааллын болон хэргийн дүн шинжилгээ хийх журамтай холбоотой бүх мэдээллийг чандлан нууцлахыг шаарддаг бөгөөд зөрчсөн тохиолдолд торгох шийтгэл оногдуулдаг.

**Гучин тавдугаар зүйл.**  
**Иргэний нийгэмтэй зөвшилцөх**

Эрх бүхий байгууллага нь хүний эрх хамгаалагч болон иргэний нийгмийн төлөөлөгчидтэй хамгаалах механизмын ажлын бүх асуудлаар зөвшилцөнө.

**Гучин зургадугаар зүйл.**  
**Нөөц**

- 1) Эрх бүхий байгууллага нь хамгаалах механизмын үйл ажиллагаа болон чиг үүргээ бүрэн болон үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн нөөцийг нь бүрдүүлнэ.
- 2) Энэ хуулийн зорилгыг биелүүлэх болон энэ зүйлийн 1-т заасан санхүүгийн нөөцөд нэмэлт нөөц бүрдүүлэх зорилгоор эрх бүхий байгууллага хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах сан байгуулна.
- 3) Сангийн нөөцийг зөвхөн хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон энэ хуульд заасан бусад үйл ажиллагаанд зарцуулна.
- 4) Ашиг сонирхлын зөрчлөөс хамгаалах зорилгоор Сан нь дараах тусламжийг авч болно. Үүнд
  - a) Нийтийн болон хувийн хэвшлийн хандив болон тусламж;
  - b) Дотоод гадаадын хувь хүн, бүлэг хүмүүс, нэгдэл, байгууллага болон хүрээлэнгээс өгсөн хандив;
  - c) Хамгаалах механизмын хүрээнд байгуулсан байгууллагын хөдлөх болон үл хөдлөх хөрөнгөөс олсон орлого;
- 5) Сангийн хөрөнгийг Механизм болон Механизмын байгууллага эрх авсан нэгж зарцуулна.
- 6) Сангийн үйл ажиллагааг ил тод явуулж, сангийн зардлын талаар тайланг Механизмын жилийн тайланд тусгана.

Тайлбар

Тусгай илтгэгчийн илтгэлд (131-р догол мөр) хүний эрх хамгаалагчдыг хамгаалах зорилгоор байгуулагдсан үндэсний байгууллагуудыг “үйл ажиллагаагаа бие даан явуулж, итгэл даахуйц, үр дүнтэй байхын тулд зохих эх үүсвэрээр хангах”, “хамгаалагчдыг бие махбодын болон сэтгэл зүйн хувьд хамгаалах материаллаг нөөцөөр” хангахыг зөвлөсөн.

ХЭЗ-ийн 22/6 тоот тогтоолд улс орнуудад дараах зүйлийг уриалсан: “НҮБ-ын тунхаглалд заасны дагуу хүний эрхийн хамгаалагчдын ажлыг дэмжихэд чиглэсэн боломжит санхүүжилтийн эх үүсвэрүүдэд ... ил тод байдал, хариуцлагыг баталгаажуулах зорилгоор улс орны хэмжээнд хүний эрхэд хамааралгүй бусад аливаа үйл ажиллагаанд ердийн журмаар тавьдгаас бусад хязгаарлалтыг ялгавартайгаар тогтоохгүй байх, санхүүжилтийн гарал үүслээс нь үүдэн хүний эрхийг хамгаалах үйл ажиллагааг ямар ч хууль тогтоомжоор эрүүгийн хариуцлага хүлээлгэх буюу хууль бус хэмээн үзэх ёсгүй.”<sup>16</sup>

<sup>16</sup> НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөл, *Protecting human rights defenders*, 12 April 2013, A/HRC/RES/22/6, 9(b) параграф.



Энэхүү зүйлийг дараах эх сурвалжид үндэслэсэн: (а) Мексикийн хуулийн 48, 49-р зүйл; (б) Балбын хуулийн 16-р зүйл; ба (в) Гондурасын хуулийн 66-р зүйл болон энэ асуудлаар CEJIL-PI-ийн хамтран хийсэн дүн шинжилгээ.<sup>17</sup>

### Гучин долдугаар зүйл. Сургалт ба шалгалт

- 1) Энэ хуулийг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх зорилгоор механизмын үйл ажиллагааг хэрэгжүүлж буй бүх албан тушаалтан, аюулгүйн болон хууль сахиулах албаны ажилтан нь шалгалт өгч, өмнө нь болон дараагаар нь ч тогтмол сургалтад хамрагдана.
- 2) Энэ зүйлийн 1-т заасан сургалт нь хүний эрх, үндсэн эрх чөлөө болон хохирогчийн нөхцөл байдлыг судлах, тэдгээрийг хамгаалах, хүний эрхийн эмзэг бүлэгт багтах хамгаалагч, ялангуяа бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийг тодорхойлох ажилд оролцож байгаа, мөн хөдөө алс орон нутагт ажиллаж байгаа болон эмэгтэй хүний эрх хамгаалагчдыг хамгаалах талаар сургалтыг багтаана.

### Тайлбар

ХЭЗ-ийн 13/13 тоот тогтоолд улс орнуудад дараах зүйлсийг уриалсан:

*.. шаардлагатай хамгаалалтын арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд нөөцийг хуваарилах, үүнд хэрэгжилтэд оролцож буй хүмүүст зориулан тусгайлсан сургалтыг багтаах.*<sup>18</sup>

Тусгай илтгэгчийн тайланд (88-р догол мөр) дараах зүйлийг зөвлөсөн:

*.. хамгааллын хөтөлбөрт оролцож буй аюулгүй байдал, хууль сахиулах байгууллагын ажилтнууд хүний эрх, жендэрийн асуудлаар тусгайлсан сургалтад хамрагдах ёстой. Хамгаалагчдын бие махбодын хамгаалалтыг тусгайлсан сургалтад хамрагдаагүй бол гуравдагч этгээдэд ишлэжүүлэх ёсгүй.*

Энэхүү зүйлд заасан улс орнуудын хэрэгжүүлэх ёстой тусгайлсан сургалтын хөтөлбөрийг нарийвчлан тодорхойлохын оронд Загвар хуулийг боловсруулагчид уг хуулийн зорилгод нийцүүлэн улс бүр өөрсдийн хүний эрхийн нөхцөл байдлын эрсдэлийн үнэлгээг харгалзан, иргэний нийгэмтэй зөвлөлдсөний үндсэн дээр сургалтын хөтөлбөрөө өөрсдийн үзэмжээр боловсруулахыг илүүд үзсэн.

Энэ зүйлийн 2-т сургалтад онцгой эмзэг бүлэгт багтах хүний эрх хамгаалагчдын нөхцөл байдал, хамгааллын хэрэгцээг багтаах ёстойг тодруулсан. Эдгээр хамгаалагчийн нөхцөл байдал үндэсний түвшинд янз бүр байж болно.

<sup>17</sup> [www.ishr.ch/sites/default/files/article/files/analysis-ley-de-proteccion-para-defensoresas\\_translated\\_final.pdf](http://www.ishr.ch/sites/default/files/article/files/analysis-ley-de-proteccion-para-defensoresas_translated_final.pdf)

<sup>18</sup> НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөл, *Protection of human rights defenders*, 15 April 2010, A/HRC/RES/13/13, 11-р параграф



## ТАВДУГААР БҮЛЭГ. ХЭРЭГЛЭГДЭХ НЭР ТОМЪЁО БОЛОН ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ

### Гучин наймдугаар зүйл.

#### Нэр томъёо

- 1) Энэ хуулийн зорилгыг биелүүлэх зорилгоор “хүний эрх, үндсэн эрх чөлөө” гэдэгт олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн баримт бичиг, олон улсын заншлын эрх зүйн хэм хэмжээ ба эдгээрт нийцүүлэн баталсан үндэсний хуулиар хүлээн зөвшөөрсөн ба тунхагласан эрх, эрх чөлөөг ойлгоно.
- 2) Энэ хуулийн зорилтыг биелүүлэх зорилгоор “дарамтлах болон хилс хэрэгт хэлмэгдүүлэх” гэдэгт доорхи хүмүүст хувь хүний байдал, хүний эрх хамгаалагчийн ажил, үйл ажиллагаа болон тухайн хүний ирээдүйд, бэлтгэсэн төлөвлөсөн ажил, үйл ажиллагааных нь төлөө аливаа хүч хэрэглэх, заналхийлэх, бодит байдал болон хууль зүйн арга хэрэгслээр ялгаварлах, дарамт үзүүлэх, хүч хэрэглэн болон эрх мэдлээ урвуулан ашиглахыг ойлгоно. Үүнд:
  - a) Хүний эрх хамгаалагчийг;
  - b) Хүний эрх хамгаалагчийн хамтрагчийг;
  - c) Хүний эрх хамгаалагчийн хууль ёсны болон бусад томилогдсон эсхүл өөр хэлбэрээр төлөөлөх эрхтэй этгээдийг;
  - d) Хүний эрх хамгаалагчийн гэр бүлийн гишүүн, хамаатныг;
  - e) Хүний эрх хамгаалагчтай холбоотой албан буюу албан бус бүлэг, нэгдэл, байгууллага, нийгэмлэг, сүлжээг;
  - f) Хүний эрх хамгаалагчийн болон энэ зүйлийн b-e-д заасан этгээдийн орон гэр, эд хөрөнгөд халдах.
- 3) Энэ хуулийн зорилгыг хэрэгжүүлэх зорилгоор доорх нэр томъёог дараах утгаар ойлгоно. Үүнд:
  - a) “Хамтрагч” гэдэгт хүний эрхийн хамгаалагчтай хамтран хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах ажил хэрэгжүүлж буй этгээдийг;
  - b) “Сан” гэдэгт хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах зорилгоор энэ хуулийн 36.2-т заасны дагуу байгуулсан санг;
  - c) “Механизм” гэдэгт 4 дүгээр бүлэгт заасны дагуу байгуулсан хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах механизмыг;
  - d) “Хамгаалах арга хэмжээ” гэдэгт энэ хуулийн 4 дүгээр бүлэгт заасан бөгөөд хамгаалахад чиглэсэн арга хэмжээг;
  - e) “Төрийн эрх бүхий байгууллага” гэдэгт хууль болон итгэмжлэлийн үндсэн дээр, засгийн газрын байгууллага болон агентлагтай байгуулсан гэрээ эсхүл сонгон шалгаруулалтын үндсэн дээр нийтийн үйлчилгээ, ажил эрхэлж, гүйцэтгэж буй хүн эсхүл байгууллагыг ойлгоно.

## Тайлбар

### Дэд хэсэг (1)

Төсөл боловсруулагчид “хүний эрх ба үндсэн эрх чөлөө”-г өргөн агуулгаар авч үзсэн тодорхойлолтыг оруулсан бөгөөд “хүний эрх ба үндсэн эрх чөлөө” –г хүний эрхтэй холбоотой олон улсын гэрээ конвенцид дурдсан жагсаалтыг иш татан тодорхойлох нь хязгаарлагдмал байж болзошгүй гэж үзсэн.

Үүнд дараах гэрээ конвенц багтана:

- (a) Хүний эрхийн түгээмэл тунхаглал;
- (b) НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих талаар хувь хүн болон нийгмийн бүлэг, байгууллагын эрх үүргийн тухай тунхаглал;
- (c) Арьс өнгөөр алагчилах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц;
- (d) Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт;
- (e) Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт;
- (f) Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц;
- (g) Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц;
- (h) Хүүхдийн эрхийн тухай конвенц;
- (i) Бүх цагаач ажилтан болон тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенц;
- (j) Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай” олон улсын конвенц
- (k) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц;
- (l) Уугуул иргэдийн эрхийн тухай тунхаглал;
- (m) Хүний ба ард түмний эрхийн тухай Африкийн харти, Хүний эрхийн тухай Америкийн конвенц зэрэг бүс нутгийн хүний эрхийн холбогдох гэрээ конвенц;
- (n) Энэхүү хууль багтагдсаны дараа багтагдсан хүний эрхийн холбогдох бусад гэрээ конвенц.

Олон улсын заншлын эрх зүйн хэм хэмжээг тусгайлан дурдана.

Зарим хүний эрх хамгаалагчид шинээр бий болж байгаа бөгөөд олон улсын аль нэг гэрээ конвенцид хүлээн зөвшөөрөгдөөгүй байгаа хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулж болохыг харгалзан олон улсын тодорхой гэрээ конвенцуудыг жагсаасан аливаа тодорхойлолт тусгайлан заасан байх ёсгүй (“Хүний эрх, үндсэн эрх чөлөөнд ... хамаарна”).

Хүний эрх, үндсэн эрх чөлөөний олон агуулгыг дээр дурдсан олон улсын хүний эрхийн гэрээ конвенцийг тайлбарлаж, хэрэглэсэн үндэсний болон олон улсын байгууллагуудын шийдвэр, түүнчлэн олон улсын заншлын хэм хэмжээгээр тодорхой тайлбарласан байдаг.

Эдгээр шийдвэрийн ач холбогдлыг харгалзан “хүний эрх ба үндсэн эрх чөлөө” гэсэн тодорхойлолтод энэ талаар нэг өгүүлбэр оруулж болох бөгөөд “хүний эрх ба үндсэн эрх чөлөө” -ний утгыг тайлбарлахдаа тийм шийдвэрүүдийг харгалзаж болно

### Дэд хэсэг (2)

“Айлган сүрдүүлэх ба хонзогнох” гэсэн тодорхойлолт нь Тунхаглалын 12(2)-р зүйлд үндэслэсэн:

*Улс бүр, энэхүү тунхаглалд дурдсан эрхүүдээ хууль ёсны дагуу эдлэн, дангаараа буюу бусадтай эвлэлдэн нэгдэж, заналхийлэл, хонзогнол, хуульд заагаагүй буюу хуульд заасны дагуу алагчлах, дарамт шахалт, бусад аливаа дур зоргоороо үйлдэл зэрэг аливаа хүчирхийллийн эсрэг тэмцсэн хэн бүхнийг эрх бүхий байгууллагаар хамгаалуулах бүхий л арга хэмжээг ханган хэрэгжүүлнэ.*

Хүний эрх хамгаалагчийн хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чадвар нь хүний эрх хамгаалагч өөрөө заналхийлэлд өртсөн тохиолдолд төдийгүй түүний ойр дотны хүмүүст аюул заналхийлэл учирсан тохиолдолд ч суларч байдаг. Тийм ч учраас 3-р зүйлд дурдсан “айлган сүрдүүлэх ба хонзогнох” гэсэн тодорхойлолтод хүний эрх хамгаалагчийн гэр бүлийн гишүүд, түүний төлөөлөгчид буюу түншүүд, эсвэл хүний эрх хамгаалагчтай холбоотой аливаа бүлэг, холбоо, байгууллагын эсрэг хийсэн үйлдлийг багтаасан болно.

Төсөл боловсруулагчид 2-р зүйлийн (d)-д гэр бүлийн гишүүн гэсэн нэр томъёог тодорхойлохгүй байх шийдвэр гаргасан. Энэхүү нэр томъёог тодорхойлох нь үнэн хэрэгтээ түүний хэрэглээг хязгаарлаж болзошгүй гэж үзсэнээс үүдэлтэй. Гэр бүлийн гишүүн гэсэн нэр томъёог аль болох өргөн хүрээнд, тухайн улсын соёл, зан заншлын хүрээнд тайлбарлах нь зүйтэй.

Хүний эрх хамгаалагчидтай холбоотой дотоодын ямар ч хууль тогтоомжид хүний эрх хамгаалагчийн “гэр бүлийн гишүүн” гэж хэн болохыг тодорхойлоогүй. Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 5-р зүйлд дараах байдлаар тодорхойлсон:

*Оролцогч улсууд эцэг эх, зохих тохиолдолд, нутгийн ёс заншлын дагуу өргөтгөсөн гэр бүл, нийгэмлэгийн гишүүд, асран хамгаалагч болон хүүхдийн өмнөөс хуулийн дагуу хариуцлага хүлээх бусад этгээдийн хариуцлага, эрх, үүргийг хүндэтгэн, хөгжиж буй хүүхдийн чадавхид нийцүүлэн энэхүү Конвенцид заасан эрхээ хэрэгжүүлэхэд удирдан чиглүүлнэ.*

Гэр бүлийн энэхүү өргөн тодорхойлолт нь дэлхийн өнцөг булан бүрд хүүхэд хүмүүжүүлж буй төрөл садан ба айл хотлын зохицуулалтыг харгалзан үзсэн болно.

Хүний эрх хамгаалагчдыг хүлээн зөвшөөрөх, хамгаалах тухай хууль баталж буй аливаа улсаас гэр бүлийн гишүүдийн тухай тодорхойлолт оруулахдаа дээрх гэрээ конвенцид үндэслэсэн байх ёстойн зэрэгцээ өргөн хүрээтэй бөгөөд зөвхөн цусан төрлийн харилцаанаас гадна гэрлэлт болон бусад холбооноос үүсэх хэлхээ холбоог хүлээн зөвшөөрөх ёстой.

### **Дэд хэсэг (3)**

3-р зүйлийн (a)-д заасан "хамтрагч" гэсэн тодорхойлолт нь хүний эрх хамгаалагч ба хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр тэдэнтэй хамтран үйл ажиллагаа явуулж буй хүмүүс хоорондын олон янзын ажил төрлийн харилцааг хамарсан өргөн цар хүрээтэй юм.

"Эрх бүхий төрийн байгууллага" гэсэн тодорхойлолт нь 2006 оны Викториагийн Хүний эрх, үүрэг хариуцлагын тухай хуулийн 4-р зүйлд дурдсан "төрийн байгууллага" гэсэн тодорхойлолтын хялбаршуулсан хувилбар юм.

38-р зүйлийн (3)-ийн (d) -д заасан "эрх бүхий төрийн байгууллага" гэсэн тодорхойлолтыг хүний эрх хамгаалагчдыг хүлээн зөвшөөрөх, хамгаалах тухай хууль баталж буй аливаа улс өөрийн нөхцөл байдалд тохируулан боловсронгуй болгох шаардлагатай байж болох юм.

## **Гучин есдүгээр зүйл. Ялгаварлан гадуурхахгүй байх**

Энэ хууль нь хүйс, үндэс угсаа, арьсны өнгө, хэл, шашин, итгэл үнэмшил, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэс угсаа, нийгмийн гарал, харьяалал, нас, эдийн засгийн байдал, эд хөрөнгө, гэр бүлийн байдал, төрөлт, хөгжлийн бэрхшээл, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл болон бусад аливаа байдлаар ялгаварлахгүйгээр .... Улсын нутаг дэвсгэр, бүрэн эрх үйлчлэх бусад нутагт бүгдэд адил үйлчилнэ.

### Тайлбар

Энэхүү зүйлийг бүс нутгийн хэлэлцүүлгээр дэвшүүлсэн зөвлөмжид нийцүүлэн оруулсан болно.<sup>19</sup> Энэ зүйл нь бүх хүний эрх хамгаалагчид энэ хуульд заасан эрх, хамгаалалтыг эдлэх боломжийг хангахад чиглэсэн нэмэлт хамгаалалт юм.

39-р зүйлд дурдсантай төстэй заалтыг Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 2-р зүйлд дурдсан байдаг:

*Хүн бүр энэ Тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг үндэс угсаа, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстой. Мөн түүнчлэн тухайн хүнийг харьяалдаг улс буюу нутаг дэвсгэрийн улс төр, эрх зүй болон олон улсын статус ямар ч байлаа гэсэн, тухайлбал, тусгаар тогтносон буюу асрамжинд байгаа, өөрөө эс удирдах зэрэг бүрэн эрхт байдал нь ямар ч байдлаар хязгаарлагдмал байсан тэр нь ялгаварлах үндэс болох ёсгүй.*

Бүх цагаач ажилтан болон тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенцийн 1-р зүйлийн (1)-д зааснаар:

*Энэхүү Конвенц нь цаашид өөрөөр заагаагүй бол бүх цагаач ажилтан болон тэдний гэр бүлийн гишүүдэд хүйс, арьсны өнгө, хэл, шашин шүтлэг, итгэл үнэмшил, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний, угсаатны болон нийгмийн гарал, харьяалал, нас, эдийн засгийн байдал, өмч хөрөнгө, гэр бүлийн байдал, төрсөн эсвэл бусад статусаас үл хамааран нэгэн адил үйлчилнэ.*

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 2-р зүйлийн (2)-д зааснаар:

*Энэхүү Пактад оролцогч улсууд үндэс угсаа, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, төрсөн болон бусад нөхцөл байдлаар алагчилахгүйгээр энэхүү Пактад тунхагласан эрхийг хэрэгжүүлэх баталгааг бий болгох үүрэгтэй.*

Цагаач ажилтны тухай конвенцийн үг хэллэг нь хүлээн зөвшөөрч үл болох ялгаварлан гадуурхах үндэслэлүүдийн хамгийн дэлгэрэнгүй жагсаалтыг багтаасан тул 39-р зүйлд ашигласан болно. Хөгжлийн бэрхшээл, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл ба бэлгийн онцлог шинжийг олон улсын хүний эрхийн хэм хэмжээ, хууль зүйг тусгахын тулд уг жагсаалтад нэмж оруулсан бөгөөд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц<sup>20</sup>, Бэлгийн чиг баримжаа ба хүйсийн баримжаа илэрхийлэлд олон улсын хүний эрх, эрх зүйг хэрэглэх тухай Жогжакартын зарчмуудыг<sup>21</sup> тус тус багтаасан.

<sup>19</sup> International Service for Human Rights, *Project report: Regional Consultation on Model National Law on the Recognition and Protection of Human Rights Defenders*, Section 6.8.1.1.

<sup>20</sup> Тухайлбал, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцийн 5.2: “Оролцогч улсууд нь хүнийг хөгжлийн бэрхшээлийн улмаас бүх хэлбэрээр алагчилах явдлыг хориглох бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ямарваа хэлбэрийн алагчилалд өртөхөөс хамгаалах адил тэгш, үр дүнтэй хууль зүйн хамгаалалтыг бий болгоно”

<sup>21</sup> Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэлд олон улсын хүний эрх, эрх зүйг хэрэглэх тухай Жогжакартын зарчмууд, Зарчим 2: “Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлдээ үндэслэн ялгаварлан гадуурхалтад өртөлгүйгээр хүн бүр бүх хүний эрхээ эдлэх эрхтэй”.

## **ХАВСРАЛТ I. ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧДЫГ ХАМГААЛАХ ЭРХИЙН, НӨӨЦИЙН БОЛОН ХЭРЭГЖҮҮЛЭХ МЕХАНИЗМЫН БОЛОМЖИТ НЭМЭЛТ ЗААЛТУУД**

### Тайлбар

Энэхүү хавсралтад Хуулийн IV хэсгийг ажиллуулах нэмэлт удирдлага болгохоор Загвар хууль, журам, тогтоолд тусгаж болох хэсэг заалт багтсан болно.

### **Нэгдүгээр зүйл.**

#### **Хамгаалалтын арга хэмжээ авахыг хүсэх өргөдөл**

- (1) Хүний эрх хамгаалагч болон Хэсэг 38 (2) (b) - (e) -д заасан хүмүүс хамгаалалтын арга хэмжээ авах өргөдлийг бичгээр буюу амаар биечлэн [*тогтсон загварыг ашиглан*] эсвэл ийм зорилгоор долоо хоногийн өдөр бүр 24 цагийн турш хандахаар байгуулсан яаралтай тусламжийн утсаар дамжуулан гаргаж болно.
- (2) Өргөдөл бичгээр өгөх нь тухайн нөхцөл байдалд боломжгүй бол хамгаалалтын арга хэмжээ авах өргөдлийг амаар биечлэн буюу [*энэ зорилгоор байгуулсан яаралтай тусламжийн утас*] -аар холбогдон гаргаж болно.
- (3) Өргөдөл [хүлээн авсан албан тушаалтан] нь дараахыг хийнэ. Үүнд:
  - (a) хамгаалах арга хэмжээ авах, буюу яаралтай хамгаалах арга хэмжээ авах өргөдөл гаргахад шаардлагатай дэлгэрэнгүй мэдээллийг авах; ба
  - (b) өргөдлийн мэдүүлгийг бичгээр үйлдэж Механизмд цаг алдалгүй, өргөдөл гаргаснаас хойш [6 цагийн] дотор дамжуулах; ба
  - (c) айлган сүрдүүлэх, хонзогнох ажиллагаа даруй явагдах эрсдэлтэй тохиолдолд өргөдлийн мэдүүлгийг шууд Механизмд дамжуулна.

### **Хоёрдугаар зүйл.**

#### **Хамгаалалтын арга хэмжээ хүссэн өргөдлийн үнэлгээ**

- (1) 4-р хэсэгт заасан яаралтай хамгаалах арга хэмжээний журамд хамрахаас бусад тохиолдолд Механизм нь хамгаалах арга хэмжээ авах өргөдөл хүлээн авснаас хойш [хоёр долоо хоногийн] дотор дараахыг хэрэгжүүлнэ:
  - (a) жендэрийн төлөв, хүний эрх хамгаалагч эмэгтэй болон өндөр эрсдэлд буй бусад хамгаалагчдын онцлог нөхцөл байдал, зөрчлийн үндэс шалтгааныг тодруулан айлган сүрдүүлэг, хонзогнол ирэх бодит эрсдэл байгаа эсэхийг тодорхойлох цогц шинжилгээ хийх;
  - (b) хамгаалалтын арга хэмжээ авах өргөдлийг хүлээн авах эсэхийг тогтоно.
- (2) Хамгаалалтын арга хэмжээ авах өргөдлийг хүлээн авсан тохиолдолд мөн [хоёр долоо хоногийн] дотор Механизм дараахыг хийнэ. Үүнд:
  - (a) хамгаалах төлөвлөгөөг боловсруулж, хамгаалах арга хэмжээг тодорхойлох;
  - (b) хамгаалалтын төлөвлөгөө, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа, арга замыг тогтох; ба

- (с) хамгаалалтын арга хэмжээнд хамрагдагч буюу хамрагдагчдыг тодорхойлох.
- (3) Хамгаалалтын арга хэмжээнд хамрагдагчид нь хүний эрх хамгаалагчид болон 38 (2) (b) - (e) -р хэсэгт заасан этгээдүүд байж болно.
- (4) Хамгаалах арга хэмжээг зөвхөн хамрагдагч буюу хамрагчдын зөвшөөрлөөр хэрэгжүүлнэ.
- (5) (1) ба (2) заалтуудад заасан Механизмаас гаргасан шийдвэрийг өргөдөл гаргагчид бичгээр мэдэгдэж, шийдвэрийн үндэслэлийг тусгана.
- (6) (1) (a)-д заасан эрсдэлийн дүн шинжилгээ, (2) (a) -д тодорхойлсон төлөвлөгөө, арга хэмжээний талаар Өргөдөл гаргагчтай зөвлөлдсөн байх учиртай.
- (7) Хамрагдагч буюу хамрагдагчдаас авсан зөвшөөрлийн үндсэн дээр Механизм нь хүний эрх хамгаалагчид болон Хэсэг 38 (2) (b)-(e)- д заасан хүмүүсийн эсрэг үйлдэл нь гэмт хэргийн шинж агуулсан эсэхийг шалгуулахаар эрсдэлийн шинжилгээг холбогдох үүрэг бүхий байгууллагад мэдээлнэ.

### Тайлбар

Энэ хэсгийн дийлэнхийг Мексикийн холбогдох хуулийн 27 дугаар зүйлээс авсан болно.

Хамгаалалтын арга хэмжээг хамгаалуулагч өөртэй нь болон түүний төлөөлөгчтэй зөвлөлдөж эрсдэлийн цогц шинжилгээг хийх нь энэхүү Загвар хуулийн схемийн үндэс нь болно.

Тусгай Илтгэгчийн тайлан (88-р догол мөр) дараахь зүйлийг зөвлөв:

*... Хамгаалах хөтөлбөрийг боловсруулах, хянах явцад хүний эрхийн хамгаалагчидтай зөвлөлдөх ба эдгээр хөтөлбөрийн бүтцийг хуулиар тодорхойлсон байх ёстой. Хамгаалах хөтөлбөрүүд ... хамгаалагчдын гэр бүлийн гишүүд, хамаатан садны аюулгүй байдлыг шинжсн ёстой.*

Тусгай Илтгэгчийн тайлан (89-р догол мөр) мөн Мексикийн хууль дахь дараах баталгааг сайшаав:

*...хамгаалуулагч өөрийн эрсдлийг шинжсн, хамгаалах арга хэмжээг тодорхойлоход оролцох эрх.*

Мексикийн хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу өргөдлийг (авах арга хэмжээ зэрэгт) хамгаалуулагчийн зөвшөөрлийг авах боломж туйлын хүндрэлтэйгээс бусад тохиолдолд зөвхөн түүний зөвшөөрснөөр шийдвэрлэнэ.

### **Гуравдугаар зүйл.**

#### **Хамгаалалтын төлөвлөгөө, авах арга хэмжээг боловсруулах**

- (1) Механизм нь энэ хууль хүчин төгөлдөр болсноос хойш [зургаан сарын] дотор иргэний нийгмийн байгууллагуудтай зөвшилцөх үндсэн дээр олон улсын шилдэг туршлагад тулгуурлан боломжит хамгаалах арга хэмжээний жагсаалтыг боловсруулна. Жагсаалтыг [зургаан] сар тутамд хянаж, шинэчлэн баяжуулна.
- (2) Механизм болон холбогдох төрийн байгууллагууд хүний эрх хамгаалагчид болон Хэсэг 38 (2) (b) - (e) -д заасан хүмүүстэй холбоотой хэрэгжүүлж болох хамгаалалтын арга хэмжээнд дараах зүйлс орно. Үүнд:

- (a) үүрэн төхөөрөмж, радио, хиймэл дагуулын утас буюу бусад холбооны хэрэгслээр хангах;
  - (b) хамгаалуулагчийн гэр, ажлын байранд камер, цоож, гэрэл эсвэл бусад аюулгүй байдлын арга хэрэгсэл суурилуулах;
  - (c) сум нэвтрэхгүй хантааз олгох;
  - (d) металл хайгч суурилуулах;
  - (e) хуягт тээврийн хэрэгслээр хангах;
  - (f) утсан холбооны шуурхай шугам үүсгэх;
  - (g) зэвсэгт буюу зэвсэглээгүй хамгаалалтын бие бүрэлдэхүүн томилох;
  - (h) хууль зүйн туслалцаагаар хангах буюу сувагчлах;
  - (i) кибер аюулгүй байдлын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, дэд бүтцээр хангах;
  - (j) олон нийтийн болон хувийн мэдэгдэл хийх, дэмжлэгийг нийтэд түгээх;
  - (k) шүүх хуралдаан буюу хууль хяналтын үйл явцад оролцох буюу ажиглах;
  - (l) хоргодох байраар хангах;
  - (m) нэрээ өөрчлөх бичиг баримтыг үйлдэж олгох;
  - (n) аяны туслалцаа үзүүлэх;
  - (o) аюулт газраас нүүлгэн шилжүүлэх;
  - (p) нүүлгэх;
  - (q) сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх, үүнд гэмтэл, стресс менежмент, сайн сайхан байдлын талаар зөвлөгөөнд хамруулах; ба
  - (r) санхүүгийн туслалцаа үзүүлэх буюу орлогыг дэмжих.
- (3) Механизм хамгаалалтын төлөвлөгөө, арга хэмжээ боловсруулах, хэрэгжүүлэх талаар хамгаалуулагч буюу хамгаалуулагчидтай зөвлөлдөж, тохиролцоно.

#### Тайлбар

Энэхүү хэсэгт Мексикийн хуулийн 33 дугаар зүйл, Гватемалын каталогийн 4.2 дахь хэсэгт үндэслэн бүс нутгийн зөвлөлдөх уулзалтаар нийтлэг гэж тодорхойлогдсон аюул заналхийллийг оруулан өргөжүүлсэн болно.

Хүний эрх хамгаалагчдыг хамгаалах механизмыг хүний эрх хамгаалагчид учирч буй эрсдлийг шинжихтэй уялдуулах нь чухал юм. Хамгаалуулагчийн эрсдэлд орж буй дүн шинжилгээг түүний зөвшөөрлөөр холбогдох мөрдөн байцаах байгууллагуудад өгснөөр хамгаалуулагчид чиглэсэн гэмт хэргийн шинжтэй ажиллагааг шалгахад дөхөм болно.



### **Дөрөвдүгээр зүйл.**

#### **Яаралтай хамгаалах төлөвлөгөө, арга хэмжээ**

- (1) 1-р хэсэгт заасны дагуу айлган сүрдүүлэг, хонзогнолтод өртөлтөөс хамгаалалтанд орох өргөдөл гаргасан тохиолдолд Механизм нь өргөдөл хүлээн авснаас хойш [зургаан цаг]-аас хэтрүүлэлгүйгээр цаг алдалгүй айлган сүрдүүлэх, хонзогнох бодит эрсдэл тулсан эсэхийг тодорхойлно.
- (2) Айлган сүрдүүлэг, хонзогнолтод өртөх эрсдэл тулсан тохиолдолд цаг алдалгүй мөн хугацаанд (зургаан цагийн) дотор Механизм нь яаралтай хамгаалах төлөвлөгөө боловсруулж, Механизм болон холбогдох төрийн байгууллагууд хамгаалуулагч ба хамгаалуулагчидтай тохирсноор яаралтай хэрэгжүүлэх болно.
- (3) Яаралтай хамгаалах арга хэмжээнд дараах зүйлс орно. Үүнд:
  - (a) нүүлгэн шилжүүлэх;
  - (b) эрсдэлийн бүсээс гадагш түр хугацаагаар нүүлгэн шилжүүлэх;
  - (c) хамгаалалтын ажилтнуудыг дагалдуулах;
  - (d) өмчийг хамгаалах арга хэмжээ авах; болон
  - (e) хамгаалуулагч ба хамгаалуулагчыг хамгаалахад шаардлагатай гэж Механизмаас тогтсон бусад арга хэмжээ.

#### Тайлбар

Тусгай илтгэгчийн тайланд (89-р зүйлд) Мексикийн хуульд “онцгой нөхцөлд 12 цаг хүрэхгүй хугацаанд шуурхай арга хэмжээ авах”-аар заасныг сайшаажээ.

Энэ хэсэгт Мексикийн хуулийн 26, 32 дугаар зүйлүүдэд голчлон үндэслэсэн болно.

### **Тавдугаар зүйл.**

#### **Хамгаалалтын арга хэмжээг дахин үнэлэх, цуцлах**

- (1) Механизм нь энэхүү хуулиар хэрэгжүүлж буй хамгаалалтын арга хэмжээнд үе үе дахин үнэлгээ хийж, шаардлагатай гэж үзвэл үргэлжлүүлэх, өөрчлөх, цуцлах бөгөөд ийм зорилгоор дараах зүйлийг хийнэ. Үүнд:
  - (a) хамгаалалтын арга хэмжээнд хамрагчдаас ярилцлага авна;
  - (b) хамгаалуулагчдаас хамгаалах арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлсэн талаар тайлан хүснэ;
  - (c) хамгаалуулагчдаас мөрдөн байцаалт, хуулийн процесст, хэрэв байгаа бол, ахиц дэвшлийн талаар мэдээлэл авна;
  - (d) айлган сүрдүүлэг, хонзогнолтод өртөх эрсдлийг нэмэгдүүлж болзошгүй шинэ нөхцөл байдал үүссэн эсэхийг тогтооно; мөн
  - (e) нөхцөл байдал, үндсэн шалтгаантай холбоотой эрсдэлийн явцын дүн шинжилгээ хийх зэрэг болно.
- (2) Хамгаалалтын арга хэмжээ нь нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой бол

хамгаалуулагчтай зөвлөлдсөний үндсэн дээр аюулгүй буцаан шилжүүлэх төлөвлөгөө боловсруулна.

- (3) Механизм нь хамгаалах арга хэмжээг өөрчлөх, цуцлах санал гаргах бол дараах зүйлийг хийх ёстой. Үүнд:
  - (a) хамгаалуулагч ба хамгаалуулагчдад энэ тухай шаардлагатай мэдэгдэл өгөх;
  - (b) хамгаалуулагч ба хамгаалуулагчдад зохих журмын дагуу хариу өгөх хангалттай боломжийг олгох.
- (4) Хэрэв Механизм нь хамгаалуулагчийн талаас хамгаалалтын арга хэмжээг санаатайгаар, удаа дараа зүй бусаар ашигласан болохыг тогтоовол хамгаалалтын арга хэмжээг өөрчилж болно.
- (5) Механизм нь айлган сүрдүүлэг, хонзогнолтод өртөх бодит эрсдэл байхгүй болсныг тогтоовол хамгаалалтын арга хэмжээг цуцалж болно.

#### Тайлбар

Энэ хэсэгт Гватемалын каталогийн 3.2.2.4 ба 3.2.2.5-р зүйлээс голчлон тусгав.

Мөн энэ хэсэгт Мексикийн хуулийн 36, 37 дугаар зүйлийг үндэс болгов.

#### **Зургаадугаар зүйл. Механизмын шийдвэрийг хянах**

- (1) 1-р хэсэгт заасны дагуу хамгаалалтын арга хэмжээ авах өргөдөл гаргагч нь дараах зүйлийг хянуулах гомдлыг [*харъяалах шүүх, трибунал буюу бусад хараат бус эрх бүхий байгууллага*]-д гаргаж болно. Үүнд:
  - (a) Механизм нь хамгаалалтын арга хэмжээ авах өргөдлийн татгалзлыг;
  - (b) Хамгаалалтын арга хэмжээг өөрчлөх буюу цуцлах Механизмын шийдвэрийг;
  - (c) Механизмаас сонгосон хамгаалах арга хэмжээг;
  - (d) 2-оос 4-р хэсэгт дурдсан Механизмын үнэлгээ, шийдвэрийг;
  - (e) хамгаалах арга хэмжээний хэрэгжүүлэлтийг хянуулж болно.
- (2) Энэхүү хэсэгт заасан хянуулах өргөдөл гомдлыг Механизм шийдвэрээ мэдэгдсэнээс хойш [30 хоногийн] дотор гаргана.
- (3) Механизмаас гаргасан хамгаалалтын арга хэмжээг татгалзах буюу зогсоох шийдвэрийг үл харгалзан Хүний эрх хамгаалагч болон 38 (2) (b) - (e) хэсэгт заасан хүмүүс шинэ баримт илэрсэн тохиолдолд хамгаалуулах арга хэмжээ авах өргөдлийг шинээр гаргаж болно.
- (4) (1)(e)-д заасантай холбогдуулан [*харъяалах шүүх, трибунал буюу бусад хараат бус эрх бүхий байгууллага*] нь хамгаалалтын арга хэмжээ муу, хангалтгүй хэрэгжсэнд сэтгэл хангалуун бус гэж үзвэл [*харъяалах шүүх, трибунал буюу бусад хараат бус эрх бүхий байгууллага*] дараах шийдвэр гаргаж болно. Үүнд:
  - (a) [сахилгын арга хэмжээ] авахаар тогтох; буюу
  - (b) [Х хүртэл хэмжээний мөнгөн торгууль] оногдуулна.

### Тайлбар

Тусгай илтгэгчийн тайланд (89-р зүйлд) шүүхийн гомдлын журам тогтоож, Механизмаас тогтоосон арга хэмжээг хэрэгжүүлээгүй төрийн албан тушаалтнуудыг хуулийн дагуу шийтгэхийг баталгаажуулсанд Мексикийн хуулийг сайшаажээ.

Энэ хэсэгт Мексикийн хуулийн XI бүлгээс ихээхэн татав.

Гондурасын хуулийн 54, 55 дугаар зүйлээс заримыг удирдлага болгов.

### **Долдугаар зүйл.**

#### **Дэмжин сурталчилах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ**

- (1) Механизм нь хүний эрх хамгаалагчдын ажлыг хүлээн зөвшөөрөх, дэмжих бөгөөд тэдгээрийг айлган сүрдүүлэлт, хонзогнолоос урьдчилан сэргийлнэ.
- (2) (1)-р заалт дахь зорилгыг биелүүлэхийн тулд Механизм дараах зүйлийг хийнэ. Үүнд:
  - (a) хүний эрх хамгаалагчдын чухал, хууль ёсны үйл ажиллагааг сурталчлах зорилгоор нийтэд мэдэгдэл түгээж олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, чингэхдээ мэдээлэл, боловсрол, болон хэвлэл мэдээллийн бүхий л байгууллагыг ашиглах;
  - (b) урьдчилан сэргийлэх арга хэмжээг санал болгох;
  - (c) айлган сүрдүүлэх, хонзогнох үйл ажиллагаанд үндэсний мониторинг хийж, ийм аюул заналхийлэлтэй холбоотой мэдээллийг хуримтлуулан цэгцлэх ба олсон зүйлийг тайланд нэгтгэх;
  - (d) хүний эрх хамгаалагчдын эсрэг болзошгүй түрэмгийллийн арга хэлбэрийг тодорхойлох;
  - (e) хүний эрх хамгаалагч, хүний эрх хамгаалагчдын бүлэг, 38-р зүйлийн 2-р хэсгийн (b)-(e)-д заасан хүмүүсийг ялгаварлан гадуурхах, нэр төр, үйлсийг гутаан доромжлохын эсрэг олон нийтэд мэдэгдэл хийх ба бусад аргаар тэмцэх; болон
  - (f) өмнө хэрэгжүүлсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ, хамгаалах арга хэмжээ, яаралтай хамгаалах арга хэмжээний үр дүнд үнэлгээ өгөх.
- (3) (2) (b)-д заасан урьдчилан сэргийлэх арга хэмжээнд айлган сүрдүүлэх, хонзогнохоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийн систем ба яаралтай арга хэмжээний төлөвлөгөөний төсөөлөл багтаана.

### Тайлбар

Механизм нь дэмжин сурталчлах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг дэвшүүлж, хүний эрхийн хамгаалагчдын амь нас, бие махбодийн аюулгүй байдал, эрх чөлөөнд заналхийлж буй байдалд үндэсний хэмжээний мониторинг тогтмол явуулах улмаар түрэмгийллийн хэлбэрийг тодорхойлох, хүний эрх хамгаалагчдад учрах эрсдлийг зураглах, өмнө хэрэгжүүлсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ, хамгаалах арга хэмжээ, яаралтай хамгаалах арга хэмжээний дүнг гаргахад ач холбогдолтой.

Энэ хэсэгт Мексикийн хуулийн 23 дугаар зүйл, VIII бүлэгт ялангуяа олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэхтэй холбогдуулан үндэсний байгууллагуудын статустай холбоотой зарчмуудыг заасан зүйлс орсон.

## **ХАВСРАЛТ II. ЗАГВАР ХУУЛИЙГ БУСАД ХУУЛЬТАЙ НИЙЦҮҮЛЭХ БОЛОМЖИЙН НЭМЭЛТ ЗААЛТУУД**

### Тайлбар

Хүний эрх хамгаалагчдыг хамгаалах тухайд хууль шинээр гаргахдаа улс орнууд хүний эрх хамгаалагчдын чухал үйл ажиллагаа, ажлыг хязгаарласан эсвэл буруутгасан заалт бүхий бусад хуулиудыг хянан үзэж, нэмэлт өөрчлөлт оруулах ёстой.

Хүний эрхийн одоогийн хууль тогтоомжинд үндэслэн энэхүү хавсралт нь Загвар хуулийн 2-р хэсэгт заасан эрхүүд бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэхийг тодорхойлох ба бусад хууль тогтоомжийн заалтуудыг энэ хуульд нийцүүлэн тайлбарлах механизмыг тайлбарласан болно.

Үндэсний эрх зүй ба олон улсын хүний эрхийн хууль тогтоомжийн зөрчилдөх байдлыг тодорхойлох, зайлсхийх хууль эрх зүйн үр дүнтэй процедуртэй орнуудын хувьд энэхүү заалтууд шаардлагагүй, тохиромжгүй байж болно.

### **Нэгдүгээр зүйл.**

#### **Энэ хуульд нийцсэн тайлбарыг илүүд үзэх**

- (1) Хуулийн заалтуудыг энэ хуулийн Хэсэг II заасан эрх, зорилгод нийцүүлэн тайлбарлаж боломжийн тууштай хэрэглэнэ.
- (2) Энэхүү хэсэг нь хуулийн заалтын хэрэглэлт бүрт хамаарна.

### Тайлбар

Энэхүү хэсгийг дотоодын хүний эрхийн тухай хуулиудын тайлбар заалтууд, түүний дотор 1998 оны Их Британийн Хүний эрхийн тухай хуулийн 3-р хэсэг, Өмнөд Африкийн Үндсэн хуулийн 39-р зүйлийн 2-р заалт зэрэг дээр үндэслэсэн болно.

Хуульд хэрэглэх хууль тогтоомжийн заалтыг (1)-т заасан журмын дагуу тайлбарлахыг (2)-т тодорхой зааж өгсөн болно.

### **Хоёрдугаар зүйл.**

#### **Нийцэмжгүй байдлын тухай мэдэгдэл**

Шүүх буюу трибунал нь аливаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хууль тогтоомжийн заалтуудыг энэ хуулийн Хэсэг II заасан нэг буюу хэд хэдэн эрхэд нийцүүлэн тайлбарлаж, хэрэглэх боломжгүй гэж үзвэл шүүх, трибуналаас нийцэмжгүй байдлын тухай мэдэгдэл гаргана, аль эсвэл өөрийн эрх мэдлийн хүрээнд тэдгээр заалтыг хүчин төгөлдөр бус болгох өөр тогтоол гаргаж болно.

### Тайлбар

Энэхүү хэсгийг 1998 оны Их Британийн Хүний эрхийн тухай хуулийн 4-р хэсэгт үндэслэсэн болно.

Энэхүү заалтыг 3-р бүлэгтэй хамт хэрэглэхийг улс орны үндсэн хуулийн заалтуудын хүрээнд авч үзэх хэрэгтэй.

**Гуравдугаар зүйл.**  
**Нийцэмжгүй байдлын мэдэгдлийн үр дагавар**

- (1) 2-т заасан нийцэмжгүй байдлын мэдэгдэл нь:
  - (a) түүнд заасан хууль тогтоомжийн заалтын хүчин төгөлдөр байдал, үргэлжлүүлэн үйлчлэх, хэрэглэхэд нөлөөлөхгүй; ба
  - (b) тухайн шүүх ажиллагаанд оролцогч талуудын эрх, үүрэгт нөлөөлөхгүй.
- (2) 2-т заасны дагуу нийцэмжгүй байдлын тухай мэдэгдэл гаргаснаас хойш [120 хоногийн] дотор [мэдэгдэл гаргасан хууль тогтоомжийн заалтын хэрэглэлтэд холбогдох сайд] [эрх бүхий байгууллагад] илтгэж танилцуулна:
  - (a) нийцэмжгүй байдлын тухай мэдэгдлийг [эрх бүхий байгууллагад] танилцуулан анхааралд нь хүргэх; ба
  - (b) нийцэмжгүй байдлын тухай мэдэгдлийн хариуд засгийн газрын авах арга хэмжээнд зөвлөлгөө өгөх.

Тайлбар

Энэ хэсэгт 2-рт зааснаар гарсан нийцэмжгүй байдлын тухай мэдэгдлийн үр дагаврыг тодорхойлсон болно.

(1) заалт нь Их Британийн Хүний эрхийн тухай хуулийн 1998 оны 4 (б) хэсэгт үндэслэсэн болно.

(2) нь Шинэ Зеландын Хүний эрхийн тухай 1993 оны 92К хэсэгт үндэслэсэн болно.

Хэсэг 3 нь Вестминстерийн хэв маягийн парламентын засаглалт уламжлалын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг нийтлэг эрх зүйн тогтолцооны адил нийцэмжгүй байдлын тухай мэдэгдлийн тухай сайдын тайланг танилцуулж болох эрх бүхий байгууллага нь заавал Парламент байх албагүй, тухайн төрийн засаглалын тогтолцоонд тухайн сайдын тайлагнах бүрэн эрх бүхий төрийн нэгж байгууллага байж болно.

**Дөрөвдүгээр зүйл.**  
**Нийцэмжтэй байдлын мэдэгдэл**

- (1) Хуулийн заалтыг санал болгож буй эрх бүхий байгууллага нь санал болгож буй хуулийн заалтын талаар нийцэмжтэй байдлын мэдэгдэл гаргах ёстой.
- (2) [хууль тогтоомжийн төслийг] санаачилж байгаа [хууль тогтоох байгууллагын] гишүүн буюу түүний өмнөөс ажиллаж байгаа өөр этгээд (1)-д дурдсан нийцэмжтэй байдлын мэдэгдлийг үйлдэж [хууль тогтоох эрх бүхий байгууллага]-д батлуулахаар танилцуулна.
- (3) Эрх бүхий байгууллага буюу [хууль тогтоох байгууллага] нь (1)-д заасан нийцэмжтэй байдлын мэдэгдлийг хуулийн заалт батлагдахаас дор хаяж хорин найман хоногийн өмнө олон нийтэд ил болгож, тэр хугацаанд тэдгээрт санал болгож буй хуулийн заалтад тайлбар, санал өгөх боломжийг олгох ёстой.
- (4) (1)-д заасан нийцэмжтэй байдлын мэдэгдэлд дараах зүйлийг тусгасан байх

шаардлагатай. Үүнд:

- (a) [хууль тогтоох байгууллагын] гишүүний эсвэл эрх бүхий хууль санаачлах буюу өөр байгууллагын үзэж байгаагаар [хуулийн төсөл буюу санал болгож буй хууль тогтоомжийн заалт] нь энэ хуулийн Хэсэг II заасан эрхүүдтэй нийцэмжтэй байгаа эсэх; ба
- (b) хэрэв тэдний бодлоор үл нийцэх байдал байгаа бол үл нийцэмжтэй байдлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байна.

#### Тайлбар

Энэхүү хэсэгт хууль тогтоомжийн заалтуудыг батлахаас өмнө болзошгүй Хуулийн Хэсэг II заасан эрхүүдтэй нийцэхгүй зөрчлийг хууль тогтоох байгууллага болон олон нийтийн анхааралд хандуулахыг зорьж буй юм. Хэсэгт 1990 оны Шинэ Зеландын Эрхийн тухай хуулийн 6-р хэсэг гэх мэт үндэсний хүний эрхийн талаархи мөрдөгдөж буй заалтуудад түшиглэсэн болно.

Үндэсний эрх зүй ба олон улсын хүний эрхийн хууль тогтоомжийн зөрчилдөх байдлыг тодорхойлох, зайлсхийх хууль эрх зүйн үр дүнтэй процедуртэй орнуудын хувьд энэхүү заалтууд шаардлагагүй, тохиромжгүй байж болно.

#### **Тавдугаар зүйл.**

##### **Хууль тогтоомжийн нийцтэй байдлыг хяналтанд байлгах**

- (1) Энэ хууль хүчин төгөлдөр болсноос хойш [гурван жилийн] дотор [Хууль зүйн сайд / Ерөнхий прокурор / өөр холбогдох буюу хариуцлагатай сайд] нь үйлчилж буй бүх хууль, хууль тогтоомжийн заалтууд нийцэж байгаа эсэхэд дүгнэлт хийж, уг дүнгээр тайлан илтгэл үйлдэж [хууль тогтоох / эрх бүхий байгууллага]-д хүргэсэн байх ёстой.
- (2) (1)-д заасан илтгэл нь мөрдөгдөж буй хууль тогтоомжийг энэ хуультай нийцэмжтэй болгож баталгаажуулах шаардлагатай нэмэлт, өөрчлөлт, хүчингүй болгох тухай саналуудыг багтаасан байх ёстой.

#### Тайлбар

Энэхүү хэсэг нь энэ Хуулийг хүчин төгөлдөр, бүрэн үйлчилгээтэй болохыг баталгаажуулах үүднээс мөрдөгдөж буй хууль тогтоомжинд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох боломжийг бүрдүүлэх, хуультай нийцэхгүй байгаа асуудлуудыг хууль тогтоох байгууллага ба холбогдох бусад байгууллагын анхааралд хандуулахыг зорьсон юм. Хуулийн төслийг бэлтгэгчид нь энэ Хуулийн зорилго, зориулалт, үр нөлөөг алдагдуулж болзошгүй, нийцэхгүй олон хууль, тогтоомж, дүрэм журам байгаа тул ийм заалтыг зайлшгүй шаардлагатай гэж үзсэн.

Үндэсний эрх зүй ба олон улсын хүний эрхийн хууль тогтоомжийн зөрчилдөх байдлыг тодорхойлох, зайлсхийх хууль эрх зүйн үр дүнтэй процедуртэй орнуудын хувьд энэхүү заалтууд шаардлагагүй, тохиромжгүй байж болно.

**ХАВСРАЛТ: УЛС ОРНЫ ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧИДТАЙ ХОЛБООТОЙ  
ДОТООД ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЖАГСААЛТ**

\* ТББ-уудаас бэлтгэсэн баримт бичиг

<b>ТОВЧ НЭР</b>	<b>БҮТЭН НЭР</b>
Бельгийн санал	Хүний эрх хамгаалагчдыг хамгаалах тухай тогтоолын санал (2012)
Бразилийн хууль *	Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хүний эрхийн тусгай нарийн бичгийн дарга нарын газрын дэргэдэх Хүний эрх хамгаалагчдыг хамгаалах хөтөлбөр (PPHRD) (2009)
Бразилийн тогтоол	Хүний эрх хамгаалагчдыг хамгаалах үндэсний бодлоготой холбоотой 2007 оны 2-р сарын 12-ны өдрийн 6.044 тоот тогтоол
Буркинабын хууль	Буркина Фасо дахь Хүний эрх хамгаалагчдыг хамгаалах тухай хуулийн төсөл (2012)
Колумбын тогтоол *	4065 тоот тогтоол (2011): Үндэсний хамгаалалтын анги байгуулах тухай
Конго улсын хууль	Хүний эрх хамгаалагчдыг хамгаалах тухай хуулийн төсөл (2008)
Конго улсын сайдын тушаал	Хүний эрх хамгаалагчдын хамгаалалтын нэгж байгуулах, зохион байгуулах, ажиллуулах тухай 2011 оны 6-р сарын 13-ны өдрийн 219 / CAB / MIN / J & DN / 2011 тоот тушаал
Гватемалын гэрээ *	Шинжилгээний байгууллагыг байгуулах тухай гэрээ (2008)
Гватемалын каталог *	Хүний эрхийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, хүний эрх хамгаалагчид болон бусад эмзэг бүлгийг хамгаалах арга хэмжээний каталог (2008)
Гватемалын бодлого *	Хүний эрх хамгаалагчид болон бусад эмзэг бүлгийн иргэдийг заналхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах үндэсний бодлого (2009)
Гондурасын хууль	Хүний эрх хамгаалагч, сэтгүүлч, нийгмийн харилцаа холбоо, шударга ёсны үйл ажиллагаа эрхлэгчдийг хамгаалах тухай хууль (2015)
Индонезийн хууль	2011-2014 оны Хүний эрхийг хамгаалах үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөний тухай Индонези улсын Ерөнхийлөгчийн 2011 оны 23 дугаар зарилг
Кот д'Ивуарын хууль	Хүний эрх хамгаалагчдын хамгаалалтыг дэмжих тухай 2014 оны 6-р сарын 20-ны өдрийн n ° 2014-388 хууль
Мексикийн хууль	Хүний эрх хамгаалагч, сэтгүүлчдийг хамгаалах тухай хууль (2012)



Мексикийн журам	Хүний эрх хамгаалагч, сэтгүүлчдийг хамгаалалтыг зохицуулах журам (2012)
Балбын хууль*	Хүний эрх хамгаалагчдын тухай 2066 тоот хуулийн төсөл (2009)
Филиппины хууль	1998 оны НҮБ-ын Хүний эрх хамгаалагчдын тухай тунхаглал буюу Бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих талаар хувь хүн болон нийгмийн бүлэг, байгууллагын эрх үүргийн тухай тунхаглалын хэрэгжилтийг зөрчсөн тохиолдолд шийтгэл ногдуулах, хүний эрх хамгаалагчдын тодорхой эрхийг тусгаж өгсөн Акт (2011)

For more information about our work  
or any of the issues covered in this  
publication, please visit our website: [www.ishr.ch](http://www.ishr.ch)  
or contact us: [information@ishr.ch](mailto:information@ishr.ch)



[www.facebook.com/ISHRGlobal](http://www.facebook.com/ISHRGlobal)



[www.twitter.com/ISHRGlobal](http://www.twitter.com/ISHRGlobal)

#### GENEVA OFFICE

Rue de Varembé 1, 5th floor  
P.O. box 16  
CH-1211 Geneva 20 CIC  
Switzerland

#### NEW YORK OFFICE

777 UN Plaza, 6th floor  
New York, NY 10017  
USA